

МУИС-ийн ХЗС-ийн харьяа
Эдийн засаг, бизнесийн эрх зүйн судалгааны төв

**АРИЛЖААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

Судалгааны баг:

Зөвлөх: Батболдын Амарсанаа /Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн профессор/

Ахлагч: Ганхуягийн Давааням /Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн ахлах багш/

Ахлагч: Батаагийн Нинжин /Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн ахлах багш/

Гишүүн: Дамбын Ганхүрэл /Хууль зүйн ухааны магистр, МУИС-ийн ХЗС-ийн багш/

Гишүүн: Амарбаярын Бодьбилэг /Хууль зүйн ухааны магистр, Судлаач/

Гишүүн: Цэрэнчимэдийн Золбоо /Хууль зүйн ухааны магистр, Судлаач/

Гишүүн: Равданбямбын Оюундэлгэр /Эрх зүйн бакалавр, Судлаач/

АГУУЛГА

УДИРТГАЛ	4
I. АРИЛЖААНЫ ЗАНШИЛ ЭХ СУРВАЛЖ БОЛОХ НЬ.....	5
1.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох.....	5
1.2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох	5
1.3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох.....	6
1.4. Үр дүнг үнэлсэн дүгнэлт	9
II. АРИЛЖААНЫ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧ	9
2.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох.....	10
2.2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох	10
2.3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох.....	11
2.4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал	14
III. АРИЛЖААНЫ БҮРТГЭЛ БОЛОН АРИЛЖААНЫ НЭР	15
3.1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт	15
3.2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал	16
3.3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал.....	21
3.4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал	28
IV. АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТӨЛӨӨЛӨХ БҮРЭН ЭРХ	29
4.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох.....	29
4.2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох.....	29
4.3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох.....	30
4.4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал	38
V. АРИЛЖААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ, ЗУУЧЛАГЧИЙН ЗОХИЦУУЛАЛТ	41
5.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох.....	41
5.2. Хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсгээ тогтоох	42
5.3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөө тооцох	43
5.4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал	47
VI. АРИЛЖААНЫ ХЭЛЦЭЛ	48
6.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох.....	48
6.2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох	49

6.3.	Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох.....	49
6.4.	Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал	59
VII.	АРИЛЖААНЫ ХУУЛЬД ТУСГАВАЛ ЗОХИХ ШИНЭ ГЭРЭЭНИЙ ТӨРЛҮҮД.....	60
7.1.	Шалгуур үзүүлэлтийг сонгох.....	60
7.2.	Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох	60
7.3.	Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох.....	60
7.4.	Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал	65
	ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	70

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 5-ын зорилт 5.2-ын I дэх үе шатны 5-д “Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, хувийн өмчийг хамгаалах эрх зүй, бодлогын орчин бүрдэнэ.” гэж, мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.18-д “Хөрөнгө оруулалт, өмчийн эрхийг хамгаалах, тогтвортой байдлыг хангах бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгож, хувийн өмчийг бүрэн хамгаалсан эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр 22-ны өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 69-д “Бизнес эрхлэгчид хоорондын харилцаанд баримтлах онцлог зарчмыг тусгах, тэдгээрийн байгуулах гэрээ, хэлцлийг Иргэний хуулиас ялгаатай зохицуулах, түүнчлэн цахим хэлбэрээр гэрээ, хэлцэл хийх, арилжааны нэр ашиглах зохицуулалтыг боловсронгуй болгох, гэрээний талуудын итгэлцлийг нэмэгдүүлэх зорилгоор арилжаа эрхлэгчийн зарим мэдээллийг нээлттэй болгох. Хууль тогтоомжоос гадна бизнес эрхлэгчдийн хооронд тогтсон заншлын хэм хэмжээг шүүх илүү өргөн хүрээнд хэрэглэх боломжийг бүрдүүлэх” гэж заасан.

Дээрх үндэслэлийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Арилжааны ерөнхий хуулийн төслийг боловсруулсан байна. Тус хуулийн төсөлд дараах асуудлыг тусгасан байна.

1. Арилжааны эрх зүйн харилцаанд оролцогчийг тодорхойлох.
2. Арилжааны заншлыг эрх зүйн эх сурвалжаар тусгах.
3. Арилжааны нэрийн дотоод эрх зүйн хамгааллыг бүрдүүлэх.
4. Арилжааны бүтцийн болон бүтцийн бус төлөөллийн зохицуулалтыг бэхжүүлэх.
5. Арилжааны хэлцлийн ерөнхий зохицуулалтыг сайжруулах.
6. Арилжааны хэлцлийн тусгай зохицуулалтын системчлэлийг ойлгомжтой болгох.

Уг үнэлгээний саналыг боловсруулахдаа Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралт “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлав. Ийнхүү үнэлэхдээ Арилжааны ерөнхий хуулийн төслийн зохицуулалт, агуулга нь өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилгод нийцэж буй эсэх, зохион байгуулалтыг өөрчилж буй зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, шинээр тусгагдсан зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдсөн эсэх, хуулийн төсөл нь хууль зүйн техникийн хувьд алдаатай эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгсөн болно.

I. АРИЛЖААНЫ ЗАНШИЛ ЭХ СУРВАЛЖ БОЛОХ НЬ

Энэхүү үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баримтлан Арилжааны тухай хуулийн төслийн 5-р зүйл. “Арилжааны хууль тогтоомжийг хэрэглэх”-ийг үнэлэхэд оршино.

Төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааны үе шат:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэлээ.

1.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох

Төслийн 5-р зүйл. “Арилжааны хууль тогтоомжийг хэрэглэх”-ийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо дараах шалгуур үзүүлэлтийг сонгов.

1. Зорилгод хүрэх байдал

Арилжааны хууль тогтоомжийг хэрэглэх заалт нь хуулиар зохицуулаагүй харилцааг арилжааны заншил, талуудын хооронд тогтсон практикийн дагуу зохицуулахаар тусгасан байх ба энэ нь хуулийн хийдлийг нөхөх зорилгоор болон арилжааны харилцаанд оролцогчдийн чөлөөт байдлын зарчмыг үндэслэн талуудын хэрэглэхээр тохиролцсон тохиолдолд ч үйлчлэх юм.

Заншлын хэм хэмжээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгддөг эрх зүйн үндсэн гурван эх сурвалжийн нэг юм. Заншлын хэм хэмжээ хэрэглэх дарааллын хувьд тусгайлсан хуулийн дараа, ерөнхийлсөн хуулийн өмнө байна. Энэ нь худалдаа, арилжааны үйл ажиллагаанд үндэсний хууль тогтоомжийн хийдлийг худалдааны заншил, худалдааны ерөнхий нөхцөлөөр нөхөн тайлбарладагтай шууд холбоотой.¹ Мөн заншлын хэм хэмжээ нь өргөн хүрээний гүйлгээнд хэрэглэхээр боловсруулсан хууль тогтоомжоос илүү тодорхой арилжаанд чиглэгддэг тул хэрэглэх хүчин чадлын хувьд дээгүүр ордог.² Өөрөөр хэлбэл, заншлын хэм хэмжээ нь хуулиас илүү нарийвчилсан зохицуулалт буюу *Lex specialis derogate legi generali*³ болох юм.

1.2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Төслийн 5-р зүйлийн 5.2, 5.3, 5.4-р хэсгийн зохицуулалтуудыг сонгон авав.

¹ Cutler Private Power and Global Authority: Transnational Merchant Law in the Global Political Economy (Cambridge University Press 2003), 208 дахь тал

² Gillette ‘Harmony and stasis in trade usage for international sales’ (1999) 39 Virginia Journal of International Law, 708 дахь тал; мөн Bernstein ‘Merchant law in a modern economy’ (Coase-Sandor Institute for Law and Economics Working Paper No 639, University of Chicago, (2013), 1 дэх тал

³ Нарийвчилсан зохицуулалт бүхий эх сурвалж нь ерөнхий зохицуулалт бүхий эх сурвалжаас илүү хүчин чадалтай гэсэн утга бүхий латинаас гаралтай үг.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгогдсон зүйл, заалт:

5.2.Энэ хуулиар зохицуулаагүй харилцааг арилжааны заншил, талуудын хооронд тогтсон практикийн дагуу, тийм заншил, практик байхгүй, эсхүл талууд түүнийг хэрэглэхгүй талаар хүсэл зоригоо тодорхой илэрхийлсэн тохиолдолд энэ хуулийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.

5.3.Талуудын хооронд тогтсон практик гэж хуульд заавал дагаж мөрдөх шинжтэй хэм хэмжээгээр зохицуулаагүй харилцааны талаар талуудын хэлэлцэн тохиролцсон, хоорондын харилцаандаа тогтоож мөрддөг аливаа дадлыг ойлгоно.

5.4.Талууд харилцан тохиролцсон бол хуульд заавал дагаж мөрдөх шинжтэй хэм хэмжээгээр зохицуулаагүй хоорондын харилцааны талаар олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээ, олон улсын худалдааны практикт хүлээн зөвшөөрөгдсөн загвар гэрээ, түүний тогтсон тайлбарыг харгалзан үзэж болно.

5.5.Арилжааны заншил (ажил хэргийн хүрээнд тогтсон заншил) гэж талууд гэрээ байгуулах үедээ мэдэж байсан, эсхүл мэдэх ёстой байсан тухайн төрлийн гэрээний харилцаанд оролцогчид нийтээр хүлээн зөвшөөрч, тогтмол дагаж мөрддөг бөгөөд хууль болон талуудын гэрээ, хэлцлийн агуулгад харшлаагүй дадлыг ойлгоно.

1.3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох

Арилжааны заншлыг эх сурвалж талаас нь тайлбарлах, үнэлэх

Олон улсын арилжааны эрх зүйд чухал байр эзэлдэг UNCITRAL-н загвар хууль болон түүнд холбогдох арбитрын журамд гэрээний талууд гэрээнд хэрэглэгдэх хуулийг (rule of law) чөлөөтэй сонгохыг зөвшөөрсөн байдаг.⁴ Талууд ийнхүү хэрэглэх хуулиа сонгохдоо олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн заншлын хэм хэмжээ болох *lex mercatoria*-г түгээмэл ашигладаг.⁵ *Lex mercatoria* нь худалдааны эрх зүй гэсэн утгатай, эртний Ромын *jus gentium*-тэй холбогдон үүссэн хэм хэмжээ бөгөөд орчин цагт худалдааны буюу арилжааны зан заншлыг илтгэнэ. *Lex mercatoria* нь олон улсын эрх зүй дэх заншлын хэм хэмжээ бөгөөд талуудын чөлөөт байдлын зарчимд үндэслэн хэрэглэгддэг тул аливаа үндэсний эрх зүйгээс үл хамааран оршин тогтнодог.

Орчин үеийн эрх зүйн эх сурвалжийн онолын дагуу, шууд үгчлэн орчуулбал худалдааны практик⁶ гэгдэх, 'use of trade', 'trade usage', 'usages of trade' зэрэг ойлголт нь *lex mercatoria*-н нэг бүрэлдэхүүн хэсэг болно.⁷ Тиймээс эх сурвалжийн хувьд заншлын хэм хэмжээнд хамаарна.⁸ Худалдааны практикийг үндэсний хууль тогтоомж болон талуудын тохиролцоог үндэслэн хэрэглэдэг.⁹ Ингэхдээ худалдааны практикийг гэрээний 'далд'

⁴ Schmitthoff, Clive M., The New Sources of the Law of International Trade, in Chia-Jui Cheng (ed.), 1988 он, 159 дэх тал

⁵ Michaels, Ralf, the True Lex Mercatoria: Private Law Beyond the State, Indiana Journal of Global Legal Studies, 14 (2007), 448 дэх тал

⁶ Тухайн үеийн эрх зүйн хөгжлийн үүднээс дээрх ойлголтуудыг худалдааны практик хэмээн орчуулдаг ч утгаа зохицуулж буй харилцаа нь арилжааны эрх зүйн харилцаанууд юм.

⁷ HJ Berman and C Kaufman, 'The Law of International Commercial Transactions (Lex Mercatoria)' (1978) 19 Harvard International Law Journal 221, 272–7 дэх тал, мөн Klaus Peter Berger, The Creeping Codification of the New Lex Mercatoria (2nd revised ed., Kluwer Law International 2010).

⁸ Juana Coetzee, The role and function of trade usage in modern international sales law, Unif. L. Rev., Vol. 20, 2015, 270 дахь тал

⁹ Juana Coetzee, The role and function of trade usage in modern international sales law, Unif. L. Rev., Vol. 20, 2015, 244 дэх тал

нөхцөл гэж үзэн гэрээний эсвэл цаашлаад эрх зүйн зохицуулалтын цоорхойг нөхөх, гэрээг тайлбарлах эх сурвалжид тооцдог байна.¹⁰

Английн эрх зүй нь зан заншил (custom)-ыг хуулийн эх сурвалж, худалдааны практик (trade usage)-г гэрээний далд нөхцөл гэж ялгадаг.¹¹ Trade usage нь хуульд нийцсэн байхын зэрэгцээ талууд уг худалдааны практикийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн чанарын талаар нэгдсэн ойлголтыг хүлээн зөвшөөрөх ёстой.¹² 2001 оны Худалдааны нэгдсэн хуулийн (UCC) 1-303(с) хэсэгт “Худалдааны практик гэдэг нь холбогдох гэрээ, хэлцлийн хувьд ажиглагдаж болохуйц хүлээлтийг зөвтгөж буй тодорхой газар, ажил мэргэжлийн хүрээ болон худалдаанд тогтмол ажиглагдаж, илэрч байдаг аливаа харилцаа, хэлцлийн арга хэлбэр эсхүл хэвшсэн үйл ажиллагаа” хэмээн тодорхойлсон байна.¹³ Харин иргэний эрх зүйн улс орнууд гол төлөв худалдааны практикийг гэрээг тайлбарлах хэрэгсэл эсвэл гэрээний далд нөхцөл болгон авч үздэг.¹⁴ Үүнээс үзвэл, улс орон бүр “trade usage”-г эрх зүйн эх сурвалж хэмээн тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрдөг байна.

Төслийн 5-р зүйлийн зохицуулалт нь олон улсын заншлын хэм хэмжээ болон талуудын хооронд тогтосон арилжааны практикийн (дадал) ойлголт, хэрэглээний онцлогтой нийцэж байна.

Олон улсын эрх зүй талаас үнэлэх шаардлагатай зүйл байгаа эсэх

Олон улсын бараа худалдах, худалдан авах гэрээний тухай 1980 оны Венийн конвенц (CISG) болон UNIDROIT-ийн олон улсын худалдааны гэрээний зарчмууд (UNIDROIT PICC) нь талуудын хэрэглэхээр сонгосон эрх зүйд арилжааны заншлын хэм хэмжээг мөн хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн шүүхийн практикт CISG-ийн 9(2)-д заасны дагуу INCOTERMS болон UNIDROIT-ийн гэрээний зарчмууд нь олон улсын худалдаа, арилжааны практикийг бүрдүүлнэ гэж үзжээ.¹⁵ Цаашлаад, 7(2)-р зүйлд талуудын бие даасан байдал ба гэрээний чөлөөт байдлын үндсэн дээр худалдааны практикийг гэрээний “дотоод цоорхой (internal gaps)”-г нөхөн тайлбарлахад ашиглаж болдог байна. Мөн CISG-ийн 9(2)-д заасны дагуу худалдаа, арилжааны практикийг “талууд мэдэж байсан эсвэл мэдэх ёстой байсан олон улсын худалдааны гэрээний талууд өргөнөөр мэддэг, байнга дагаж мөрддөг хэм хэмжээ” хэмээн тодорхойлдог. Энэ нь төслийн 5.5-д тусгагдсан байна.

Арилжааны эрх зүйн эх сурвалж, түүнийг хэрэглэхдээ эхлээд талуудын хооронд байгуулсан гэрээ, үүний дараа тэдний хооронд тогтсон худалдааны практик, олон улсын гэрээ, конвенц, нарийвчилсан үндэсний хууль тогтоомж гэх дарааллаар хэрэглэж байна. Худалдааны практик нь хэрэглэх дарааллаараа материаллаг хуулиас дээгүүрт ордог¹⁶ бөгөөд энэ нь арилжааны этгээд өөрөө өөрийгөө зохицуулах нэг арга хэлбэр болж хөгжсөний илрэл байна. Тиймээс олон улсын эрх зүйн түвшинд худалдааны практикийг заншлын хэм хэмжээ болохын хувьд эрх зүйн эх сурвалж хэмээн үнэлж, өргөн хүрээнд ашиглаж байна.

¹⁰ Мөн тэнд, 268 дахь тал

¹¹ Halsbury's Laws of England, vol 32 (5th edn, Lexis Nexis 2012), para 51.

¹² Roy Goode, Goode on Commercial Law, edited by Ewan McKendrick (4th revised edn, Penguin Books 2010), 14, 97 дахь тал ; мөн Halsbury's Laws of England, vol 32 (5th edn, Lexis Nexis 2012), paras 50, 56–61.

¹³ 2001 оны Худалдааны нэгдсэн хууль (UCC)

¹⁴ Jurgen Basedow, 'The State's Private Law and the Economy: Commercial Law as an Amalgam of Public and Private Rule-Making' (2008), American Journal of Comparative Law, 706 for the position in French and German laws

¹⁵ Мөн тэнд, 89 дэх тал. See further, Higher Cantonal Court du Valais (Fiberglass composite materials case), Switzerland 28 January 2009; Marc Rich & Co v Iritechna SpA Appellate Court Geneva, Italy 24 March 1995; St Paul Guardian Insurance Co v Neuromed Medical Systems & Support 2002 WL 465312 (SDNY 2002) US Federal District Court, New York 26 March 2002, CLOUT case no 447.

¹⁶ Juana Coetzee, TRADE USAGE: Still law made by merchants for merchants?, 2016, 108 дахь тал

Арилжааны зан заншил буюу trade usage, trade custom, trade practice

Олон улсын бараа худалдах худалдан авах гэрээний тухай НҮБ-ын конвенц¹⁷-ын 9 дүгээр зүйл болон Европын нийтлэг худалдааны хууль¹⁸-ийн 67 дугаар зүйлд¹⁹ заншил (trade usage) болон дадал (practice)²⁰-ыг ялгаатай байдлаар авч үзсэн. Заншилд (trade usage) тодорхой бүлэг эсвэл ангилалд хамаарах бизнес эрхлэгчдийн тогтсон байдлаар хүлээн зөвшөөрдөг бизнесийн үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан өргөн хүрээний ойлголтыг хамруулдаг.²¹ Нөгөөтээгүүр, арилжааны практикийн (practice) тухай ойлголт нь илүү явцуу бөгөөд мөн чанартаа хэд хэдэн хэлцэлд оролцож буй талуудын хооронд тогтсон тодорхой зан үйлтэй холбоотой юм.²²

Заншил (trade usage). CISG-д “заншил”-ыг тодорхойлоогүй. Иймд заншлыг CISG-ийн авч үздэг бусад олон ойлголтын нэгэн адил бие даасан, үндэсний эрх зүйн тодорхой үзэл баримтлал, ойлголт зэрэг тодорхой эх сурвалжийг ишлэлгүйгээр тайлбарлахыг шаарддаг.²³ Жишээ нь, Итали улсын хууль тогтоомжийн дагуу заншилд тооцогдохын тулд талууд тус заншил нь заавал дагаж мөрдөгдөх эрх зүйн хүчинтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн байх ёстой гэж үздэг. Гэвч энэ нь CISG-ийн дагуу заншлыг тодорхойлоход хамааралгүй юм. Учир нь талууд хэдийгээр тус заншил нь заавал дагаж мөрдөх хүчинтэй биш гэдгийг мэдэж байсан ч тус заншлыг дагаж мөрдөхийг зөвшөөрч болно. CISG-ийн 9 дүгээр зүйлийн (1)-ийн дагуу талууд зөвхөн өөрсдийн чөлөөт байдлын зарчмын хүрээнд хүлээн зөвшөөрсөн заншлаа дагаж мөрдөх үүрэгтэй. Гэхдээ энэхүү зөвшөөрөл нь шууд болон шууд бус хэлбэрээр хийгдсэн байж болно.

Талууд өөрсдийн хэлцэлд заншил хэрэглэхээр талуудын чөлөөт байдлын зарчмын дагуу тохиролцсон тохиолдолд үүнд олон улсын заншлаас гадна орон нутгийн болон бүс нутгийн заншлууд багтана. Жишээ нь, INCOTERMS нь худалдааны заншлын эх сурвалж юм. Жишгийн эрх зүй баталсны дагуу заншил нь CISG конвенцын заалтуудаас давуу хүчинтэй үйлчилнэ.²⁴ Иймд тухайн заншлыг ашиглах боломжтой, талуудын сонголт нь холбогдох үндэсний хууль тогтоомжийн дагуу хүчинтэй гэрээ мөн болох нь тогтоогдсон бол заншил нь CISG-ийн заалтаас давуу үйлчилнэ.

Арилжааны практик (practice). Ердийн нийтлэг шинж бүхий заншлаас ялгаатай нь арилжааны практик нь талуудын хийсэн бизнесийн харилцаа, хэлцлээс үүдэлтэй тодорхой зан үйлийн үр дүн байдаг тул заншлаас (trade usage) илүү явцуу хүрээнд тодорхойлогддог. Тухайн бизнесийн салбарт хэрэглэгдэх нийтлэг арилжааны зан үйл гэхээсээ илүүтэй талуудын тогтоосон хувийн бизнесийн зан үйл нь арилжааны практикийг тодорхойлох чухал хүчин зүйл юм. Гэвч энэ нь бизнесийн харилцаа тодорхой хугацааны туршид үргэлжилсэн бөгөөд тухайн практикийг бий болгох тодорхой зан үйл (хэлцэл зэрэг) нь хэд хэдэн удаагийн давтамжтай байхыг шаардана. Өөрөөр хэлбэл, практик нь давтамжид суурилсан байх юм.

¹⁷ United Nations Convention on Contracts for the International Sale of Goods (CISG)

¹⁸ Common European Sales Law

¹⁹ Mak, Vanessa. “According to Custom...? The Role of 'Trade Usage' in the Proposed Common European Sales Law (CESL)”, 2013. *Tilburg Law School Legal Studies Research Paper* No. 02/2014, TISCO Working Paper Series on Civil Law and Conflict Resolution Systems No. 001/2013, Available at SSRN: <https://ssrn.com/abstract=2364427> or <http://dx.doi.org/10.2139/ssrn.2364427>. Accessed 2024.06.13.

²⁰ Э.Байгал “usage” гэдгийг “заншил”, “practice” гэдгийг “дадал” гэж орчуулсан. Олон улсын эрх хувийн эрх зүй (баримт бичгийн эмхэтгэл), 2023, 74 дэх тал.

²¹ Graffi, L. “Remarks on Trade Usages And Business Practices In International Sales Law”. *Journal of Law and Commerce*, vol. 29, no. 2, May 2011, p. 275. doi:10.5195/jlc.2011.18. Accessed 2024.06.13.

²² Graffi, L, p. 278.

²³ Мөн тэнд, p. 276.

²⁴ Oberster Gerichtshof [Supreme Court] Austria, 21 Mar. 2000, t <http://www.cisg.law.pace.edu/cases/000321a3.html>; Landgericht Saarbrücken [District Court] Germany, 13 Jan. 1992, <http://www.cisg.law.pace.edu/cases/920323g1.html>.

Хэдийгээр CISG-д хэлцэл давтамжийг зохицуулаагүй боловч талууд хоёроос дээш гэрээ байгуулснаар арилжааны практикийг бий болгох боломжтойг шүүхийн практикт онцлон тэмдэглэсэн.²⁵

Талуудын хооронд бий болсон арилжааны практик болон CISG-ийн аливаа зөрчилтэй заалтууд хоорондын харилцааны тухайд уг практик нь конвенцын заалтаас давамгайл хүчинтэй үйлчилнэ гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн, талуудын хэрэглэхээр зөвшөөрсөн заншил (trade usage) нь талуудын тогтсон практикаас (practice) зөрвөл хэрэглэхээр зөвшөөрсөн заншил давамгайл үйлчилнэ гэж үздэг. Гэвч зарим судлаачид үүнтэй санал зөрдөг ба арилжааны практик нь талуудын бие даасан байдал, бодит хүсэл зоригийн жинхэнэ илэрхийлэл байх хандлагатай байдаг бол заншил нь ихэвчлэн тодорхой бизнесийн салбар дахь талуудын мэддэг боловч бүрэн дагаж мөрдөх хүсэлгүй зан үйлийн ерөнхий багцаас бүрддэг гэжээ.²⁶

Цаашлаад, зарим судлаачид арилжааны заншлын (commercial customs) хоёр төрлийг ялгахыг зорьдог. Худалдааны заншил (trade customs) гэдэг нь шүүхээс хүлээн зөвшөөрсөн заншил, харин “usage” гэдэгт шүүхээс ийнхүү хүлээн зөвшөөрөөгүй заншлыг хэлнэ гэжээ. Зарим нь заншил (trade customs) гэдэг нь тухайн бүс нутгийн дүрэм, харин “usage” гэдгийг худалдаа буюу мэргэжлийн тогтсон зан үйл гэж тодорхойлдог. Гэрээний хуулийг нэгдмэл болгоход чиглэсэн баримт бичгүүдэд ихэвчлэн “usage” нэршлийг ашигладаг.²⁷

1.4. Үр дүнг үнэлсэн дүгнэлт

Төслийн 5-р зүйл нь арилжааны зан заншил, талуудын хооронд тогтсон дадал буюу арилжааны практикийг хуулийн зохицуулаагүй харилцаанд ашиглах талаар тусгасан ба энэ нь олон улсын зохицуулалтад нийцэж байх учиртай. Ингэхдээ тусгайлсан хуулийн зохицуулалтад багтаагүй харилцаа гэдгийг тодотгох шаардлагатай ба 5-р зүйлийн 5.1-д тусгалаа олсон байна. Энэхүү хүрээнд, төслийн заалт нь олон улсын жишиг болон хуулийн зорилгыг хангаж байгаа бөгөөд зохицуулалтын зорилтыг бүрэн хангах боломжтой байна.

Арилжааны зан заншил, арилжааны талуудын хооронд тогтсон практикийн тодорхойлолт, хэрэглээ нь олон улсын жишиг болох CISG, UNIDROIT PICC, INCOTERMS зэргийн шалгуурт бүрэн нийцэж байгаа бөгөөд хуулийн төслийн зорилгод хүрэх шалгуурыг хангаж байна гэж үзлээ.

II. АРИЛЖААНЫ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧ

Энэхүү үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баримтлан Арилжааны тухай хуулийн төслийн Хоёрдугаар бүлэг. Арилжааны эрх зүйн харилцаанд оролцогчийг боловсронгуй болгоход чиглэнэ.

Төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;

²⁵ Zivilgericht Basel [Civil Court] Switzerland, 3 Dec. 1997, <http://www.cisg.law.pace.edu/cases/971203s2.html>; Amtsgericht Duisburg [Petty Court] Germany, 13 Apr. 2000, <http://cisgw3.law.pace.edu/cases/000413g1.html>

²⁶ Graffi, L, p. 280.

²⁷ Miklos, Kiraly. “The Unification of Contract Law and Commercial Usages”. *TCLR*, Issue 2, 2022, p. 4. <https://www.gmul.ac.uk/unidroit-itcl/media/ccls/docs/research/tclr-2-the-unification-of-contract-law-and-commercial-usages.pdf>. Accessed 2024.06.13.

- Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэлээ.

2.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох

Төслийн Хоёрдугаар бүлэг. Арилжааны эрх зүйн харилцаанд оролцогчийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо дараах шалгуур үзүүлэлтийг сонгов.

2. Зорилгод хүрэх байдал

Арилжааны хуулийн зохицуулалтын агуулга нь нийгэм, эдийн засгийн өдөр тутмын амьдралд тохиолдох аливаа арилжааны үйл ажиллагаа болон үзэгдэл билээ. Улмаар, арилжааны хууль хэмээх бичмэл хууль нь энэхүү арилжааны үйл ажиллагаа болон үзэгдлийг оновчтой зохицуулахын сацуу үйлчлэх хүрээгээ тодорхой болгох зайлшгүй шаардлагатай. Хэдий энэхүү арилжааны үйл ажиллагаа болон үзэгдэл хэмээх нийгмийн бодит фактыг нэг мөр, нэгдсэн байдлаар томъёолох боломжгүй ч эдгээрийн агуулгыг аль болох оновчтойгоор тусгасан тодорхой шалгуурын тусламжтайгаар арилжааны хуулийн бүтэц болон зохицуулалтын агуулга, хүрээг тодорхой болгох боломжтой. Улс орнууд арилжаа эрхлэгчийн ойлголтод суурилсан субъектын шалгуур эсхүл арилжааны хэлцлийн ойлголтод суурилсан объектын шалгуурын аль нэгэнд тулгуурлан арилжааны хуулийн зохицуулалтын агуулга, хүрээг тогтоож өгдөг.

Манай Улсын хувьд арилжааны үйл ажиллагаа болон үзэгдлийг Иргэний суурь хуулиар зохицуулсаар ирсэн нь зохимжгүй болохыг холбогдох судалгаанууд цохон тэмдэглэсээр ирсэн. Улмаар, субъектын шалгуурт тулгуурласан арилжааны бие даасан хуулийг боловсруулах нь хамгийн оновчтой арга зам гэж үзсэн бөгөөд энэ хүрээнд төслийн Хоёрдугаар бүлэг субъектын шалгуур болох арилжаа эрхлэгч гэдэгт хэнийг ойлгох вэ гэдэгт тодорхой хариултуудыг өгчээ.

Иймд дээр дурдсаны дагуу субъектын шалгуур нь арилжааны үйл ажиллагаа болон үзэгдлийг оновчтой зохицуулах зорилгод хүрч буй эсэхийг гадаадын зарим улс орнуудын арилжааны хуультай харьцуулан авч үзэх нь зохилтой. Арилжааны үйл ажиллагаа болон үзэгдлийг оновчтой зохицуулах гэдэг нь эдийн засгийн утгаар нэгдүгээрт талууд тохиролцоо хийхэд санаа авч болохуйц зохицуулалтыг хуульд тусгах замаар тохиролцооны зардлыг бууруулах, хоёрдугаарт тухайн зохицуулалт нь талууд хамгийн сайнаар хэлэлцэн зөвшилцсөний үр дүнд бий болох тохиролцооны агуулгатай ижил байх хэмээх 2 агуулгыг илэрхийлнэ. Үүнийг өргөн утгаар нь тохиролцоонд хүрэх зардал (transaction cost) гэх бөгөөд арилжааны үйл ажиллагаа болон үзэгдлийг оновчтой зохицуулах нь тохиролцоонд хүрэх зардлыг бууруулах томоохон ач холбогдолтой гэж дүгнэж болох юм.²⁸

2.2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах зохицуулалтуудыг сонгон авав.

Хүснэгт №1. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгогдсон зүйл, заалт

	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Арилжааны үйл ажиллагааг оновчтой зохицуулах	6 дугаар зүйлийн 6.1,6.2

²⁸ Ian Ayres & Robert Gertner, *Filling Gaps in Incomplete Contracts: An Economic Theory of Default Rules*, 99 Yale L. J. 87, 87-94 (1989); R. H. Coase, *The Problem of Social Cost*, 3 J. L. & Econ 1 (1960).

2	Арилжаа эрхлэгчийг төрөлжүүлэх	6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 8 дугаар зүйлийн 8.1
---	--------------------------------	--

2.3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох

“Арилжааны үйл ажиллагааг оновчтой зохицуулах” зорилтын хувьд

6 дугаар зүйл.Арилжаа эрхлэгч

6.1.Арилжааны үйл ажиллагааг өөрийн нэрийн өмнөөс эрхэлдэг хувь хүн болон хуулийн этгээд нь арилжаа эрхлэгч байна.

6.2.Арилжааны үйл ажиллагаа нь ашиг олох зорилгоор байнга эрхлэх, бие даасан, гадагш чиглэсэн, хуулиар хориглоогүй аж ахуйн аливаа үйл ажиллагаа байна.

Арилжааны үйл ажиллагаа болон үзэгдэл нь нийгмийн амьдралын өнцөг булан бүрийг хамрах, хязгааргүй олон төрөлтэй, хувьсан өөрчлөгдөх шинжтэй тул арилжааны хуулийн зохицуулалтын хүрээг аль болох уян хатан байдлаар тогтоож өгөх шаардлагатай. Нөгөө талаар иргэний хуулийн тусгай хууль болохын хувьд хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлохгүйгээр арилжааны хуулийг хэрэглэх боломжгүй. Энэ 2 хэрэгцээ шаардлагыг субъектын шалгуур болон объектын шалгуурыг хослуулан тэнцвэржүүлдэг. Гэхдээ, субъектын шалгуур нь объектын шалгууртай харьцуулахад илүү уян хатан, нийгмийн хэрэгцээ шаардлагыг дагаад өөрчлөгдөх боломжтой гэж үздэг тул сүүлийн үеийн чиг хандлагад субъектын шалгуурыг илүүд үзэх болжээ. Чингэхдээ ХБНГУ-ын арилжааны хууль нь (HGB) субъектын шалгуурын жишиг хууль болж өгдөг байна.


ХБНГУ-ын арилжааны хууль (HGB)-ийн 1.1 дүгээр зүйлд “Энэ хуульд тусгагдсан арилжаа эрхлэгч гэдэг нь арилжааны үйл ажиллагааг эрхэлдэг хүнийг хэлнэ” гэж тусгаад, 1.2 дугаар зүйлд арилжааны үйл ажиллагаа нь бүхий л бизнес, аж ахуйн үйл ажиллагааг хамрах агуулгыг тусгаж өгчээ. Үүнээс арилжаа эрхлэгчийн ойлголт нь угтаа арилжааны үйл ажиллагаагаар тодорхойлогдож буйг харж болно. Хэдий арилжааны үйл ажиллагаа нь хийсвэр, өргөн хүрээтэй, уян хатан шинжтэй ойлголт мэт боловч ХБНГУ-ын арилжааны эрх зүйн туршлагын хүрээнд нэгэнт тогтсон ойлголт юм. Тухайлбал, арилжааны үйл ажиллагааг тодорхойлоход чиглэсэн төрөл бүрийн шалгуурууд байдгаас гадагш чиглэсэн, ашиг олох зорилготой, байнга эрхлэх гэсэн 3 шалгуур нь арилжааны үйл ажиллагааг тодорхойлох гол шалгуурууд болж өгдөг байна. Улмаар, ХБНГУ-ын арилжааны хуулийн 343 дугаар зүйлд “Арилжааны хэлцэл гэдэг нь арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаатай холбогдуулан хийж буй бүхий л хэлцлийг хэлнэ” гэж хуульчилжээ.

Япон Улсын арилжааны хууль (商法) объектын шалгуурт суурилсан холимог шалгуурыг баримталсан гэж үздэг. Япон Улсын арилжааны хуулийн 1.1 дүгээр зүйлд “Арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаа, арилжааны хэлцэл бусад арилжааны асуудлыг бусад хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулиар зохицуулна” гэж хуульчилсан. Үүнээс үзвэл, субъектын шалгуураас ялгаагүй мэт боловч тус хуулийн 4.1 дүгээр зүйлд “Энэ хуульд тусгагдсан арилжаа эрхлэгч гэдэг нь өөрийн нэрийн өмнөөс арилжааны хэлцэл хийх үйл ажиллагааг эрхэлдэг этгээдийг хэлнэ” гэж тодорхойлсон нь арилжааны хэлцэл нь арилжаа эрхлэгчээс салшгүй ойлголт болохыг харуулна. Тус зүйлийн “арилжааны хэлцэл”-ийг 501 болон 502 дугаар жагсаан хуульчилсан.

Бүдүүвч №1. ХБНГУ-ын арилжааны хуулийн субъектын шалгуур



Бүдүүвч №2. Япон Улсын арилжааны хуулийн объектын шалгуур (холимог шалгуур)



Дээрх бүдүүвчүүдээс харж байгаачлан субъектын шалгуур болон объектын шалгуур аль аль нь бусад ойлголтуудтай нарийн уялдаа холбоотой. Мөн ямар ч шалгуур баримталсан тулах цэг зайлшгүй шаардлагатай болох бөгөөд субъектын шалгуурын хувьд энэ нь тодорхой шалгуурт суурилсан арилжааны үйл ажиллагаа хэмээх ойлголт бол объектын шалгуурын хувьд энэ нь хуульд хязгаартайгаар жагсаан хуульчилсан арилжааны хэлцлийн ойлголт юм. Объектын шалгуур нь нэгэнт хязгаартайгаар жагсаан хуульчлагдсан тул нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэхийн тулд буцаад арилжаа эрхлэгчийн ойлголтоос тусламж авахаас өөр аргагүйд хүрдэг. Хууль хэрэглээний нэгдмэл, тодорхой байдлын үүднээс объектын шалгуур давуу талтай байхыг үгүйсгэхгүй ч түүний хэт хязгаарлагдмал байдал нь арилжааны үйл ажиллагааг оновчтой зохицуулах зорилтод нийцэхгүй.

Субъектын шалгуур болон объектын шалгуурыг хуулийн нарийвчлалын үүднээс нэг шугамд харсан тохиолдолд субъектын шалгуур нь зарчмын шинжтэй хэм хэмжээ бол, объектын шалгуур нь дүрмийн шинжтэй хэм хэмжээнд хамаарна.²⁹ Арилжаа эрхлэгчид өөрсдийн үйлдлийн үр дагаврыг урьдчилан тооцоолох, шүүхээс хуулийг нэг мөр хэрэглэх зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзвэл дүрмийн шинжтэй объектын шалгуурын нийгмийн зардал харьцангуй бага. Гэтэл, арилжааны үйл ажиллагааны олон талт байдал, хурдацтай хувьсан өөрчлөлтийг харгалзан үзвэл объектын шалгуур зохимжгүй. Өөрөөр хэлбэл, арилжааны үйл ажиллагааг оновчтой зохицуулна гэдэг нь хуулийн оновчтой нарийвчлалыг сонгох явдал бөгөөд арилжааны үйл ажиллагааны олон талт байдал, хурдацтай хувьсан өөрчлөлт зэрэг хүчин зүйлсээс шалтгаалаад нарийвчлал багатай субъектын шалгуур нь оновчтой байна гэж үзэж болохоор байна.³⁰

²⁹ Louis Kaplow, Rules Versus Standards: An Economic Analysis, 42 Duke L. J. 557, 558-568 (1992).

³⁰ Vincy Fon & Francesco Parisi, On the Optimal Specificity of Legal Rules, 4 (32) George Mason Uni L. & Econ. 10 (2007) нь нийгмийн зардал багатай, оновчтой хэм хэмжээний нарийвчлалыг “Our model shows that if we expect

Төслийн 6 дугаар 6.1 “Арилжааны үйл ажиллагааг өөрийн нэрийн өмнөөс эрхэлдэг хувь хүн болон хуулийн этгээд нь арилжаа эрхлэгч байна” гээд, 6 дугаар зүйлийн 6.2 “Арилжааны үйл ажиллагаа нь ашиг олох зорилгоор байнга эрхлэх, бие даасан, гадагш чиглэсэн, хуулиар хориглоогүй аж ахуйн аливаа үйл ажиллагаа байна” гэж тусгаж субъектын шалгуурыг баримталжээ. Ингэхдээ арилжааны үйл ажиллагааг тодорхойлох шалгуурыг өргөжүүлж бие даасан, хуулиар хориглоогүй гэсэн шалгууруудыг нэмэх замаар арилжааны үйл ажиллагааг нарийвчилжээ. Дээр дурдсанчлан уян хатан субъектын шалгуур нь арилжааны үйл ажиллагааг оновчтой зохицуулах зорилтыг хангахад түлхүү нийцэж болохыг тайлбарласан тул төслийн “арилжааны үйл ажиллагааг оновчтой зохицуулах” зорилтод нийцэж байна гэж дүгнэж болно.

“Арилжаа эрхлэгчийг төрөлжүүлэх” зорилтын хувьд

6 дугаар зүйл.Арилжаа эрхлэгч

6.1.Арилжааны үйл ажиллагааг өөрийн нэрийн өмнөөс эрхэлдэг хувь хүн болон хуулийн этгээд нь арилжаа эрхлэгч байна.

6.2.Арилжааны үйл ажиллагаа нь ашиг олох зорилгоор байнга эрхлэх, бие даасан, гадагш чиглэсэн, хуулиар хориглоогүй аж ахуйн аливаа үйл ажиллагаа байна.

6.3. Хуулийн этгээд нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд компани, нөхөрлөл хэлбэрээр бүртгүүлж байгуулагдсанаар арилжаа эрхлэгч болно.

7 дугаар зүйл.Арилжааны бүртгэлд сайн дураар бүртгүүлснээр арилжаа эрхлэгч болох этгээд

7.1.Энэ хуулийн 6.2-т заасан шинжийг хангаагүй үйл ажиллагаа эрхлэгч хувь хүн нь энэ хуульд заасан арилжааны бүртгэлд сайн дураар бүртгүүлж арилжаа эрхлэгч болж болно.

7.2.Мал аж ахуй, газар тариалан, хүлэмжийн аж ахуй зэрэг хөдөө аж ахуйн болон ойн аж ахуйн буюу анхдагч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхэлж байгаа хувь хүн нь энэ хуульд заасан арилжаа эрхлэгчид хамаарахгүй.

7.3.Энэ хуулийн 7.2-т заасан үйл ажиллагаа эрхэлдэг этгээд сайн дураараа арилжааны бүртгэлд бүртгүүлснээр арилжаа эрхлэгч болж болно.

8 дугаар зүйл.Жижиг арилжаа эрхлэгч

8.1.Хувиараа арилжаа эрхлэгчийн өмнөх санхүүгийн жилийн балансад тусгагдсан нийт хөрөнгийн хэмжээ, эсхүл арилжааны үйл ажиллагаагаа явуулж эхлээд нэг санхүүгийн жил өнгөрөөгүй байгаа тохиолдолд арилжааны үйл ажиллагаагаа явуулж эхлэх үеийн балансад тусгагдсан нийт хөрөнгийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнээс доогуур байвал түүнийг жижиг арилжаа эрхлэгч гэж үзнэ.

ХБНГУ-ын арилжааны хууль (HGB)-ийн 1.1 дүгээр зүйлд тусгагдсан арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийг “жинхэнэ арилжаа эрхлэгч” буюу *istkaufmann* гэж нэрлэдэг. Тиймээс, “жинхэнэ арилжаа эрхлэгч” нь арилжааны үйл ажиллагааг эрхэлдэг этгээд мөн. Үүнээс гадна, “сайн дурын арилжаа эрхлэгч” буюу *kanpkaufmann* гэж бий. “Сайн дурын арилжаа эрхлэгч” нь дараах хоёр төрөлтэй. Нэгдүгээрт, жижиг арилжаа эрхлэгч нь тус хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу арилжааны бүртгэлд бүртгүүлснээр арилжаа эрхлэгчид тооцогдоно. Хоёрдугаарт, анхдагч үйлдвэрлэл эрхэлдэг этгээд нь зарчмын хувьд арилжаа эрхлэгч биш боловч арилжааны зохион байгуулалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж арилжааны бүртгэлд бүртгүүлснээр арилжаа эрхлэгчид тооцогдоно. Мөн компани,

volatility in the environment and consequent obsolescence in legal order, lower levels of specificity should be chosen” гэж дүгнэжээ.

нөхөрлөл зэрэг ашгийн төлөө хуулийн этгээдүүд нь угаас арилжаа эрхлэгчид тооцогдох нь ойлгомжтой.

Япон Улсын арилжааны хууль (商法)-ийн 4.1 дүгээр зүйлд “жинхэнэ арилжаа эрхлэгч” буюу 固有商人-г тусгасан. Жинхэнэ арилжаа эрхлэгч нь өөрийн нэрийн өмнөөс арилжааны хэлцэл хийх үйл ажиллагааг эрхэлдэг этгээд мөн. Өөрийн нэрийн өмнөөс гэдэг нь өөрийн үйл ажиллагаанаас үүссэн аливаа эрх, үүргийг өөрөө хариуцах агуулгыг илэрхийлнэ. Арилжааны хэлцэл гэдэг нь 501 болон 502 дугаар зүйлд тусгагдсан “үндсэн арилжааны хэлцэл” (絶対的商行為) болон “аж ахуйн арилжааны хэлцэл” (營業的商行為)-г хэлнэ. Үйл ажиллагааг явуулах гэдэг нь ашиг олох зорилгоор тухайн хэлцлийг төлөвлөлтийн үндсэн дээр байнга хийхийг хэлнэ. “Жинхэнэ арилжаа эрхлэгч”-ээс гадна “зохиомол арилжаа эрхлэгч” (擬制商人) гэж бий. Зохиомол арилжаа эрхлэгч нь дараах хоёр төрөлтэй. Нэгдүгээрт, дэлгүүр түүнтэй төстэй дэд бүтцээр дамжуулан бараа бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагаа эрхэлдэг этгээд нь зохиомол арилжаа эрхлэгчид хамаарна. Анхдагч үйлдвэрлэл болох өөрийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, газар тариалангийн бүтээгдэхүүн, мал аж ахуйн бүтээгдэхүүн зэргийг дэлгүүрээр дамжуулан худалдан борлуулдаг этгээдийг зохиомол арилжаа эрхлэгч гэж үзнэ. Хоёрдугаарт, уул уурхай нь их хэмжээний хөрөнгө оруулалт, дэд бүтцийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг тул уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийг зохиомол арилжаа эрхлэгчид тооцдог. Цаашилбал, жижиг арилжаа эрхлэгч (小商人) гэж бий. Арилжааны үйл ажиллагаанд ашиглах хөрөнгө нь засгийн газраас тогтоосон хэмжээнээс доогуур этгээдийг жижиг арилжаа эрхлэгч гэж үзнэ. Түүнчлэн, ашгийн төлөө хуулийн этгээд болох компани, нөхөрлөл зэрэг нь арилжаа эрхлэгч мөн.

ХБНГУ болон Япон Улсын арилжааны хуульд 1) Жинхэнэ арилжаа эрхлэгч 2) Сайн дурын арилжаа эрхлэгч 3) Арилжаа эрхлэгч хуулийн этгээд гэсэн арилжаа эрхлэгчийн үндсэн гурван төрлийг тусгаж өгдөг байна. Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 нь жинхэнэ арилжаа эрхлэгчийг “Арилжааны үйл ажиллагааг өөрийн нэрийн өмнөөс эрхэлдэг хувь хүн болон хуулийн этгээд нь арилжаа эрхлэгч байна” гэж тусгажээ. Түүнчлэн, арилжаа эрхлэгчийн шинжийг хангаагүй этгээд ч арилжаа эрхлэгчээр бүртгүүлэх боломжийг төслийн 7 дугаар зүйлийн 7.1-д уян хатан байдлаар тусгаж, сайн дурын арилжаа эрхлэгчийн үндсэн төрөл болох анхдагч үйлдвэрлэл эрхэлдэг этгээдүүдийн арилжаа эрхлэгчид тооцогдож болохыг 7 дугаар зүйлийн 7.2-д тусгаж өгчээ. Хуулийн этгээдийн хувьд шууд арилжаа эрхлэгчид тооцогдох агуулгыг 6 дугаар зүйлийн 6.3-д тусгасан байна. Иймд төслийн холбогдох зохицуулалтууд нь арилжаа эрхлэгчийг төрөлжүүлэх зорилтдоо хүрч байна гэж үзэж байна.

2.4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

Дүгнэлт

Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 нь субъектын шалгуурын үндсэн зохицуулалт мөн. Улмаар, субъектын шалгуур нь субстантив арилжааны хууль буюу арилжааны үйл ажиллагааг оновчтой зохицуулах зорилтод нийцэж байх учиртай. Энэ хүрээнд субъектын шалгуур нь арилжааны үйл ажиллагааны олон талт байдал, хурдацтай хувьсан өөрчлөлтөд дасан зохицох чадвартай нийгмийн зардал хамгийн бага сонголт мөн. Иймд, арилжааны үйл ажиллагааг оновчтой зохицуулах зорилтыг хангах бүрэн боломжтой байна.

Цаашилбал, ХБНГУ болон Япон Улсын арилжааны хуулиас харж байгаачлан арилжааны хууль нь арилжаа эрхлэгчийг төрөлжүүлэх зайлшгүй шаардлагатай. Энэ хүрээнд төслийн хоёрдугаар бүлэг 1) Жинхэнэ арилжаа эрхлэгч 2) Сайн дурын арилжаа эрхлэгч 3) Хуулийн этгээдийн арилжаа эрхлэгчийн төрлүүдийг оновчтой төрөлжүүлсэн байна гэж дүгнэж болно.

Зөвлөмж

Төслийн хоёрдугаар бүлэг нь арилжааны үйл ажиллагааг оновчтой зохицуулах, арилжаа эрхлэгчийг төрөлжүүлэх зорилтуудыг хангаж байх тул энэхүү хэсэгт зөвлөмж өгөхөөс татгалзав.

III. АРИЛЖААНЫ БҮРТГЭЛ БОЛОН АРИЛЖААНЫ НЭР

“Арилжааны ерөнхий хууль”-ийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-т заасан хуулийн төслийн анхдагч хуулийн төслийн төрлөөр боловсруулагдсан бөгөөд мөн хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”³¹-д заасны дагуу дараах үе шаттайгаар бэлтгэсэн болно.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгийг тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Энэхүү үр нөлөөг үнэлэх судалгааны хүрээг “Арилжааны ерөнхий хууль”-ийн 3 болон 4 дүгээр бүлгээр тогтоов.

3.1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт

Үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлуудтай уялдуулан, аргачлалд заасны дагуу дараах 6 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Хүлээн зөвшөөрөх байдал
5. Харилцан уялдаа
6. Зардал

“Зорилгод хүрэх байдал” бүхий шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Арилжааны ерөнхий хууль”-ийн төсөл (Цаашид “Хуулийн төсөл” гэх)-ийн холбогдох зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалд болон хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн хуулийн төсөлд тусгасан заалт, зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхэд үнэлгээ хийхийг зорьсон юм.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

³¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

“Практикт хэрэгжих боломж” бүхий шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгасан дараах зохицуулалтуудын практикт хэрэгжих боломжийг шалгахар сонгож авав. Үүнд:

- Хуулийн төслийн Гуравдугаар бүлэг. Арилжааны бүртгэлийн зохицуулалт нь арилжаа эрхлэгч болох аж ахуй нэгж, хувиараа бизнес эрхлэгч нар, цаашлаад бүртгэлийн байгууллага гэх мэт төрийн байгууллагад нэмэлт ачаалал үүсгэх эсэх, хэрэв үүсгэвэл түүнд тохирох эсхүл түүнээс давсан эерэг үр дүн (арилжааны харилцаанд оролцогчдын итгэлийг хамгаалах, зардлыг бууруулах)-г практикт бий болгож чадах эсэхийг үнэлэх;
- Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэг. Арилжааны нэрийн зохицуулалт нь арилжаа эрхлэгчийн зах зээлд танигдсан бизнесийн үйл ажиллагааны нэрээ хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бодитоор бий болгож чадах эсэх, барааны тэмдэгт холбогдох зохицуулалтаас ялгаж чадах эсэхийг үнэлэх;

“Ойлгомжтой байдал” бүхий шалгуур үзүүлэлтийг дараах шалтгаанаар сонгов. Тус хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл тул хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектэд ойлгомжтой, салаа утгагүй байх, хуулийн төсөлд тусгасан зүйл, заалтууд нь найруулгын хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлэх;

“Хүлээн зөвшөөрөх байдал” бүхий шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана.

“Харилцан уялдаа” бүхий шалгуур үзүүлэлтийг дараах шалтгаанаар сонгов. Тус хуулийн төсөл нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Улсын бүртгэлийн хууль болон Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль болон холбогдох бусад хуультай давхардалгүй, уялдаа холбоотой буюу зохицолтой эсэхийг үнэлэх;

“Зардал” бүхий шалгуур үзүүлэлтийн хүрээнд тус хуулийн төсөл батлагдсан тохиолдолд бий болох эерэг үр дүн, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлаасаа давсан буюу ашигтай байх эсэхэд үнэлэх.

3.2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын гуравдугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн тодорхой зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг нь үнэлнэ. Тухайн зохицуулалтыг сонгохдоо мөн зүйлийн 3.2-т заасны дагуу “гол ач холбогдолтой зохицуулалтыг олж тогтоох нь зүйтэй бөгөөд тухайн зохицуулалт бодитой судалгаа хийж болохуйц байх шаардлагатай” гэснийг урьдчилсан нөхцөл болголоо.

Тус хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл бөгөөд өмнө нь Иргэний хуулиар зохицуулагдаж байсан арилжааны шинжтэй харилцааг Иргэний хуулиас салгах, цаашлаад нэмэлтээр шинэлэг тогтолцоо бий болгож байгаа билээ. “Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан”-гийн үр дүнд дараах зөвлөмжийг хүргэсэн бөгөөд тэдгээрийн дотор “Аж ахуй эрхлэгчийн бүртгэл”, “Аж ахуй эрхлэгчийн нэр, түүнийг шилжүүлэх, түрээслүүлэх, бүртгүүлэх асуудал”-ыг хуулийн төсөлд тусгах шаардлагатай гэсэн байна. Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх тодорхой

зохицуулалтыг хуулийн төсөлд 3 болон 4 дүгээр бүлэг буюу 9 дүгээр зүйлээс 13 дугаар зүйлд тусгасан байна.

Тиймээс энэ хэсэгт дээрх 6 шалгуурын дагуу, “Арилжааны ерөнхий хууль”-ийн төслийн Гуравдугаар бүлгийн 9, 10 дугаар зүйл болон Дөрөвдүгээр бүлгийн 11, 12, 13 дугаар зүйлийг сонгон авч үр нөлөөг үнэлнэ.

Хүснэгт №2. Арилжааны ерөнхий хуулийн төсөлд арилжааны бүртгэл болон арилжааны нэрд холбогдох зохицуулалт тусгагдсан байдал.

№	Зүйлийн дугаар, нэр	Зохицуулалт
1.	9 дүгээр зүйл.Арилжааны бүртгэл	9.1.Арилжааны бүртгэл нь хувиараа арилжаа эрхлэгчийн төрөлжсөн бүртгэл болон ашгийн төлөө хуулийн этгээдийн улсын бүртгэлээс бүрдэнэ. 9.2.Хувиараа арилжаа эрхлэгчийн төрөлжсөн бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн харилцааг хуулиар зохицуулна. 9.3.Бүртгэлийн байгууллага арилжаа эрхлэгч арилжааны бүртгэлд шинээр бүртгүүлсэн болон хасагдсан, бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт орсон тухай нийтэд мэдээлнэ. 9.4.Арилжааны бүртгэл дэх арилжаа эрхлэгчийн мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байх болон хаалттай байх мэдээллээс бүрдэнэ. 9.5.Арилжаа эрхлэгчийн бүртгэлд бүртгэгдэх мэдээллийн төрөл, нээлттэй болон хаалттай байх мэдээллийн агуулга, бүртгэл хөтлөх журмыг холбогдох хуулиар зохицуулна. 9.6.Хувиараа арилжаа эрхлэгч дахин давтагдашгүй бүртгэлийн дугаартай байна. Энэ хуулийн 12 дугаар зүйлийг тус бүртгэлийн дугаарын хувьд нэгэн адил хэрэглэнэ. 9.7.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны бүртгэлд бүртгүүлсэн бол бүртгэгдсэн болохыг илэрхийлсэн “Х.А.Э” буюу хувиараа арилжаа эрхлэгч гэсэн ялгах тэмдгийг арилжааны үйл ажиллагаагаа эрхлэн явуулахдаа хэрэглэнэ.
2.	10 дугаар зүйл.Арилжааны бүртгэлийн үр дагавар	10.1.Арилжааны бүртгэл дэх мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр арилжаа эрхлэгч зохих өөрчлөлтийг арилжааны бүртгэлд тусгуулж, арилжааны бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах үүрэгтэй. Арилжааны бүртгэлд холбогдох өөрчлөлтөө тусгуулаагүйгээс гарах үр дагаврыг арилжаа эрхлэгч хариуцна. 10.2.Арилжаа эрхлэгч заавал бүртгүүлэх мэдээллийг бүртгүүлээгүй бол тухайн мэдээллийн талаар мэдээгүй гуравдагч этгээдийн эсрэг тус бүртгүүлээгүй мэдээллийг ашиглах эрхгүй. 10.3.Арилжаа эрхлэгч санаатай болон болгоомжгүйгээр арилжааны бүртгэлд буруу ташаа мэдээлэл бүртгүүлсэн бол тухайн бүртгэлийн зөрүүтэй байдлын талаар мэдээгүй, эсхүл мэдэх боломжгүй байсан гуравдагч этгээдийн хувьд хэлцэл хийх үед олон нийтэд нээлттэй байсан арилжааны бүртгэлийн мэдээллийг үнэн зөв гэж тооцно. 10.4.Гуравдагч этгээд нь арилжааны бүртгэлд бүртгэгдээгүй мэдээллийн талаар, эсхүл арилжааны бүртгэл дэх олон нийтэд нээлттэй мэдээлэл буруу ташаа, зөрүүтэй байсан талаар мэдэж байсан, эсхүл илт болгоомжгүйгээс

		мэдээгүй бол энэ хуулийн 10.2, 10.3 дахь хэсэг үйлчлэхгүй. Энэ тохиолдолд бүртгүүлэх үүрэг хүлээсэн арилжаа эрхлэгч тухайн мэдээллийг гуравдагч этгээд мэдэж байсан, эсхүл илт болгоомжгүйгээс мэдээгүй болохыг нотлох үүрэгтэй. 10.5.Арилжаа эрхлэгч арилжааны бүртгэлд заавал бүртгүүлэх мэдээллийг зохих журмын дагуу бүртгүүлсний дараа тухайн мэдээллийг гуравдагч этгээдийн эсрэг ашиглах эрхтэй болно. Гэхдээ ийнхүү бүртгэгдсэн мэдээлэл нь зүй ёсны шалтгааны улмаас энэ талаар мэдээгүй, эсхүл мэдэх боломжгүй байсан гуравдагч этгээдийн хувьд эрх зүйн үр дагавар үүсгэхгүй. Энэ тохиолдолд гуравдагч этгээд нь зүй ёсны шалтгааны улмаас энэ талаар мэдээгүй гэдгээ өөрөө нотлох үүрэгтэй.
3.	11 дүгээр зүйл. Арилжааны нэр	11.1.Арилжаа эрхлэгч нь хэлцэл хийх, арилжааны үйл ажиллагаагаа эрхлэн явуулахдаа өөрийн арилжааны нэрийг хэрэглэнэ. Арилжааны нэр нь арилжаа эрхлэгч нэхэмжлэл гаргах, хариуцагчаар татагдах тохиолдолд хэрэглэгдэж болно. 11.2.Хувиараа арилжаа эрхлэгч нь арилжааны нэрээ бүртгүүлж болно. 11.3.Арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн нэр нь тухайн хуулийн этгээдийн арилжааны нэр байна. 11.4.Аливаа этгээд өөрийгөө арилжаа эрхлэгч гэж бусдыг төөрөгдүүлэхээр нэр, ялгах тэмдэг ашиглахыг хориглоно.
4.	12 дугаар зүйл. Шударга бусаар бусдын арилжааны нэрийг ашиглахыг хориглох	12.1.Аливаа этгээд шударга бус зорилгоор бусад арилжаа эрхлэгчийн арилжааны нэртэй давхардсан, эсхүл бусдыг төөрөгдүүлэхүйц ижил, төсөөтэй нэр ашиглахыг хориглоно. 12.2.Арилжаа эрхлэгч арилжааны нэрийг нь энэ хуулийн 12.1-д заасныг зөрчиж ашигласан этгээдийн эсрэг уг үйлдлийг таслан зогсоох, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй. Хохирол нөхөн төлүүлэхээр шаардах тохиолдолд Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг хэрэглэнэ.
5.	13 дугаар зүйл. Арилжааны нэрийг бусдад ашиглуулах, шилжүүлэх болон холбогдох хариуцлага	13.1.Хувиараа арилжаа эрхлэгч өөрийн арилжааны нэрийг бүртгүүлсэн бол арилжааны нэрээ бусад хувь хүнд ашиглуулж, шилжүүлж, өв залгамжлуулж болно. 13.2.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны нэрийг шилжүүлэх, өв залгамжлуулах тохиолдолд энэ талаар арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй. 13.3.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны нэрийг бусдад ашиглуулах гэрээг бичгээр байгуулж, арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд энэ шаардлагыг зөрчсөн гэрээ хүчин төгөлдөр бус байна. 13.4.Хувиараа арилжаа эрхлэгч өөрийн арилжааны нэрээ бусдад ашиглуулсан тохиолдолд өөртэй нь хэлцэл хийсэн гэж төөрөгдөж арилжааны нэрийг ашиглаж байгаа этгээдтэй хэлцэл хийсэн гуравдагч этгээдийн өмнө

	тухайн хэлцлээс үүссэн үүргийг арилжааны нэрийг ашиглаж байгаа этгээдтэй хамтран хариуцна. Энэ хуулийн 13.3-т заасныг зөрчсөн тохиолдолд ч нэгэн адил байна. 13.5.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны нэрийг бусдад шилжүүлэх бол арилжааны үйл ажиллагаатай нь хамт, эсхүл өөрийн арилжааны үйл ажиллагааг бүрмөсөн зогсоосны дараа шилжүүлнэ. 13.6.Гэрээнд өөрөөр заагаагүй бол арилжааны нэрээ бусдад шилжүүлсэн хувиараа арилжаа эрхлэгч нь арилжааны нэрээ шилжүүлсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд арилжааны нэрийг шилжүүлэн авсан этгээд арилжааны үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг аймаг, нийслэлд ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэхгүй. 13.7.Хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авсан этгээд нь тухайн арилжаа эрхлэгчийн арилжааны нэрийг үргэлжлүүлэн хэрэглэх тохиолдолд шилжүүлэн авсан арилжааны үйл ажиллагаанаас нь үүссэн үүргийг гүйцэтгэх үүрэг хүлээнэ. 13.8.Энэ хуулийн 13.7-д заасан тохиолдолд арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авсны дараа даруй тухайн арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авахаас өмнө үүссэн үүргийг хариуцахгүй болохоо арилжааны бүртгэлд бүртгүүлсэн бол тухайн үүргийг гүйцэтгэх үүрэг хүлээхгүй. 13.9.Энэ хуулийн 13.6-д заасан тохиолдолд арилжааны үйл ажиллагаагаа шилжүүлэгч болон шилжүүлэн авагч нь гуравдагч этгээдэд хандан тухайн арилжааны үйл ажиллагаанаас үүссэн үүргийг шилжүүлэн авагч цаашид хариуцахгүй тухай мэдэгдсэн бол тухайн үүргийг шилжүүлэн авагч гүйцэтгэх үүрэг хүлээхгүй. 13.10.Хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авсан этгээд нь тухайн арилжаа эрхлэгчийн арилжааны нэрийг үргэлжлүүлэн хэрэглэхгүй тохиолдолд ч тухайн арилжааны үйл ажиллагаанаас үүссэн үүргийг өөртөө шилжүүлэн авсан бол тухайн арилжаа эрхлэгчийн үүрэг гүйцэтгүүлэгч нь тухайн арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авагчид хандан үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй. Энэ тохиолдолд Иргэний хуулийн 124 дүгээр зүйлийн зохицуулалтыг нэгэн адил хэрэглэнэ.
--	---

3.3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 9-13 дугаар зүйл	Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын судалгаанд дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэж чадах эсэхэд дүн шинжилгээ хийх, сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 9-13 дугаар зүйл	Хуулийг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц) бүрдэх эсэхийг судалж тодорхойлох.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн 9-13 дугаар зүйл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
4	Хүлээн зөвшөөрөх байдал	Хуулийн төслийн 9-13 дугаар зүйл	Тус хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор эрх ашиг, сонирхол нь хөндөгдөх этгээдүүдийн байр суурийг тодорхойлох.
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийн 9-13 дугаар зүйл	Иргэний хууль болон Улсын бүртгэлийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй эсэхийг үнэлэх.
6	Зардал	Хуулийн төслийн 9-13 дугаар зүйл	Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах үйл ажиллагааны зардлын тооцоо хийх /аргачлалын дагуу тусад нь хийх/, түүнээс гарсан үр дүнг үнэлэх.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ хэсэгт дээрх зохицуулалтууд нь хуулийн төслийг боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагад тусгагдсан асуудлыг шийдвэрлэж чадах эсэхийг үнэлэх байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Үүний тулд, нэн тэргүүнд тус хуулийн төсөл боловсруулагдах хэрэгцээ шаардлагыг тодорхой болгох шаардлагатай. Судлаачид арилжааны нэр болон, арилжааны бүртгэлтэй холбоотой дараах асуудал байгаа талаар авч үзжээ.³² Үүнд:

³² Б.Амарсанаа, С.Батбаяр, Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар “Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан” 2019 он.

№	Хэрэгцээ, шаардлага, зорилт	Нийцэж буй эсэх
(Арилжааны бүртгэлтэй холбогдох хэсэг) Зорилт: “Аж ахуй эрхлэгчийн арилжааны бүртгэлийн тогтолцоог бий болгож, хэлцлийн баталгаат байдлыг хангах”		
1.	Хувиараа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэхгүй, санхүүгийн тайлан тооцоо хөтөлдөггүй нь арилжааны хэлцлийн найдвартай, тогтвортой байдлыг хангаж чадахгүй байна.	Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд арилжааны бүртгэлийн эрх зүйн орчны үндэслэл бүрдсэн байна.
2.	Аж ахуй эрхлэгчийн бүртгэл буруу бүртгэгдснээс үүсэх үр дагаврыг аж ахуй эрхлэгч өөрөө хүлээж, хэлцлийн нөгөө талын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй.	Хуулийн төслийн 10 дугаар зүйлд арилжаа эрхлэгч бүртгэлд бүртгүүлээгүй, бүртгэлд байгаа мэдээллээ шинэчлээгүй тохиолдолд түүнд итгэсэн шударга (гэрээний) нөгөө талын эрх, ашиг сонирхлыг хамгаалахаар тусгасан, бүртгэлээс үүсэх үр дагаврыг зарчмын хувьд арилжаа эрхлэгч өөрөө хүлээхээр байна.
(Арилжааны нэртэй холбогдох хэсэг) Зорилт: “Арилжааны нэрийн зохицуулалтыг бий болгож оюуны өмчийн хамгаалагдах эрхийн объектэд хамааруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах зохицуулалтыг бий болгох”		
3.	Арилжааны нэрийг зохицуулаагүйгээс нэрийг давхардуулан олгох, бусдыг төөрөгдүүлэх байдлаар ашиглах боломжийг олгож байна.	Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд Арилжааны нэрийн эрх зүйн зохицуулалтын үндэслэлийн тавьж өгчээ. Мөн Арилжааны нэр нь Иргэний хуулийн хамгаалагдах объект болох талаар тусгажээ. Тодруулбал, хуулийн төслийн 12 дугаар зүйлд шударга бусаар бусдын арилжааны нэрийг ашиглахыг хориглох талаар зохицуулжээ.
4.	Аж ахуй эрхлэгчийн арилжааны нэрийн зохицуулалт тодорхойгүйгээс нэрийг бусдад ашиглуулах, түрээслэх замаар ашиг олох боломжгүй нөхцөлийг үүсгэж байна.	Хуулийн төслийн 13 дугаар зүйлд арилжааны нэрийг эдийн засгийн эргэлтэд оруулах, гэрээний зүйл болгох, өвлүүлэх боломжтой болох талаар зохицуулжээ.

2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгуурын үнэлгээг тус хуулийн төслийн зардлын тооцооны үнэлгээнд тулгуурлан үнэлэв. Хуулийн төсөл батлагдсантай холбоотой гарах зардлын тооцоог заалт тус бүрт үнэлэх нь учир дутагдалтай. Зарим заалт өндөр зардал гарах заалт байгаа бол зарим нь өндөр өгөөж бий болгохыг үгүйсгэхгүй. Эдгээр нь бүрэлдээ эдийн засгийн өгөөжтэй эсэхийг дүгнэх шаардлагатай.

Хүснэгт №3. Зардлын тооцооны үнэлгээ³³

³³ МУИС-ийн ХЗС-ийн харьяа Эдийн засаг, бизнесийн эрх зүйн судалгааны төв “АРИЛЖААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН” 2024 он.

№	Зардлын ангилал	Зардлын үнэлгээ
1.	Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо	Арилжааны бүртгэлийн хэвийн тогтвортой байдлыг хангахад улсын бүртгэлийн байгууллага өөрийн чиг үүргийн дагуу уг харилцаанд оролцохоор байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор жилд дунджаар төрийн байгууллагад 5,915,485 минутын ачаалал үүсгэх ба түүнд холбогдож 1,382,872,928 төгрөгийн зардал үүснэ. Ийнхүү зардал нэмэгдэх шалтгаан нь тус хуулийн төсөл дэх хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй холбоотой. Гэвч арилжаа эрхлэгчдийн бүртгэлжүүлэх, тэдгээрийн баримтлах тусгай хэм хэмжээг төрөлжүүлэн батлах нь арилжаа, бизнесийн харилцааны түргэн шуурхай, найдвартай байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.
2.	Хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо	Арилжааны эрх зүй нь хувийн эрх зүйн салбар боловч Иргэний эрх зүйгээс ялгарах зарим онцлог зарчимтай байдаг. Арилжааны ерөнхий хууль дахь хэм хэмжээ нь дийлэнхдээ димпозитив шинжтэй байх тул гагцхүү зайлшгүй биелэгдэх шинжтэй буюу императив хэм хэмжээгээр үүрэг хүлээлгэсэн зүйл, заалтыг сонгож, тэдгээрт холбогдох зардлыг тооцсон. Ийнхүү гэрээний талуудын эрх, зарчимтай холбогдох өөрчлөлтийг зардлын тооцооноос хасч, гагцхүү императив заалт эсхүл голлох өөрчлөлттэй холбоотой зардлыг тооцож үзэхэд уг хуулийн төсөл хэрэгжсэнээр арилжаа эрхлэгч хуулийн этгээд, арилжааны зуучлагч, төлөөлөгч, зорчигч тээвэрлэгч нарт жилд дунджаар 560,705,288 төгрөгийн зардал гарах төлөвтэй байна.
3.	Иргэнд үзүүлэх ачааллыг тооцоо	Арилжааны ерөнхий хууль батлагдсанаар хувиараа арилжаа эрхлэгч иргэний арилжааны бүртгэлд бүртгүүлэх, үнэн зөв байдлыг хариуцах, нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр хийлгэх, арилжааны нэрийг бусдад ашиглуулах, шилжүүлэх тохиолдолд бүртгүүлэх зэрэг голлох үүргийг хүлээнэ. Дээрх үүргүүдтэй холбоотойгоор тухайлбал арилжааны бүртгэлд бүртгүүлэхэд дунджаар 170 минут, бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулахад 160 минут, нягтлан бодох бүртгэл хөтлөхөд 2400 минут, арилжааны нэрийг бусдад шилжүүлэхэд 580 минутын ачаалал үүснэ. Ийнхүү ачаалал үүсэх болсон шалтгаан нь санхүүгийн тайлан гаргах, арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй холбоотой. Иргэнд учрах ачааллыг бууруулах зорилгоор цахим арилжааны бүртгэлийг үүсгэх, идэвхжүүлэх, бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлагыг багасгах, гэрээ, баримт бичгийн төслийн жишиг загвар гаргах зэрэг оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Нөгөөтэйгүүр арилжааны бүртгэлд бүртгүүлснээр тухайн арилжаа эрхлэгчийн найдвартай, мэргэжлийн, хариуцлагатай байдлыг тодотгож, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах давуу талтай.
4.	Зардал-үр өгөөжийн үнэлгээ	Хуулийн төсөл дэх арилжааны бүртгэл, арилжааны төлөөлөл зэрэг арилжааны харилцааг түргэн шуурхай байлгахад

	чиглэсэн тусгай зохицуулалт нь арилжаа эрхлэгчийн дотоод хэлцлийн зардлыг үлэмж багасахаас гадна гэрээний хүчин төгөлдөр байдалтай холбоотой шүүхийн маргааны тоог бууруулж, улмаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардлыг бодитой бууруулна. Дээрхтэй холбоотой санхүүгийн өгөөжийг шүүхийн болон шүүхийн бус гэж ангилж үзвэл, тус хуулийн төсөл хэрэгжсэнээр зохицуулагч байгууллага, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ачааллыг 46,466,400 минутаар бууруулах боломжтойгоос гадна шүүхэд маргаан үүсгэх, өмгөөлөгч авах, шүүхэд тайлбар, нэхэмжлэл, нотлох баримт гаргаж өгөх, шүүх хуралдаанд оролцох зэрэгтэй холбоотойгоор арилжаа эрхлэгчид учрах шүүхийн зардлыг мөн бууруулна. Харин шүүхийн бус зардалд тухайлан авч үзвэл, B2B, B2C харилцааны явцад хэлцлийн нэг тал хэлцэл хийгч нөгөө талын гэрээ байгуулах эрхтэй этгээдийн талаарх мэдээллийг цуглуулах, түүний төлөөлөх бүрэн эрхийн үндэслэл, итгэмжлэлийг хянах, дүн шинжилгээ хийх, танилцуулахад дунджаар 8 цаг буюу 1 ажлын өдрийг, хууль буюу итгэмжлэлээр төлөөлөх эрхтэй этгээдээр гэрээг заавал баталгаажуулахад дунджаар 2 цагийг зарцуулдаг гэж үзвэл нэг арилжаа эрхлэгч нэг удаагийн хэлцэл хийхэд ойролцоогоор 116,160 төгрөгний зардалтай ажилладаг байна. Арилжаа ерөнхий хуульд заасан арилжааны бүртгэл, төлөөлөлтэй холбоотой тусгай зарчим хэрэгжиж эхэлснээр дээр дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 81.6 мянга гаруй арилжаа эрхлэгч хуулийн этгээдэд учрах зардал болох 9 тэрбум 400 гаруй сая төгрөгийг хэмнэх боломжтой.
--	---

3. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Шаардлага хангасан эсэх
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.

29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан..
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан байна.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан

30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан
--	--------------------

4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

№	Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт заалт	Арилжааны ерөнхий хуулийн төсөлтэй нийцсэн байдал
1	Монгол Улсын үндсэн хууль	Тавдугаар зүйл. 1.Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.	Арилжааны бие даасан хуультай байх нь дэлхийн эдийн засгийн хувьд өндөр хөгжилтэй орнуудын нийтлэг хандлага гэж үзэж болохоор байна. ³⁴ Энэ нь тухайн улс орон өөрийн орны бизнес, эдийн засгийг хөгжүүлэх нэг арга хэлбэр юм. Үүний жишээ болгон Европын холбооны орнуудаас эрх зүйн томоохон төлөөлөгч улс болох Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Азиас Япон Улс, англо-саксоны эрх зүйн бүлийн орнуудаас Америкийн нэгдсэн улсыг дурдаж болно. АНУ-ын хувьд муж бүр өөрийн онцлогт нийцсэн Иргэний хуультай боловч Арилжааны хуулийн хувьд нийтлэг загвар хууль /Uniform Commercial Code/-ийг баталсан байдаг. ³⁵
		Арван зургадугаар зүйл 4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;	Зах зээлийн чөлөөт эдийн засгийн амин сүнс нь шударга өрсөлдөөнт хувийн аж ахуй байдаг. Үндэсний Статистикийн хорооноос гаргасан 2018 оны 1-р улирлын Ажиллах хүчний судалгаагаар Монгол Улсад нийт 1,142,900 хүн ажил эрхэлж байгаагаас 269,500 хүн буюу нийт ажил эрхэлж буй хүн амын 23.5 хувь нь хувиараа аж ахуй эрхлэгч байгаа ³⁶ бөгөөд энэ хуулийн төсөлд тусгагдсан арилжааны бүртгэл болон арилжааны нэрийн зохицуулалт нь тэдгээр аж ахуй эрхлэгчдийн бизнесийн итгэлийг хамгаалах үндсэн ач холбогдолтой.

³⁴ ХЗДХЯ-ны захиалгаар Н.Норовсамбуу, Г.Давааням, Ж.Содномдаржаа “Гадаад орнуудын арилжааны /худалдаа/-ны тухай хуулиудын харьцуулсан судалгаа” 2019 он.

³⁵ Uniform Law Commission. "Uniform Commercial Code (UCC)." Accessed June 17, 2024. <https://www.uniformlaws.org/acts/ucc>.

³⁶ Б.Амарсанаа, С.Батбаяр, Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар “Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан” 2019 он.

2	Иргэний хууль	2.1.Иргэний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. 3.3.Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ.	Арилжааны ерөнхий хуулийн төслийн 5 дугаар зүйлд Арилжааны ерөнхий хуулийн зохицуулалт нь Арилжааны эрх зүйн харилцааны нарийвчилсан хууль байхаар тусгажээ. Тиймээс Иргэний хуулийн зохицуулалттай нийцэж байна. Түүнчлэн, мөн зүйлийн 5.2-т зааснаар “арилжааны заншил, талуудын хооронд тогтсон практикийн дагуу, тийм заншил, практик байхгүй, эсхүл талууд түүнийг хэрэглэхгүй талаар хүсэл зориггоо тодорхой илэрхийлсэн тохиолдолд энэ хуулийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ” гэж заасан ерөнхий болон нарийвчилсан хуулийн хэв шинжийг агуулж байна.
3	Улсын бүртгэлийн тухай хууль	2.1.Улсын бүртгэлийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.	Арилжааны ерөнхий хуулийн төслийн 9 дүгээр зүйлд зааснаар Арилжааны бүртгэл нь хувиараа арилжаа эрхлэгчийн төрөлжсөн бүртгэл болон ашгийн төлөө хуулийн этгээдийн улсын бүртгэлээс бүрдэнэ. Хуулийн этгээдийн бүртгэл нь одоогийн тогтолцоогоороо явах бөгөөд шинээр бий болох бүртгэл нь хувиараа арилжаа эрхлэгчийн төрөлжсөн бүртгэл юм. Арилжааны ерөнхий хуулийн Иргэний хуулийн нарийвчилсан хууль бөгөөд Иргэний хуультай нийцсэн байх тул Улсын бүртгэлийн тухай хуульд мөн нийцнэ.
4	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль	3.1.1."барааны тэмдэг" гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг;	Арилжааны нэр нь хуулийн этгээдийн хувьд хуулийн этгээдийн нэр байх бол хувиараа аж ахуй эрхлэгч нарын хувьд бодит утгаараа бусад аж ахуй эрхлэгчдээс ялгагдах нэршил болно. Энэхүү нэр нь Арилжааны ерөнхий хуулийн төслийн 11-13 дугаар зүйлд заасан зохицуулалтын дагуу хөрөнгө болж буй бөгөөд эрх зүйн хамгаалалтад орж буй юм. Ингэснээр хөрөнгийн өмчлөгч тухайн арилжааны нэрийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж үүснэ. Дээрх заалтууд Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулиар зохицуулаагүй харилцааг зохицуулж буй тул зөрчилдөхгүй.

Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Улсын бүртгэлийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль зэрэг хуулиудад заасан арилжаа, арилжааны бүртгэл, арилжааны нэртэй холбоотой харилцааг зохицуулсан холбогдох зохицуулалтыг харьцуулж үзэхэд харилцан уялдаатай, нийцэлтэй байна.

5. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Тус хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл бөгөөд нийгэмд зарим талаар шинэ тогтолцоог бий болгоно. Тухайлбал, хувиараа аж ахуй эрхлэгчдийн бүртгэл болон арилжааны нэрийн асуудал юм. Нэг талаасаа бүртгэл нь үүрэг болгох, тухайн үүргийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг хариуцах зэргээр арилжааны харилцаанд оролцогчдын эрх, ашиг сонирхлыг хөндөх эрсдэл бий. Тиймээс энэ хуультай холбогдох бизнесийн эрхлэгчдийн байр суурийг тодруулах шаардлагатай. Үүний дагуу бэлтгэсэн “Арилжааны хууль тогтоомжийн зохицуулалтын талаарх бизнес эрхлэгчдийн байр суурь судалгааны тайлан”³⁷-аас үзвэл, “Монгол Улсад бизнес эрхлэхэд бизнес эрхлэгчид бие биедээ итгэх итгэлийн төвшин хангалттай хэмжээнд биш байгаа гэсэн дүгнэлтийг судалгааны үндсэн дээр хийж болохуйц байна. Энд дурдсан итгэлийг бий болгох, хамгаалах нь зөвхөн эрх зүйн асуудал дангаар биш хэдий ч судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн хариултаас үзвэл эрх зүйн одоогийн орчин хангалттай бус, эрх зүйн тодорхойгүй байдал (эрх зүйн эрсдэл) давамгайлж байна” гэж дүгнэсэн байна.

Үүний дагуу арилжааны харилцаанд шударга оролцогчдын итгэлийг хамгаалах үүднээс арилжааны бүртгэлийн асуудлыг уг хуулийн төсөлд нарийвчлан тогтоож өгчээ. Энэхүү төсөл батлагдсанаар бизнесийн эрхлэгчдийн цаг хугацааг хэмнэх, түүнийг дагаад орлого нэмэгдэж³⁸ бизнес эрхлэх таатай орчин бүрдэх хүлээлттэй байх тул арилжааны харилцаанд оролцогчдод эергээр хүлээн зөвшөөрөгдөнө гэж үнэлэв.

6. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Эерэг дүнтэй. /Арилжааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайлан тайланг хавсаргав./

3.4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

Арилжааны ерөнхий хуулийн төслийн 3 болон 4 дүгээр бүлэгт сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу үнэлвээс, дараах үр дүнд хүрч байна.

- Зорилгодоо хүрэх боломжтой;
- Практикт хэрэгжих боломжтой;
- Ойлгомжтой;
- Харилцан уялдаатай;
- Хүлээн зөвшөөрөгдөх боломжтой;
- Зардлын хувьд эерэг дүнтэй.

³⁷ “Ханнс-Зайделийн” сангийн “Эрх зүйн боловсрол академи”-ийн захиалгаар “Өмгөөлөл судлалын академи” ТББ гүйцэтгэсэн “Арилжааны хууль тогтоомжийн зохицуулалтын талаарх бизнес эрхлэгчдийн байр суурь судалгааны тайлан” 2020 он.

³⁸ МУИС-ийн ХЗС-ийн харьяа Эдийн засаг, бизнесийн эрх зүйн судалгааны төв “АРИЛЖААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН” 2024 он.

Тиймээс тус хуулийн төслийн 3 болон 4 дүгээр бүлгийн зохицуулалтууд нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д заасан шалгууруудыг хангасан гэж дүгнэлээ.

Зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлж дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна. Үүнд:

- Хуулийн төсөлд хуулийн нэр томъёоны тайлбар хэсгийг нэмэхийг зөвлөж байна. Ингэснээр тухайн хуулийг хэрэглэх болон хэрэгжүүлэх явцад оролцогч талууд нэгдмэл утгаар ойлгож, маргаан үүсэхгүй боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

IV. АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТӨЛӨӨЛӨХ БҮРЭН ЭРХ

Энэхүү үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баримтлан Арилжааны тухай хуулийн төслийн Тавдугаар бүлэг, арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрх-ийг боловсронгуй болгоход чиглэнэ.

Төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэлээ.

4.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох

Төслийн Тавдугаар бүлэг, арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрхийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо дараах шалгуур үзүүлэлтийг сонгов.

1. Зорилгод хүрэх байдал

Уг шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзэв.

Арилжааны хууль нь арилжааны тогтвортой, баталгаатай, түргэн шуурхай байдлыг хангах туйлын зорилготой бөгөөд “тохиролцоонд хүрэх зардал” (transaction cost)-ыг хамгийн бага түвшинд байлгахад чиглэдэг. Арилжааны төлөөлөх бүрэн эрхийн тогтолцоо нь цогц, иж бүрэн төлөөлөх бүрэн эрхийг арилжаа эрхлэгчийн дотоод ажилтанд олгох замаар арилжааны үйл ажиллагааг эрхлэн явуулах боломжийг бүрдүүлдгээрээ арилжааны тогтвортой, баталгаатай, түргэн шуурхай байдлыг хангах шууд ач холбогдолтой.

4.2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Манай Улсын Иргэний хуулийн Долдугаар бүлэгт тусгагдсан төлөөллийн зохицуулалт нь иргэний эрх зүйн суурь харилцаанд төлөөлөл үүсэх ерөнхий үндэслэлийг тусгасан гэдэг утгаараа арилжааны үйл ажиллагаанд үйлчлэх зорилго болон агуулгыг хангалттай агуулаагүй байдаг. Түүнчлэн Компанийн тухай хуулийн зохицуулалт нь

компанийг төлөөлөх эрхийг гагцхүү компанийн орган болох гүйцэтгэх удирдлагад олгодог бөгөөд энэ нь шийдвэр гаргах зардлыг нэмэгдүүлдэг.

Энэ хүрээнд дээрх хуулийн зохицуулалтууд нь арилжааны төлөөллийн харилцааг зохицуулахад дараах хүндрэлүүдийг бий болгож, арилжааны тогтвортой, баталгаатай, түргэн шуурхай байдалд сөргөөр нөлөөлж байдаг. Тухайлбал:

- Иргэний хууль нь тухайлсан хэлцэлд төлөөлөх харилцааг зохицуулах агуулгатай байдаг тул арилжааны үйл ажиллагаанд шаардагдах төрөл бүрийн, өргөн хүрээтэй, үргэлжилсэн шинжтэй арилжааны хэлцлийн төлөөллийг зохицуулахад тохиромжгүй;
- Иргэний хуулийн төлөөлөх бүрэн эрхийг гагцхүү хуулийн дагуу эсхүл итгэмжлэлийн үндсэн дээр үүсэхээр зохицуулсан нь ажил үүргийн хувьд арилжааны төлөөллийг хэрэгжүүлэх боломжтой этгээдийн төлөөлөх бүрэн эрхэд эргэлзээ үүсгэдэг;
- Иргэний хуулийн хүрээнд илэрхий, ил тод байх зарчмыг баримталдаг нь төлөөлөх бүрэн эрхийн хүчин төгөлдөр байдалд эргэлзээ үүсгэдэг;
- Гадаад нөхцөл байдалд итгэсэн гуравдагч этгээдийн итгэл зохистой хэмжээнд хамгаалагддаггүй.

Иймд төслийн “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг тооцохын тулд дээрх асуудлуудыг багцалж дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгогдсон зүйл, заалт

	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Арилжааны төлөөлөх бүрэн эрхийг төрөлжүүлэх	14 дүгээр зүйлийн 14.1, 14.2
2	Арилжааны төлөөлөх бүрэн эрх үүсэх үндэслэлийг өргөжүүлэх	14 дүгээр зүйлийн 14.5
3	Гадаад нөхцөл байдалд итгэсэн гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах	14 дүгээр зүйлийн 14.7, 14.9

4.3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох

“Арилжааны төлөөлөх бүрэн эрхийг төрөлжүүлэх” зорилтын хувьд

14.1. Арилжаа эрхлэгчийн эрхлэн явуулдаг арилжааны үйл ажиллагаанд хамаарах тодорхой төрлийн арилжааны хэлцэл болон хууль ёсны үйлдэл, эсхүл мөн тухайн арилжааны үйл ажиллагаанд хамаарах тодорхой хэлцэл болон хууль ёсны үйлдлийг хийх бүрэн эрхийг арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь бусад этгээдэд олгож болно.

14.2. Хувиараа арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь энэ хуулийн 14.1-д зааснаас гадна өөрийн эрхлэн явуулдаг арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрхийг бусад этгээдэд олгож болно.

Арилжааны төлөөлөл нь арилжааны тогтвортой, баталгаатай, түргэн шуурхай байдлыг хангах үүднээс арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх цогц, иж бүрэн эрхийг хуульчилж өгдөг нь иргэний хуулиас ялгагдах арилжааны тухай хуулийн нэгэн чухал онцлог билээ. Энэ хүрээнд улс орнууд өргөн хүрээтэй арилжааны төлөөлөх бүрэн эрхийн төрлүүдийг хуульчилдаг. Иймд, ХБНГУ болон Япон Улсын арилжааны төлөөлөх бүрэн эрхийн төрлүүдийг авч үзэж төслийн тавдугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 нь арилжааны төлөөлөх бүрэн эрхийг төрөлжүүлэх зорилтод хүрч буй эсэхийг үнэлэх болно.

ХБНГУ

ХБНГУ-ын Арилжааны хуулийн 48 дугаар зүйл болон 54 дүгээр зүйлд 1) Прокура 2) Арилжааг эрхлэх бүрэн эрх 3) Тодорхой төрлийн хэлцэл хийх бүрэн эрх 4) Тодорхой хэлцэл хийх бүрэн эрх хэмээх дөрвөн төрлийн арилжааны төлөөлөх бүрэн эрхийг хуульчилсан байдаг.

ХБНГУ-ын Арилжааны хууль (HGB)

48 дугаар зүйл

1) Прокура-г гагцхүү арилжаа эрхлэгч болон түүний хууль ёсны төлөөлөгч нь ил тод хүсэл зоригийн илэрхийллийн үндсэн дээр олгож болно.

49 дүгээр зүйл

1) Прокурагийн төлөөлөх бүрэн эрх нь арилжааны үйл ажиллагааг явуулахад шаардагдах бүх төрлийн шүүхийн болон шүүхийн бус хэлцэл болон хууль ёсны үйлдлийг хийх бүрэн эрхийг хамарна.

54 дүгээр зүйл

1) Прокура олголгүйгээр арилжааг эрхлэх бүрэн эрх, тодорхой төрлийн хэлцэл хийх бүрэн эрх, эсхүл тодорхой хэлцэл хийх бүрэн эрхийг олгож болох бөгөөд энэхүү арилжааны төлөөлөх бүрэн эрх нь тухайн арилжааны үйл ажиллагааг хэвийн явуулах эсхүл тухайн хэлцлийг хийхэд шаардагдах бүх төрлийн хэлцэл болон хууль ёсны үйлдлийг хамарна.

ХБНГУ-ын Арилжааны хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д хуульчилснаар Прокура нь хамгийн өргөн хүрээтэй арилжааны төлөөлөх бүрэн эрх юм. Нэг үгээр хэлбэл, Прокура нь хуулиар тогтоож өгсөн арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах цогц, иж бүрэн эрх мөн. Үүнд бүхий л төрлийн шүүхийн болон шүүхийн бус хэлцэл болон хууль ёсны үйлдэл хамаарах бөгөөд арилжааны үйл ажиллагааг эрхлэн явуулах тодорхой орон зай болох салбар байгууллага эсхүл арилжаа эрхлэгчийн тодорхой арилжааны салбарыг төлөөлөх бүрэн эрх нь прокура-д хамаарна. Жишээ нь тодорхой арилжаа эрхлэгчийн Өмнөговь салбарын захирал г.м эсхүл ABC хүнс ногоо, ABC хувцас, ABC гэр ахуй г.м хэд хэдэн арилжааны салбарын тухайн арилжааны салбарын захирал зэргийг прокура гэж ойлгож болно.

Прокура-г гагцхүү арилжаа эрхлэгч болон түүний хууль ёсны төлөөлөгч олгох боломжтой бөгөөд энэ талаараа арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй. Прокура нь цогц, иж бүрэн эрх болохынхоо хувьд бусдад өөрийн прокура-г шилжүүлэх боломжгүй ч бусад төрлийн арилжааны төлөөлөх бүрэн эрхийг олгох боломжтой. Түүнчлэн арилжаа эрхлэгч тухайлан үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах эрхийг прокура-д олгохоос нааш прокура нь үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах эрхийг эдлэхгүй.

Прокура-гаас гадна арилжааг эрхлэх бүрэн эрх, тодорхой төрлийн хэлцэл хийх бүрэн эрх, тодорхой хэлцэл хийх бүрэн эрхийг ХБНГУ-ын Арилжааны хуулийн 54 дүгээр зүйлийн

54.1-д хуульчилсан. Энэхүү 54.1 дүгээр зүйлийн ач холбогдол нь арилжааны төлөөлөх цогц, иж бүрэн эрхийг хуульчлах замаар арилжааны төлөөлөлд тодорхой хуулийн үндсийг бүрдүүлэхэд оршино. Өөрөөр хэлбэл, арилжааны төлөөлөх бүрэн эрх олгох итгэмжлэлийн хүрээнд тухайн бүрэн эрхийн агуулгыг арилжаа эрхлэгч чөлөөтэй тогтоох боломжтой. Түүнчлэн, 54 дүгээр зүйлийн 2 дахь өгүүлбэр нь "... бүх төрлийн хэлцэл болон хууль ёсны үйлдлийг хамарна" гэж хуульчилж хэлцэл, хэлцэлтэй төсөөтэй үйлдэл, бодит үйлдэл зэрэг эрх зүйн үр дагавар үүсгэж болох бүхий л үйлдэлд төлөөлөх бүрэн эрх хэрэгжихээр хуульчилжээ.

Арилжааг эрхлэх бүрэн эрх нь прокура-аас ялгаагүй, прокура-ийн нэг хэлбэр гэж хэлж болно. Харин, тодорхой төрлийн хэлцэл хийх бүрэн эрх нь арилжааны үйл ажиллагаанд магадгүй хамгийн чухал үүрэг гүйцэтгэх арилжааны төлөөлөх бүрэн эрх ба жишээ нь барааны захиалга хариуцсан ажилтан, борлуулалт хариуцсан ажилтан зэрэг нь тодорхой төрлийн хэлцэл хийх бүрэн эрхтэй этгээдэд хамаарна. Түүнээс гадна, арилжааны төлөөлөх бүрэн эрхийн зохицуулалт иргэний хуулиас давуу үйлчлэх зорилгоор тодорхой хэлцэл хийх бүрэн эрхийг ч мөн арилжааны төлөөлөх бүрэн эрхийн нэг төрөл болгон хуульчилсан байдаг.

Япон

Япон улсын Арилжааны хуульд 1) Ерөнхий төлөөлөх бүрэн эрх 2) Тодорхой төрлийн хэлцэл эсхүл тодорхой асуудлаар төлөөлөх бүрэн эрх 3) Бараа бүтээгдэхүүнийг худалдах бүрэн эрх хэмээх гурван төрлийн бүрэн эрхийг хуульчилсан байдаг.

Япон Улсын Арилжааны хууль (商法)

21 дүгээр зүйл. Ерөнхий төлөөлөх бүрэн эрхтэй этгээдийн төлөөлөх бүрэн эрх

1) Ерөнхий төлөөлөх бүрэн эрхтэй этгээд нь арилжаа эрхлэгчийн нэрийн өмнөөс тухайн арилжааны үйл ажиллагааны бүхий л шүүхийн болон шүүхийн бус хэлцлийг хийх бүрэн эрхийг эдэлнэ.

25 дугаар зүйл. Тодорхой төрлийн хэлцэл эсхүл тодорхой асуудлаар итгэмжлэл олгогдсон ажилтан

1) Арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаанд хамаарах тодорхой төрлийн хэлцэл эсхүл тодорхой асуудлаар итгэмжлэл олгогдсон ажилтан нь тухайн асуудалд хамаарах бүхий л шүүхийн бус үйлдлийг хийх бүрэн эрхтэй байна.

26 дугаар зүйл. Бараа бүтээгдэхүүнийг худалдах дэлгүүрийн ажилтан

Бараа бүтээгдэхүүнийг худалдах (Худалдан борлуулах, түрээслүүлэх зэрэг бусад төсөөтэй үйлдэл) зорилготой дэлгүүрийн ажилтан нь тухайн дэлгүүрт буй бараа бүтээгдэхүүнийг худалдах бүрэн эрхтэй гэж үзнэ.

Япон улсын Арилжааны хуульд тусгагдсан хамгийн өргөн хүрээтэй арилжааны төлөөлөх бүрэн эрх нь ерөнхий төлөөлөх бүрэн эрх бөгөөд агуулгаараа ХБНГУ-ын прокуратай адилхан. Өөрөөр хэлбэл, арилжааны төлөөлөх цогц, иж бүрэн эрх болохынхоо хувьд арилжааны үйл ажиллагаанд хамаарах бүхий л шүүхийн болон шүүхийн бус хэлцэл, үйлдлийг хийх бүрэн эрхтэй. Жишээ нь салбар төлөөлөгчийн газрын захирал эсхүл тодорхой арилжааны салбарын захирал зэрэг нь ерөнхий төлөөлөх бүрэн эрхтэй этгээд мөн. Арилжааны зорилгогүй ч арилжааны үйл ажиллагаанд хамаарах бүхий л хэлцэл, хууль ёсны үйлдэл нь ерөнхий төлөөлөх бүрэн эрхийн агуулгад хамаарна. Ерөнхий төлөөлөх

бүрэн эрхтэй этгээд нь өөрийн төлөөлөх бүрэн эрхээ бусдад шилжүүлэх боломжгүй ч бусад төрлийн арилжааны төлөөлөх бүрэн эрхийг олгож болно.

Тодорхой төрлийн хэлцэл эсхүл тодорхой асуудлаар төлөөлөх бүрэн эрх нь арилжааны үйл ажиллагаанд хамаарах тодорхой төрлийн хэлцэл, асуудлаар төлөөлөх цогц, иж бүрэн эрхийг хэлнэ. Жишээ нь гадаад худалдааны менежер, борлуулалтын албаны захирал зэрэг этгээдүүд нь тухайн хариуцсан асуудлаар бүхий л арилжааны төлөөллийг хэрэгжүүлэх боломжтой.

Бараа бүтээгдэхүүнийг худалдах бүрэн эрх нь тухайн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад хамаарах бүхий л хэлцэл, хууль ёсны үйлдлийг хийх бүрэн эрхийг хэлэх бөгөөд арилжааны төлөөлөх цогц, иж бүрэн эрх мөн.

Үр нөлөөг тооцох

ХБНГУ болон Япон Улсын арилжааны хуулийн төлөөлөх бүрэн эрхийн зохицуулалт нь арилжааны төлөөлөх цогц, иж бүрэн эрхийг хуульчилж, түүнийг төрөлжүүлэх замаар арилжааны тогтвортой, баталгаатай, түргэн шуурхай байдлыг хангадаг байна. ХБНГУ-ын хувьд Прокура, Тодорхой төрлийн хэлцэл хийх бүрэн эрх, Япон Улсын хувьд Ерөнхий төлөөлөх бүрэн эрх, Тодорхой төрлийн хэлцэл эсхүл тодорхой асуудлаар төлөөлөх бүрэн эрх нь арилжааны төлөөлөх бүрэн эрхийн гол төрөл болж өгдөг. Энэхүү арилжааны төлөөлөх бүрэн эрхийн төрлүүдийг төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 нь “тодорхой төрлийн арилжааны хэлцэл болон хууль ёсны үйлдэл” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 нь “арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрх” гэж төрөлжүүлжээ. Үүнээс үзвэл төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 болон 14.2 нь “Арилжааны төлөөлөх бүрэн эрхийг төрөлжүүлэх” зорилттой нийцэж байна гэж дүгнэж болох юм.

“Арилжааны төлөөлөх бүрэн эрх үүсэх үндэслэлийг өргөжүүлэх” зорилтын хувьд

14.5. Арилжааны үйл ажиллагаанд хамаарах ажил үүргийг хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр гүйцэтгэж байгаа ажилтан нь тухайн ажлын байрны чиг үүргийн дагуу гүйцэтгэж байгаа хууль ёсны үйлдэл, байгуулах хэлцлийн хувьд энэ хуулийн 14.3-т заасан итгэмжлэл байгаа эсэхээс үл хамааран арилжаа эрхлэгчийг төлөөлөх эрхтэй гэж үзнэ.

Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.3-т зааснаар төлөөлөх бүрэн эрх нь гагцхүү хуульд зааснаар эсхүл итгэмжлэлийн үндсэн дээр үүсэх боломжтой. Гэтэл энэ нь арилжааны түргэн шуурхай, тогтвортой байдлыг хангах үүднээс ажил үүргийн хувьд арилжааны төлөөллийг хэрэгжүүлэх шаардлагатай тохиолдолд нийцдэггүй. Улмаар, арилжааны хуулийн төлөөллийн зохицуулалтын нэгэн чухал ач холбогдол нь арилжаа эрхлэгчийн дотоод ажилтны төлөөлөх бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх явдал бөгөөд үүнийг арилжааны төлөөлөх бүрэн эрх үүсэх үндэслэлийг иргэний хуулиас өргөжүүлж буйтай дүйцүүлэн ойлгож болно.

ХБНГУ болон Япон Улсад арилжааны төлөөллийг дотоод төлөөлөл болон гадаад төлөөлөл гэж ангилсны үндсэн дээр тухайн арилжаа эрхлэгчид харьяалагдах ажилтныг дотоод төлөөлөлд хамааруулан хуульчилсан байдаг. Энэ нь гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалахын сацуу арилжаа эрхлэгчийн тухай бүрд төлөөлөх бүрэн эрх олгох зардлыг багасгах ач холбогдолтой.

ХБНГУ

ХБНГУ-ын Арилжааны хууль (HGB)

48-р зүйл

1) Прокура-г гагцхүү арилжаа эрхлэгч болон түүний хууль ёсны төлөөлөгч нь ил тод хүсэл зоригийн илэрхийллийн үндсэн дээр олгож болно.

54 дүгээр зүйл

1) Прокура олголгүйгээр арилжааг эрхлэх бүрэн эрх, тодорхой төрлийн хэлцэл хийх бүрэн эрх, эсхүл тодорхой хэлцэл хийх бүрэн эрхийг олгож болох бөгөөд энэхүү арилжааны төлөөлөх бүрэн эрх нь тухайн арилжааны үйл ажиллагааг хэвийн явуулах эсхүл тухайн хэлцлийг хийхэд шаардагдах бүх төрлийн хэлцэл болон хууль ёсны үйлдлийг хамарна.

ХБНГУ-ын арилжааны хуулийн хамгийн өргөн хүрээтэй арилжааны төлөөлөх бүрэн эрх нь прокура болохын хувьд арилжаа эрхлэгч эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь прокура-г олгож буй хүсэл зоригоо ил тодоор илэрхийлэх замаар прокура бүхий этгээдийг томилдог. Энэ хүрээнд прокураг олгож буй итгэмжлэл шаардлагатай болдог төдийгүй арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүргийг хүлээдэг. Прокура нь арилжааны дотоод төлөөлөл тул прокура бүхий этгээдтэй арилжаа эрхлэгч хөдөлмөрийн харилцаанд байх нь прокура-ийн төлөөлөх бүрэн эрхийн урьдчилсан нөхцөл болж өгдөг.

ХБНГУ-ын 54 дүгээр зүйлд тусгагдсан арилжааны төлөөлөх бүрэн эрхийг арилжааны ажилтан хэрэгжүүлэх боломжтой талаар 59-өөс 62 дугаар зүйлд хуульчилж өгсөн. Өөрөөр хэлбэл, арилжааны ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж буй нь арилжааны төлөөлөх бүрэн эрхийг олгож буй явдал бөгөөд ажилтан нь ажил үүргийн хувьд арилжааны төлөөллийг хэрэгжүүлэх боломжтой байна. Гэхдээ, арилжааны ажилтан гэж үзэхэд 1) Хөдөлмөрийн харилцаа үүссэн байх шаардлагатай ба ажилтан нь арилжаа эрхлэгчээс хараат этгээд байх 2) Арилжааны зорилгоор ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулсан байх 3) Арилжааны үйл ажиллагааны хүрээнд ажилтан хөдөлмөр эрхэлж байх 4) Ажилтан нь цалин хөлс авах эрхтэй байх гэсэн 4н урьдчилсан нөхцөл тавигддаг.

Япон Улсын Арилжааны хууль (商法)

21 дүгээр зүйл. Ерөнхий төлөөлөх бүрэн эрхтэй этгээдийн төлөөлөх бүрэн эрх

1) Ерөнхий төлөөлөх бүрэн эрхтэй этгээд нь арилжаа эрхлэгчийн нэрийн өмнөөс тухайн арилжааны үйл ажиллагааны бүхий л шүүхийн болон шүүхийн бус хэлцлийг хийх бүрэн эрхийг эдэлнэ.

25 дугаар зүйл. Тодорхой төрлийн хэлцэл эсхүл тодорхой асуудлаар итгэмжлэл олгогдсон ажилтан

1) Арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаанд хамаарах тодорхой төрлийн хэлцэл эсхүл тодорхой асуудлаар итгэмжлэл олгогдсон ажилтан нь тухайн асуудалд хамаарах бүхий л шүүхийн бус үйлдлийг хийх бүрэн эрхтэй байна.

26 дугаар зүйл. Бараа бүтээгдэхүүнийг худалдах дэлгүүрийн ажилтан

Бараа бүтээгдэхүүнийг худалдах (Худалдан борлуулах, түрээслүүлэх зэрэг бусад төсөөтэй үйлдэл) зорилготой дэлгүүрийн ажилтан нь тухайн дэлгүүрт буй бараа бүтээгдэхүүнийг худалдах бүрэн эрхтэй гэж үзнэ.

Ерөнхий төлөөлөх бүрэн эрх бүхий этгээдийг хөдөлмөрийн гэрээ болон итгэмжлэлийн үндсэн дээр томилдог. Ерөнхий төлөөлөх бүрэн эрх бүхий этгээд нь арилжааны үйл ажиллагааг гадагшаа төлөөлөх арилжаа эрхлэгчийн дотоод ажилтан мөн. Ерөнхий төлөөлөх бүрэн эрх бүхий этгээд нь арилжаа эрхлэгчийг төлөөлөх цогц, иж бүрэн эрхийг эдлэх тул компанийн хувьд илүү өндөр шаардлага тавигдаж компанийн ТУЗ-ийн шийдвэрээр ерөнхий төлөөлөх бүрэн эрхтэй этгээдийг томилох ёстой болдог. Мөн, ерөнхий төлөөлөх бүрэн эрхтэй этгээдийг арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй.

Бусад арилжааны төлөөлөх бүрэн эрхийг арилжааны ажилтанд олгох бөгөөд тухайн ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж буйг итгэмжлэл олгож буйтай дүйцүүлэн ойлгож болно. Улмаар, арилжааны ажилтан нь өөрийн ажил үүргийн хувьд арилжааны төлөөллийг хэрэгжүүлэх боломжтой. Нөгөөтээгүүр, зайлшгүй арилжааны төлөөлөх бүрэн эрхийг олгох агуулгатай итгэмжлэл олгосон байх шаардлагатай гэж тайлбарлах хандлага байх боловч гуравдагч этгээдийн зүгээс арилжааны ажилтанд итгэмжлэл олгосон эсэхийг шалгах нь арилжааны түргэн шуурхай байдалд сөргөөр нөлөөлөх тул энэхүү хандлагыг дэмжих боломжгүй юм.

Үр нөлөөг тооцох

ХБНГУ болон Япон Улсад арилжаа эрхлэгчид харьяалагдах дотоод этгээдүүд болох ажилтны арилжааны төлөөлөх бүрэн эрхийг нарийвчлан хуульчилж, ажилтны төлөөлөх бүрэн эрхээс үүсэх аливаа тодорхойгүй байдал, эргэлзээнээс урьдчилан сэргийлдэг. Ингэхдээ зарчмын хувьд итгэмжлэл олгогдсон байхыг шаарддаг боловч тухай бүрд итгэмжлэл олгох нь зардал чирэгдэл ихтэй, мөн гуравдагч этгээд ажилтанд тухайлан итгэмжлэл олгосон байхыг шалгах нь зохисгүй гэдэг үндэслэлээр ажилтан ажил үүргийн хувьд арилжааны төлөөлөх бүрэн эрхтэй байна гэж үздэг. Үүнээс үзвэл, төслийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “... бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр олгоно” гэж төлөөллийн харилцааны урьдчилсан нөхцөлийг хуульчилсны үндсэн дээр төслийн 14 дүгээр зүйлийн 14.5-д “Арилжааны үйл ажиллагаанд хамаарах ажил үүргийг хөдөлмөр эрхлэлтийн

харилцааны үндсэн дээр гүйцэтгэж байгаа ажилтан нь тухайн ажлын байрны чиг үүргийн дагуу гүйцэтгэж байгаа хууль ёсны үйлдэл, байгуулах хэлцлийн хувьд энэ хуулийн 14.3-т заасан итгэмжлэл байгаа эсэхээс үл хамааран арилжаа эрхлэгчийг төлөөлөх эрхтэй гэж үзнэ” гэж компанийн дотоод төлөөлөл болох ажилтны арилжааны төлөөлөх бүрэн эрхийг уян хатан байдлаар тусгасан нь оновчтой болжээ. Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8 нь компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхийг гагцхүү гүйцэтгэх удирдлагад олгосон байдаг нь арилжааны түргэн шуурхай байдалд сөргөөр нөлөөлдөг гэж үнэлэгдсээр ирсэн бөгөөд төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 уг асуудлыг шууд шийдвэрлэх ач холбогдолтой байж болох юм. Иймд төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 “арилжааны төлөөлөх бүрэн эрх үүсэх үндэслэлийг өргөжүүлэх” зорилтод хүрч байна гэж дүгнэж болох юм.

“Гадаад нөхцөл байдалд итгэсэн гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах” зорилтын хувьд

Иргэний хууль нь төлөөлүүлэгч болон гуравдагч этгээдийн эрх ашгийг тэнцвэржүүлэх үүднээс төлөөллийн харилцааны суурь зохицуулалтуудыг тусгаж өгдөг. Харин арилжааны хуулийн төлөөллийн тогтолцоо нь бүхэлдээ гуравдагч этгээдийн эрх ашгийг илүүд харгалзан үзэж, арилжааны тогтвортой, баталгаатай, түргэн шуурхай байдлыг хангахыг эрмэлздэг. Өөрөөр хэлбэл, арилжааны төлөөлөх бүрэн эрх аль болох олон тохиолдолд хүчин төгөлдөр байхаар арилжааны төлөөлөх цогц, иж бүрэн эрхийг хуульчилж, төлөөлөх бүрэн эрхгүй эсхүл төлөөлөх бүрэн эрхийг хязгаарласан байсан ч гадаад нөхцөл байдалд итгэсэн гуравдагч этгээдийг хамгаалах зохицуулалтуудыг тусгаж өгдөг. Энэ хүрээнд Япон Улсын зохицуулалтыг дэлгэрүүлэн авч үзэх болно.

Япон Улсны Арилжааны хууль (商法)

21 дүгээр зүйл. Ерөнхий төлөөлөх бүрэн эрх

(3) Ерөнхий төлөөлөх бүрэн эрхэд тавьсан хязгаарлалт нь тус хязгаарлалтыг мэдээгүй, эсхүл мэдэх боломжгүй байсан гуравдагч этгээдэд эрх зүйн үр дагавар үүсгэхгүй.

24 дүгээр зүйл. Илэрхий ерөнхий төлөөлөх бүрэн эрх

Арилжааны салбар байгууллагад арилжааны үйл ажиллагааг эрхлэх бүрэн эрхтэй мэт нэр ашигласан ажилтан нь тухайн салбар байгууллагын үйл ажиллагааны талаар бүхий л шүүхийн бус үйлдлийг хийх бүрэн эрхтэй гэж тооцно. Гэвч, гуравдагч этгээд нь энэ талаар мэдсэн эсхүл мэдэх боломжтой байсан тохиолдолд энэхүү зохицуулалт үйлчлэхгүй.

25 дугаар зүйл. Тодорхой төрлийн хэлцэл эсхүл тодорхой асуудлаар итгэмжлэл олгогдсон ажилтан

(2) Тодорхой төрлийн хэлцэл эсхүл тодорхой асуудлаар төлөөлөх бүрэн эрхэд тавьсан хязгаарлалт нь тус хязгаарлалтыг мэдээгүй, эсхүл мэдэх боломжгүй байсан гуравдагч этгээдэд эрх зүйн үр дагавар үүсгэхгүй.

Япон Улсын Компанийн тухай хууль (会社法)

349 дүгээр зүйл. Компанийг төлөөлөх

(4) Гүйцэтгэх захирал нь хувьцаат компанийн нэрийн өмнөөс бүхий л шүүхийн болон шүүхийн бус үйлдлийг хийх бүрэн эрхтэй байна.

(5) Өмнөх бүрэн эрхэд тавьсан хязгаарлалт нь тухайн хязгаарлалтыг мэдээгүй эсхүл мэдэх боломжгүй байсан гуравдагч этгээдэд эрх зүйн үр дагавар үүсгэхгүй.

354 дүгээр зүйл. Илэрхий гүйцэтгэх захирал

Хувьцаат компани нь гүйцэтгэх захирлаас өөр ТУЗ-ийн гишүүнд захирал, дэд захирал, эсхүл компанийг төлөөлөх эрх бүхий этгээд гэж ойлгогдохуйц нэр оноосон бол тухайн ТУЗ-ийн гишүүний хийсэн хэлцлийг энэ талаар мэдээгүй эсхүл мэдэх боломжгүй байсан гуравдагч этгээдийн өмнө хариуцна.

Арилжааны төлөөлөх бүрэн эрх нь цогц, иж бүрэн эрх гэдэг утгаараа гуравдагч этгээдийг хамгаалах ач холбогдолтой. Энэ хүрээнд өмнө дурдсан зорилтууд болох “Арилжааны төлөөлөх бүрэн эрхийг төрөлжүүлэх”, “Арилжааны төлөөлөх бүрэн эрх үүсэх үндэслэлийг өргөжүүлэх” зорилтууд нь ч мөн гадаад нөхцөл байдал буюу компанийн дотоод харилцаанд үүссэн арилжааны төлөөлөх бүрэн эрхийг мэдэх боломжгүй гуравдагч этгээдийг хамгаалах чиг үүргийг гүйцэтгэдэг.

Үүнээс гадна, арилжааны хууль гуравдагч этгээдийг 1) Арилжааны төлөөлөх бүрэн эрхэд хязгаарлалт тавьсан тохиолдол 2) Ерөнхий төлөөлөх бүрэн эрхтэй мэт цол гуншинтай тохиолдолд хамгаалах зохицуулалтуудыг тусгасан байдаг.

Арилжааны төлөөлөх бүрэн эрхэд ялангуяа ерөнхий төлөөлөх бүрэн эрхэд арилжааны төрөл, үнийн дүн, гэрээ байгуулах этгээдийн төрөл зэргээр хязгаарлалт тавихыг үгүйсгэхгүй. Гэвч ийм төрлийн хязгаарлалтыг гуравдагч этгээд шалгах боломжгүйгээс гадна ерөнхий төлөөлөх бүрэн эрхийн агуулгыг хуулиар нэг мөр тогтоосон байх тул тухайн

ерөнхий төлөөлөх бүрэн эрхэд тавьсан хязгаарлалт гуравдагч этгээдийн хувь үр дагавар үүсгэхгүй. Гэвч гуравдагч этгээд тухайн хязгаарлалтыг мэдээгүй эсхүл мэдэх боломжгүй байсан тохиолдолд л тухайн хязгаарлалт хүчингүй байна гэдгийг анхаарах нь зүйтэй. Компанийн дүрэм, хөдөлмөрийн гэрээ зэрэг дотоод баримт бичигт арилжааны төлөөлөх бүрэн эрхийг хязгаарласныг гуравдагч этгээд ихэнх тохиолдолд мэдэх боломжгүй билээ. Гуравдагч этгээд тухайн хязгаарлалтыг мэдэж байсан эсхүл мэдэх ёстой байсан гэдгийг нотлох үүргийг арилжаа эрхлэгч хүлээнэ.

Иргэний хуульд илэрхий бүрэн эрхийн тогтолцоог хуульчилж гадаад нөхцөл байдалд итгэсэн гуравдагч этгээдийг хамгаалахыг эрмэлздэг. Гэвч энэхүү илэрхий бүрэн эрхийн тогтолцоо нь ерөнхий, хийсвэр шинжтэй тул арилжааны хууль нарийвчилсан илэрхий бүрэн эрхийн тогтолцооны нэг төрөл болох илэрхий ерөнхий төлөөлөх бүрэн эрх, компанийн хууль илэрхий гүйцэтгэх захирлын зохицуулалтыг тусгаж өгсөн байдаг. Өөрөөр хэлбэл, төлөөлөх бүрэн эрхтэй мэт цол гуншинтай тохиолдолд гуравдагч этгээд тухайн этгээдийг төлөөлөх бүрэн эрхтэй гэж ойлгохоос өөр аргагүй бөгөөд энэхүү гадаад нөхцөл байдалд итгэсэн гуравдагч этгээдийн итгэл хамгаалагдах учиртай. Илэрхий ерөнхий төлөөлөх бүрэн эрхтэй гэж үзэхэд 1) Тухайн салбар байгууллагын үйл ажиллагааг эрхлэх эрхтэй мэт цол, гуншинтай байх 2) Арилжаа эрхлэгч тухайн цол, гуншинг өөрөө олгосон байх 3) Гуравдагч этгээд нь мэдээгүй эсхүл мэдэх боломжгүй байсан гэх гурван урьдчилсан нөхцөлийг хангах шаардлагатай. Мөн тодорхой төрлийн хэлцэл эсхүл тодорхой асуудлаар итгэмжлэл олгогдсон ажилтны хувьд ч илэрхий ерөнхий төлөөлөх бүрэн эрхтэй адилаар илэрхий төлөөлөх бүрэн эрх үүсэж болно.

Түүнчлэн, Илэрхий ерөнхий төлөөлөх бүрэн эрхээс гадна компанийн хууль илэрхий гүйцэтгэх захирлын зохицуулалтыг тусгаж компанийг төлөөлөх бүрэн эрхгүй ТУЗ-ийн гишүүний хийсэн хэлцлийн үр дагаврыг компанид хариуцуулж, гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалдаг.

Үр нөлөөг тооцох

Арилжааны төлөөлөх бүрэн эрхийн тогтолцоо нь өргөн утгаар бүхэлдээ гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах зорилготой бөгөөд арилжааны төлөөлөх бүрэн эрхэд хязгаарлалт тавьсан тохиолдолд болон ерөнхий төлөөлөх бүрэн эрхтэй мэт цол гуншинтай тохиолдолд гуравдагч этгээдийг хамгаалах хэрэгцээ шаардлага улам нэмэгддэг. Төслийн 14 дүгээр зүйлийн 14.9 нь "... аливаа хязгаарлалт нь гуравдагч этгээдийн хувьд ямар нэгэн эрх зүйн үр дагавар үүсгэхгүй. Гэхдээ гуравдагч этгээд нь энэ хязгаарлалтын талаар мэдсэн, эсхүл илт болгоомжгүйгээр мэдээгүй бол үүнд хамаарахгүй" гэж тусгасан нь оновчтой болжээ. Мэдээж гуравдагч этгээд мэдсэн, эсхүл илт болгоомжгүйгээр мэдээгүй гэдгийг нотлох үүргийг арилжаа эрхлэгч хүлээх учиртай. Иймд төслийн 14 дүгээр зүйлийн 14.9 нь "гадаад нөхцөл байдалд итгэсэн гуравдагч этгээдийг хамгаалах" зорилтод нийцэж байна гэж үзэж болох юм. Жич дурдахад, төсөлд илэрхий ерөнхий төлөөлөх бүрэн эрхийг тусгаагүй ч иргэний хуулийн илэрхий бүрэн эрхийн суурь зохицуулалт болон төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 "... итгэмжлэл байгаа эсэхээс үл хамааран арилжаа эрхлэгчийг төлөөлөх эрхтэй гэж үзнэ" гэх зохицуулалтын хүрээнд төлөөлөх бүрэн эрхтэй мэт цол гуншинтай тохиолдолд гуравдагч этгээдийг хамгаалах боломжтой байж болох юм.

4.4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

Дүгнэлт

Арилжааны төлөөлөх бүрэн эрхийн зохицуулалт нь иргэний хуулиас ялгагдах, нарийвчилсан арилжааны төлөөлөх бүрэн эрхийн тогтолцоог бүрдүүлэхдээ “Арилжааны төлөөлөх бүрэн эрхийг төрөлжүүлэх”, “Арилжааны төлөөлөх бүрэн эрх үүсэх үндэслэлийг өргөжүүлэх”, “гадаад нөхцөл байдалд итгэсэн гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах” гэсэн зорилтуудыг хангаж байх учиртай.

“Арилжааны төлөөлөх бүрэн эрхийг төрөлжүүлэх” гэдэг нь арилжааны цогц, иж бүрэн төлөөлөх бүрэн эрхийг хуульчлах явдал бөгөөд ХБНГУ-аас иш татвал прокура болон тодорхой төрлийн хэлцэл хийх бүрэн эрх, Япон Улсаас иш татвал ерөнхий төлөөлөх бүрэн эрх болон Тодорхой төрлийн хэлцэл эсхүл тодорхой асуудлаар төлөөлөх бүрэн эрхтэй агуулга нэг арилжааны төлөөлөх бүрэн эрхийг хуульчилж буйг арилжааны төлөөлөх бүрэн эрхийг төрөлжүүлж байна гэж үзэж болно.

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 тодорхой төрлийн арилжааны хэлцэл хийх бүрэн эрхийг, 14 дүгээр зүйлийн 14.2 арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрхийг хуульчилсан нь “арилжааны төлөөлөх бүрэн эрхийг төрөлжүүлэх” зорилтод нийцжээ.

“Арилжааны төлөөлөх бүрэн эрх үүсэх үндэслэлийг өргөжүүлэх” гэдэг нь арилжаа эрхлэгчийн дотоод ажилтны төлөөлөх бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх явдал бөгөөд ХБНГУ болон Япон Улсад арилжааны дотоод төлөөлөл гэх агуулгын хүрээнд ажилтны арилжааны төлөөлөх бүрэн эрхийг хуульчилж, тухайлан итгэмжлэл олгогдоогүй байсан ч ажилтныг төлөөлөх бүрэн эрхтэй гэж үзэх нь энэхүү зорилтын агуулгыг илэрхийлнэ.

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 нь “... хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр гүйцэтгэж байгаа ажилтан нь тухайн ажлын байрны чиг үүргийн дагуу гүйцэтгэж байгаа хууль ёсны үйлдэл, байгуулах хэлцлийн хувьд ... итгэмжлэл байгаа эсэхээс үл хамааран арилжаа эрхлэгчийг төлөөлөх эрхтэй гэж үзнэ” гэж хуульчилсан нь “арилжааны төлөөлөх бүрэн эрх үүсэх үндэслэлийг өргөжүүлэх” зорилтыг хангаж байна.

“Гадаад нөхцөл байдалд итгэсэн гуравдагч этгээдийг хамгаалах” гэдэг нь арилжааны төлөөлөх бүрэн эрхийг хязгаарласан гэдгийг гуравдагч этгээд мэдээгүй болон тухайн этгээд төлөөлөх бүрэн эрхтэй мэт цол, гуншнаас шалтгаалаад гуравдагч этгээд төлөөлөх бүрэн эрхтэй гэж итгэсэн тохиолдолд гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалж, арилжааны хэлцлийг хүчин төгөлдөрт тооцох агуулга юм.

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.9 “аливаа хязгаарлалт нь гуравдагч этгээдийн хувьд ямар нэгэн эрх зүйн үр дагавар үүсгэхгүй” гэж гуравдагч этгээдийг хамгаалахыг зорьсон байгаа бөгөөд төслийн 14 дүгээр зүйлийн 14.5-аар дамжуулан илэрхий бүрэн эрхийн тохиолдолд гуравдагч этгээдийг хамгаалах боломжийг тусгаж өгчээ. Иймд “гадаад нөхцөл байдал итгэсэн гуравдагч этгээдийг хамгаалах” зорилт хангагдаж байна гэж үзэж болно.

Дээрхээс үзвэл арилжааны хуулийн төслийн арилжааны төлөөлөх бүрэн эрхийн бүлэг нь арилжааны хуулийн төлөөлөх бүрэн эрхийн гол ач холбогдол, зорилтуудыг хангахуйц хэмжээнд нарийвчилсан, боловсронгуй зохицуулалтуудыг тусгаж өгсөн байх ба улмаар арилжааны тогтвортой, баталгаатай, түргэн шуурхай байдалд эерэг үр нөлөөг бий болгохоор байна гэж дүгнэж болно.

Жич дурдахад арилжааны төлөөлөх бүрэн эрх нь цогц, иж бүрэн төлөөлөх бүрэн эрх болохын хувьд арилжааны төлөөлөх бүрэн эрхтэй этгээд нь арилжаа эрхлэгчийн эрх ашигт харш байдлаар бүрэн эрхээ урвуулан ашиглах, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зэргээр арилжаа эрхлэгчийг хохироох эрсдэлтэй байхыг үгүйсгэхгүй. Арилжаа эрхлэгч нь өөрийн эрх ашигт харшилсан ирээдүйд бий болзошгүй бүхий л эрсдэлүүдийг урьдчилан тооцоолох

боломжгүй бөгөөд үүнийг тохиролцоонд тусгах нь арилжаа эрхлэгчийн хувьд хэт өндөр зардалтай байж болно. Иймд үл өрсөлдөх үүрэг, үнэнч байх үүрэг зэрэг ерөнхий агуулгатай, өргөн хүрээтэй үүргийг арилжааны төлөөлөх бүрэн эрхтэй этгээдэд хүлээлгэх агуулгыг хуульд тусгаж өгөх нь оновчтой байж болох юм. Гэхдээ энэ төрлийн үүрэг нь арилжааны хүчин төгөлдөр байдалд нөлөө үзүүлэхгүйгээр гагцхүү арилжаа эрхлэгчийн хохирол шаардах эрхийн үндэслэл болдог тул арилжааны хуулийн төлөөлөх бүрэн эрхийн тогтолцооны шууд зорилтод хамааралгүй гэж үзэн дэлгэрүүлэн авч үзээгүй билээ.

Зөвлөмж

Дээр дурдсанаар төслийн арилжааны төлөөлөх бүрэн эрхийн бүлэг зохицуулалтууд нь арилжааны хуулийн зорилго, зохих зорилтууддаа хүрч байх тул энэхүү хэсэгт зөвлөмж бус цаашид анхаарч болох асуудлуудыг дурдлаа.

- Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.3-т тодорхой төрлийн хэлцэл хийх бүрэн эрх эсхүл тодорхой хэлцэл болон хууль ёсны үйлдлийг хийх бүрэн эрхийг арилжаа эрхлэгч эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч олгохоор хуульчилсан байна. Тодорхой төрлийн хэлцэл хийх бүрэн эрх болон тодорхой хэлцэл хийх бүрэн эрх нь арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрхтэй харьцуулахад явцуу хүрээтэй, мөн олон тоогоор олгогдох шаардлагатай байхыг үгүйсгэхгүй тул тус бүрэн эрхийг олгох этгээдийг гагцхүү арилжаа эрхлэгч болон түүний хууль ёсны төлөөлөгчөөр хязгаарлах нь оновчгүй байж болно.

- Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 нь арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь явуулах бүрэн эрхийг хувиараа арилжаа эрхлэгч олгохоор зохицуулсан. Хуулийн этгээдийн хувьд “арилжааны үйл ажиллагааг бүхэлд” нь гэх агуулгаар бус арилжааны үйл ажиллагааны салбар байгууллага эсхүл салбарыг бүхэлд нь явуулах бүрэн эрхийг олгож болно гэх агуулгыг нэмэлтээр тусгаж өгөх нь тохиромжтой байж болох юм.

- Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 болон 14.4 нь арилжааны төлөөлөх бүрэн эрхийг олгох хэлбэрийг гагцхүү бичгээр олгосон итгэмжлэлээр хязгаарлажээ. Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр итгэмжлэлийг цахим хэлбэрээр олгож болохоор зохицуулсан. Энэ хүрээнд Иргэний хуулийн суурь зохицуулалтад нийцүүлэн “амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдсэнээр төлөөлөгчид бүрэн эрх олгож болно” гэх итгэмжлэл олгох бусад хэлбэрийг тусгаж болох юм.

- Төслийн 14 дүгээр зүйлийн 14.5-ийн 2 дахь өгүүлбэр “Нөхөрлөлийг удирдах төлөөлөх эрхтэй гишүүн, Компанийн тухай хуулийн 83.8-д заасан гүйцэтгэх захирал үүнд хамаарахгүй” гэжээ. Тус этгээдүүдийн төлөөлөх бүрэн эрх нь хуулийн этгээдийн органы хувьд төлөөлөх бүрэн эрх бөгөөд 14 дүгээр зүйлийн 14.5-ийн өмнөх өгүүлбэртэй холбон ойлговол тус этгээдүүдэд төлөөлөх бүрэн эрх олгоход итгэмжлэл шаардлагатай гэж ойлгогдохоор байх бөгөөд ерөөс арилжаа эрхлэгчийн дотоод ажилтны бүрэн эрхийн асуудалтай уялдахгүй байна гэж хэлж болно. “Үүнд хамаарахгүй” гэдэг диспозицийн агуулга тодорхойгүй байх тул 14 дүгээр зүйлийн 14.5-ийн 2 дахь өгүүлбэрийг нэг бол тусад нь зүйл, заалтаар нэмж агуулгыг тодорхойлох эсхүл хасах нь оновчтой байж болох юм.

- Төслийн 14 дүгээр зүйлийн 14.8 нь арилжааны төлөөлөх бүрэн эрхтэй этгээд нь Иргэний хуулийн 231 дүгээр зүйлд заасан аргаар үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээхгүй байх хязгаарлалтыг тусгажээ. Иргэний хуулийн 231 дугаар зүйл нь үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг бүхэлд нь жагсаан хуульчилсан зохицуулалт учир арилжааны төлөөлөх бүрэн эрхтэй этгээд нь огтоос үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээх боломжгүй болохоор байна. Энэ нь ХБНГУ болон Япон улсын арилжааны хуульд тусгагдсан хязгаарлалттай харьцуулахад

хэт өргөн хүрээтэй байгаа бөгөөд арилжааны төлөөлөх бүрэн эрхтэй этгээд нь огтоос үүргийн гүйцэтгэлийг хангах асуудлаар төлөөлөх бүрэн эрхгүй гэж үзвэл гуравдагч этгээд эрсдэлээ бага байлгах үүднээс арилжааны төлөөлөх бүрэн эрхтэй этгээдээс зайлсхийж арилжаа эрхлэгчтэй шууд хэлцэл байгуулахыг илүүд үзэх гэсэн сэдлийг бий болгож магадгүй юм. Энэ нь эргээд арилжааны төлөөлөх бүрэн эрхийн тогтолцооны ач холбогдлыг үгүй хийх эрсдэлтэй.

- Өмнөх асуудалтай холбогдуулан авч үзвэл ХБНГУ-ын арилжааны хуулийн 49.2 болон 54.2 дугаар зүйлийн хязгаарлалт нь заавал дагаж мөрдөх шинжтэй бус, тохиролцоогоор өөрчлөх боломжтой дефолт зохицуулалт бөгөөд арилжаа эрхлэгч тухайлан эрх олгосон тохиолдолд арилжааны төлөөлөх бүрэн эрхтэй этгээд нь үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжтой байна. Иймд, төслийн 14 дүгээр зүйлийн 14.8-ийг арилжаа эрхлэгч зөвшөөрөл олгосон тохиолдолд үйлчлэхгүй байхаар дефолт зохицуулалт болгож хувиргах нь тохиролцооны зардлыг бууруулах ач холбогдолтой байж болох юм. Хэрэв, үл хөдлөх хөрөнгө захиран зарцуулах, вексель үйлдэх, зээлийн гэрээ байгуулах, аливаа маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөх хязгаарлалтыг заавал дагаж мөрдөх шинжтэй байх ёстой гэж үзвэл дор хаяж Иргэний хуулийн 231 дүгээр зүйлд заасан үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээх асуудлаар арилжаа эрхлэгчээс зөвшөөрөл олгосон тохиолдолд төлөөлөх бүрэн эрхтэй байхаар дефолт зохицуулалт болгон өөрчлөн найруулах нь оновчтой байж болно.

- Арилжааны төлөөлөх бүрэн эрх нь цогц, иж бүрэн эрх тул арилжаа эрхлэгч болон төлөөлөх бүрэн эрхтэй этгээдийн хооронд нэгэн төрлийн итгэлцлийн харилцаа үүсдэг бөгөөд үүнд тохирсон ерөнхий үүргийг арилжааны хуульд тусгадаг. Уг ерөнхий үүрэгт үл өрсөлдөх үүрэг болон хүчин чармайлт гаргах үүрэг хамаарна. Үл өрсөлдөх үүрэг нь арилжааны төлөөлөх бүрэн эрхтэй этгээд өөрийн эсхүл гуравдагч этгээдийн эрх ашгийн төлөө арилжааны төлөөлөх бүрэн эрхээ хэрэгжүүлэх явдлыг хориглодог. Хүчин чармайлт гаргах үүрэг нь арилжааны төлөөлөх бүрэн эрхтэй этгээд өөрөө бие даан арилжааны үйл ажиллагааг явуулах, бусад арилжаа эрхлэгчийн ажилтан болох зэрэг явдлыг хориглодог. Ийм төрлийн ерөнхий үүргийг арилжааны хуульд нэгдсэн байдлаар тусгах нь тухайлсан төлөөллийн харилцаа бүрд үүсэж болох зардлыг хэмнэх ач холбогдолтой.

V. АРИЛЖААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ, ЗУУЧЛАГЧИЙН ЗОХИЦУУЛАЛТ

5.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 6 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Зардал³⁹

³⁹ Журмын төслийн “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийг Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоо сэдэвт судалгаа гүйцэтгэсэн байх тул дэлгэрэнгүйг тус судалгаанаас үзнэ үү.

6. Харилцан уялдаа

Эдгээрээс зардлын тооцоог бие даасан судалгаагаар хийх тул уг үр нөлөөний үнэлгээний хүрээнд авч үзээгүй болно.

5.2. Хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсгээ тогтоох

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын гуравдугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн тодорхой зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг нь үнэлнэ. Тухайн зохицуулалтыг сонгохдоо мөн зүйлийн 3.2-т заасны дагуу “гол ач холбогдолтой зохицуулалтыг олж тогтоох нь зүйтэй бөгөөд тухайн зохицуулалт бодитой судалгаа хийж болохуйц байх шаардлагатай” гэснийг урьдчилсан нөхцөл болголоо.

Тус хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл бөгөөд өмнө нь Иргэний хуулиар зохицуулагдаж байгаа арилжааны гэрээний зохицуулалтыг Арилжааны ерөнхий хуулийн төсөлд шинээр системчилсэн байна. Ингэхдээ Иргэний хуулийн тусгай ангийн гучин есдүгээр бүлэг буюу зуучлалын хэсэгт хамаарч байгаа худалдааны зуучлал, худалдааны төлөөлөгч, комиссын гэрээний зохицуулалтыг Арилжааны ерөнхий хуульд дараах байдлаар шинээр системчилсэн байна.

Арилжааны ерөнхий хуулийн төсөл
I ХЭСЭГ - ЕРӨНХИЙ АНГИ ЗУРГАДУГААР БҮЛЭГ. АРИЛЖААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ 15 дугаар зүйл.Арилжааны төлөөлөгч 16 дугаар зүйл.Арилжааны төлөөлөгчийн үүрэг 17 дугаар зүйл.Үйлчлүүлэгчийн үүрэг 18 дугаар зүйл.Арилжааны төлөөлөгчийн хөлс 19 дүгээр зүйл.Арилжааны төлөөлөгчтэй байгуулах гэрээний хугацаа 20 дугаар зүйл.Арилжааны төлөөлөгчид олгох нөхөн олговор 21 дүгээр зүйл.Арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүрэг
I ХЭСЭГ - ЕРӨНХИЙ АНГИ ДОЛДУГААР БҮЛЭГ. АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ 22 дугаар зүйл.Арилжааны зуучлагч 23 дугаар зүйл.Хэлцлийн талыг нэрлэн заагаагүй зуучлагчийн баримт 24 дүгээр зүйл.Барааны дээжийг хадгалах 25 дугаар зүйл.Үүргийн гүйцэтгэлийг хүлээж авах эрхгүй байх 26 дугаар зүйл.Талуудын өмнө хүлээх хариуцлага 27 дугаар зүйл.Хэлцлийн талуудаас хөлс шаардах эрх 28 дугаар зүйл.Арилжааны зуучлагчийн хөтлөх тэмдэглэл

II ХЭСЭГ – ТУСГАЙ АНГИ

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ. КОМИСС

61 дүгээр зүйл.Комисс

62 дугаар зүйл.Комиссын үүрэг

63 дугаар зүйл.Комиссын байгуулсан хэлцлээс үүссэн шаардах эрх

64 дүгээр зүйл.Комиссын хөлс, зайлшгүй зардал, тусгай хөлс

65 дугаар зүйл.Комиссын барьцааны эрх

66 дугаар зүйл.Комисс гэрээний нэг тал болох эрх

Тиймээс энэ хэсэгт дээрх 6 шалгуурын дагуу, “Арилжааны ерөнхий хууль”-ийн төслийн Зургадугаар бүлэг, Долдугаар бүлэг, Арван гуравдугаар бүлгийг сонгон авч, түүний үр нөлөөг системчлэлийн хүрээнд үнэлнэ.

5.3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөө тооцох

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэх байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх учраас тодорхой байгууллага, иргэний эрх ашиг хөндөгдөж буй зохицуулалтыг сонгон авах нь зүйтэй.

Харин Арилжааны ерөнхий хуулийн төсөл дэх арилжааны төлөөлөгч, арилжааны зуучлагч, комиссын зохицуулалт нь агуулгын хувьд хүчин төгөлдөр үйлчилж байгаа Иргэний хуулийн зохицуулалтаас рецепц хийсэн шинжтэй байна.

Иргэний хууль, 2002

Арилжааны ерөнхий хуулийн төсөл

ГУЧИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ЗУУЧЛАЛ Хоёрдугаар дэд бүлэг. Худалдааны зуучлагч, комисс 415 дугаар зүйл. Худалдааны төлөөлөгч, ... 416 дугаар зүйл. Хөлс, шагнал, шимтгэлийн хэмжээ 417 дугаар зүйл. Худалдааны төлөөлөгч,.... байгуулах гэрээний хугацаа 418 дугаар зүйл. Худалдааны төлөөлөгчид олгох нөхөн олговор 419 дүгээр зүйл. Хариуцлага	ЗУРГАДУГААР БҮЛЭГ. АРИЛЖААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ 15 дугаар зүйл.Арилжааны төлөөлөгч 16 дугаар зүйл.Арилжааны төлөөлөгчийн үүрэг 17 дугаар зүйл.Үйлчлүүлэгчийн үүрэг 18 дугаар зүйл.Арилжааны төлөөлөгчийн хөлс 19 дүгээр зүйл.Арилжааны төлөөлөгчтэй байгуулах гэрээний хугацаа 20 дугаар зүйл.Арилжааны төлөөлөгчид олгох нөхөн олговор 21 дүгээр зүйл.Арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүрэг
ГУЧИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ЗУУЧЛАЛ Хоёрдугаар дэд бүлэг. Худалдааны зуучлагч, комисс 413 дугаар зүйл. Худалдааны зуучлагч 414 дүгээр зүйл. Худалдааны зуучлагчийн хөтлөх тэмдэглэл	ДОЛДУГААР БҮЛЭГ. АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ 22 дугаар зүйл.Арилжааны зуучлагч 23 дугаар зүйл.Хэлцлийн талыг нэрлэн заагаагүй зуучлагчийн баримт 24 дүгээр зүйл.Барааны дээжийг хадгалах 25 дугаар зүйл.Үүргийн гүйцэтгэлийг хүлээж авах эрхгүй байх 26 дугаар зүйл.Талуудын өмнө хүлээх хариуцлага 27 дугаар зүйл.Хэлцлийн талуудаас хөлс шаардах эрх 28 дугаар зүйл.Арилжааны зуучлагчийн хөтлөх тэмдэглэл
ГУЧИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ЗУУЧЛАЛ Хоёрдугаар дэд бүлэг. Худалдааны зуучлагч, комисс 415 дугаар зүйл.комисс 416 дугаар зүйл. Хөлс, шагнал, шимтгэлийн хэмжээ 417 дугаар зүйл....комисстой байгуулах гэрээний хугацаа 419 дүгээр зүйл. Хариуцлага	АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ. КОМИСС 61 дүгээр зүйл.Комисс 62 дугаар зүйл.Комиссын үүрэг 63 дугаар зүйл.Комиссын байгуулсан хэлцлээс үүссэн шаардах эрх 64 дүгээр зүйл.Комиссын хөлс, зайлшгүй зардал, тусгай хөлс 65 дугаар зүйл.Комиссын барьцааны эрх 66 дугаар зүйл.Комисс гэрээний нэг тал болох эрх

Иймд “Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур, “Практикт хэрэгжих боломж” шалгуур, “Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур, “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзлээ.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бид тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг. Тус хуулийн төслийн хүрээнд арилжааны төлөөлөгч, арилжааны зуучлагч, комиссын зохицуулалт нь системчлэлийн хувьд Арилжааны ерөнхий хуулийн төсөлтэй уялдаж, нийцэж буй эсэх талаар шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх нь ач холбогдолтой гэж үзлээ.

Арилжааны ерөнхий хуулийн төсөл нь системчлэлийн хувьд ерөнхий анги буюу ерөнхий үндэслэл, тусгай анги буюу арилжаа хэлцэл гэсэн хэсэгтэй боловсруулагдсан байна. Ингэхдээ арилжааны төлөөлөгч, арилжааны зуучлагчийн зохицуулалтыг ерөнхий үндэслэл хэсэгт тусгасан байна. Харин комиссын зохицуулалт тусгай анги буюу арилжааны хэлцэл хэсэгт тусгажээ (хүснэгт №5).

Хүснэгт №5. Арилжааны ерөнхий хуулийн төслийн системчлэл

Ерөнхий анги	Тусгай анги
I хэсэг ерөнхий үндэслэл	II хэсэг арилжааны хэлцэл
Нэгдүгээр бүлэг нийтлэг үндэслэл,	Наймдугаар бүлэг нийтлэг үндэслэл
Хоёрдугаар бүлэг арилжааны харилцаанд оролцогч	есдүгээр бүлэг худалдах, худалдан авах гэрээ
Гуравдугаар бүлэг арилжааны бүртгэл	Аравдугаар бүлэг мөнгөн зээлийн үйл ажиллагаа
Дөрөвдүгээр бүлэг арилжааны нэр	Арван нэгдүгээр бүлэг санхүүгийн түрээс /лизинг/
Тавдугаар бүлэг арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрх	Арван хоёрдугаар бүлэг франчайз, мерчандайз
Зургадугаар бүлэг арилжааны төлөөлөгч	Арван гуравдугаар бүлэг комисс
Долдугаар бүлэг арилжааны зуучлагч	Арван дөрөвдүгээр бүлэг аялал жуулчлал
-	Арван тавдугаар бүлэг илгээмжийн гэрээ
-	Арван зургадугаар бүлэг тээвэрлэлт
-	Арван долдугаар бүлэг хадгалалт
-	Арван наймдугаар бүлэг даатгал
-	Арван есдүгээр бүлэг зээл тооцооны үүрэг
-	Хорьдугаар бүлэг тооцоо нийлэх

-	Хорин нэгдүгээр бүлэг бусад зүйл
---	----------------------------------

Арилжааны төлөөлөгч, арилжааны зуучлагч, комисс нь арилжаа эрхлэгч бусад этгээдтэй арилжааны харилцаанд ороход түүнийг төлөөлөх, зуучлах чиг үүргийг гүйцэтгэдэг бие даасан эрхлэгч байдгаараа онцлог юм. Энэ ч утгаараа хуулийн төслийн тавдугаар бүлэгт заасан арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрхээс ялгаатай нь түүний бүтцэд хамаарахгүй буюу ажилтан биш байдаг.

Уг хуулийн төсөл дэх арилжааны төлөөлөгч, арилжааны зуучлагч, комиссын зохицуулалтын хүрээнд дараах хоёр асуудлыг хөндөж болохоор байна.

Нэгдүгээрт арилжааны зуучлагчийг ерөнхий ангид тусгах эсэх

Хуулийн төслийн ерөнхий анги дахь арилжааны зуучлагч нь тодорхойлох боломжгүй олон тооны этгээдтэй арилжааны зуучлалын гэрээ байгуулах замаар зуучлалын үйлчилгээ үзүүлдэг. Энэ шинжээрээ тодорхой этгээдтэй арилжааны төлөөлөгчийн гэрээ байгуулах замаар төлөөлөх үйлчилгээ үзүүлдэг арилжааны төлөөлөгчийн ойлголтоос ялгаатай. Улмаар арилжааны зуучлагчийн гэрээг Арилжааны хуулийн төслийн тусгай ангид гэрээний төрөл байдлаар хуульчлах нь оновчтой.

Гэсэн хэдий ч, Арилжааны зуучлагчийн талаар Арилжааны ерөнхий хуулийн төслийн долдугаар бүлэг буюу ерөнхий ангид тусгасан байна. Энэ нь хуулийн төслийн системчлэлийн хувьд ойлгомжгүй болгожээ. Бусад улсын зохицуулалтыг авч үзвэл арилжааны төлөөлөгчийн талаар Арилжааны хуулийн ерөнхий ангид тусгасан байх боловч, арилжааны зуучлагчийн талаар тусгай ангид хуульчилсан байна⁴⁰.

Хүснэгт №6. Арилжааны төлөөлөгч, арилжааны зуучлагч, комиссын зохицуулалтын системчлэл

	Япон Улс	Герман Улс
Арилжааны төлөөлөгч	Ерөнхий анги Долдугаар бүлэг	Ерөнхий анги Долдугаар бүлэг
Арилжааны зуучлагч	Тусгай анги Тавдугаар бүлэг	Ерөнхий анги Наймдугаар бүлэг
Комисс	Тусгай анги Зургадугаар бүлэг	Тусгай анги Гуравдугаар бүлэг

Мөн арилжааны зуучлагчийн ерөнхий зохицуулалт нь Иргэний хуулийн тусгай ангийн 410 дугаар зүйлд Зуучлалын гэрээ болохыг анхаарах шаардлагатай. Түүнчлэн арилжааны зуучлагч болон комисс нь тодорхойлох боломжгүй олон тооны этгээдэд үйлчилдэг байх боловч, комиссын зохицуулалтыг тусгай ангид арилжааны зуучлагчийн зохицуулалтын ерөнхий ангид тусгах нь зохимжгүй байна.

⁴⁰ Хүснэгт №6-аас Япон Улсын үзнэ үү.

Иймээс урьдчилан тодорхойлох боломжгүй олон тооны этгээдэд үйлчилдэг арилжааны зуучлагчийн зохицуулалтыг гэрээний зохицуулалтын хэсэгт буюу тусгай ангид тусгах нь зүйтэй.

Хоёрдугаарт комиссыг тусгай ангид тусгах эсэх

Өөрийн нэрийн өмнөөс, гэхдээ бусдын зардлаар барааг борлуулж, эрх хэрэгжүүлэх этгээдийг комисс гэнэ. Комиссыг бусдад үйлчил байгаа шинжээр нь дараах байдлаар хоёр ангилж болно.

- 1) Тодорхой этгээдэд үйлчилдэг комисс;
- 2) Тодорхой бус этгээдэд үйлчилдэг комисс.

Арилжааны ерөнхий хуулийн төслийн арван гуравдугаар бүлэгт тусгалаа олсон комиссын зохицуулалт нь Иргэний хуулийн 415-419 дүгээр зүйлд заасан комиссын зохицуулалтаас рецепц хийсэн шинжтэй байна. Иргэний хуулийн 415-419 дүгээр зүйлийн заалтаас үзэхэд комиссын зохицуулалт нь арилжааны төлөөлөгчийн зохицуулалттай хамт байхаас гадна үйлчлүүлэгчийн сонирхлыг сайтар хамгаалсан байдлаас үзэхэд тодорхой этгээдэд үйлчилдэг комисс хэмээн дүгнэж болохоор байна.

Гэсэн хэдий ч, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа комисс нь тодорхой бус этгээдэд үйлчилж байна. Тухайлбал, интерном, легалдата зэрэг бүх төрлийн номын дэлгүүр, өргөө, тэнгис зэрэг кинотеатр, шоппи.мн, ардшоп зэрэг онлайн дэлгүүр зэргийг дурдаж болно.

Харин бусад улсын зохицуулалтыг авч үзвэл тодорхой бус олон тооны этгээдэд үйлчилдэг комиссын талаар түлхүү зохицуулсан байх бөгөөд Арилжааны хуулийн тусгай ангид тусгасан байна (Хүснэгт №7).

Хүснэгт №7. Тодорхой бус этгээдэд үйлчлэх комиссын системчлэл

	Япон Улс	Герман Улс
Комисс	Тусгай анги Зургадугаар бүлэг	Тусгай анги Гуравдугаар бүлэг

Иймээс хуулийн төсөл дэх комиссын зохицуулалт нь тодорхой этгээдэд үйлчилдэг комисс эсхүл тодорхой этгээдэд үйлчилдэг комиссын харилцааны алинд нь чиглэсэн болохыг магадлах замаар Монгол Улсын комиссын онцлогт нийцүүлэн тодорхой бусад этгээдэд үйлчилдэг комиссын зохицуулалтыг бэхжүүлэх шаардлагатай. Комиссын зохицуулалтын системчлэлийн хувьд тодорхой бус этгээдэд үйлчилдэг комиссын зохицуулалтыг тусгай ангид тусгах нь бусад улсын адилаар зохистой байна.

Түүнчлэн хуулийн төслийн арван тавдугаар бүлэг дэх илгээмжийн гэрээ нь комиссын гэрээний тусгай төрөл тул түүнийг системчлэлийн хувьд комиссын гэрээний зохицуулалтыг араас үргэлжлүүлэх тусгах буюу арван дөрөвдүгээр бүлэгт оруулах нь зохистой.

5.4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

Уг үнэлгээний тулгуурлан дараах зөвлөмжийг боловсруулав.

- Арилжааны ерөнхий хуулийн төслийн I хэсэгт туссан тодорхойгүй этгээдэд үйлчилдэг арилжааны зуучлагчийн зохицуулалтыг I хэсэгт гэрээний зохицуулалтын хэсэгт тусгах нь зүйтэй.

- Арилжааны хуулийн төслийн арван тавдугаар бүлэг дэх илгээмжийн гэрээ нь комиссын гэрээний тусгай төрөл тул түүнийг системчлэлийн хувьд комиссын гэрээний зохицуулалтыг араас үргэлжлүүлэх тусгах буюу арван дөрөвдүгээр бүлэгт оруулах нь зохистой.

VI. АРИЛЖААНЫ ХЭЛЦЭЛ

Арилжааны хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад дурдсанаар арилжааны эрх зүй нь хувийн эрх зүйн салбар боловч Иргэний эрх зүйгээс ялгарах зарим онцлог зарчимтай. Үүнд арилжаа эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах, гадаад нөхцөл байдалд үнэнч шударгаар итгэсэн итгэлийг хамгаалах, арилжаа эрхлэгч нь үүргээ биелүүлэхдээ мэргэшсэн, анхаарал болгоомжтой хандах зэрэг зарчмыг удирдлага болгодог.

Арилжааны хуулийн төслийн II хэсэгт арилжааны хэлцлийг зохицуулсан бөгөөд есдүгээр бүлгээс эхлэн хорьдугаар бүлгийн хооронд нийт 11 үндсэн гэрээний төрлийг тусгасан. Эдгээр нь 2002 оны Иргэний хуульд тусгагдсан бөгөөд хууль санаачлагчийн зүгээс тэдгээрт зарчмын болон хэлбэрийн шинжтэй өөрчлөлтүүд оруулж, заримыг нь одоогийн Иргэний хуульд зохицуулагдсан тэр хэвээр төсөлд тусган оруулжээ. Доорх хүснэгтэд Иргэний хуультай харьцуулахад өөрчлөлт оруулсан болон оруулаагүй агуулгаар гэрээний төрлийг ангилан харуулав. Төслийн дэлгэрэнгүй танилцуулгад өөрчлөлт бүхий зохицуулалт, түүний агуулгын талаар дэлгэрэнгүй тусгасан тул энэхүү үнэлгээний хүрээнд тэдгээрийг дэлгэрүүлэн дурдаагүй болно.

Хүснэгт №8: Иргэний хуулийн зохицуулалттай харьцуулахад төсөлд өөрчлөлт оруулсан болон оруулаагүй гэрээний төрөл

Өөрчлөлт оруулсан	Өөрчлөлт оруулаагүй
• Худалдах, худалдан авах гэрээ • Санхүүгийн түрээсийн гэрээ • Франчайзын гэрээ • Комисс • Аялал жуулчлалын гэрээ • Илгээмжийн гэрээ • Тээвэрлэлтийн гэрээ • Тооцоо нийлэх гэрээ • Хадгалалтын гэрээ	• Мерчандайзын гэрээ • Даатгалын гэрээ • Төлбөр тооцооны гэрээ

Энэхүү бүлгийн зорилго нь Арилжааны хуулийн төслийн тусгай ангид заасан зарим төрлийн гэрээний зохицуулалтыг боловсронгуй болгох саналыг судалгааны ажлууд, шүүхийн шийдвэр болон зарим гадаад орны харьцуулалт дээр тулгуурлан дэвшүүлэхэд чиглэнэ. Ингэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” -ыг баримтлан дараах үе шаттайгаар гүйцэтгэв:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

6.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох

Арилжааны хэлцэл бүлгийн зарим гэрээний зохицуулалтын хүрээнд үнэлгээг гүйцэтгэхдээ төслийн зохицуулах харилцаа, зарчимд тулгуурлан, аргачлалд заасны дагуу дараах шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж

“Зорилгод хүрэх байдал” шалгуурын хүрээнд одоогийн Иргэний хуульд тусгагдан хэрэгжиж буй арилжаа эрхлэгчид хамаарах зарим төрлийн гэрээний зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөл рүү шилжүүлэн тусгахдаа арилжааны эрх зүйн суурь зарчмуудыг удирдлага болгон, Иргэний хуулийн үйлчлэлийн хүрээнд тулгарч байсан асуудал, дутагдлыг шийдвэрлэж, зохицуулалтыг боловсронгуй болгосон эсэхэд үнэлгээ хийхэд чиглэнэ.

Энэхүү үнэлгээ нь арилжааны хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа, төслийн танилцуулга, төслийн ерөнхий ангийн суурь зохицуулалтыг үндэслэсэн.

“Практикт хэрэгжих боломж” шалгуурын хүрээнд одоо Иргэний хуулиар зохицуулж буй, цаашид Арилжааны хуулиар зохицуулж байхаар төсөлд тусгасан “Санхүүгийн түрээсийн гэрээ”, “Илгээмжийн гэрээ”, “Франчайзын гэрээ”, “Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээ” зэргийн хүрээнд эдгээр зохицуулалтын Иргэний хуулийн үйлчлэлийн явцад практикт хэрэгжихэд тулгамдаж байсан асуудлыг Арилжааны хуулийн төсөлд зохицуулахдаа шийдвэрлэсэн эсэхийг авч үзнэ.

6.2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын гуравдугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн тодорхой зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг үнэлэх ба ийнхүү сонгохдоо аргачлалын 3.2-т заасны дагуу “гол ач холбогдолтой зохицуулалтыг олж тогтоох ...” нөхцөлийг шалгуур болголоо. Арилжааны хуулийн төслийн “арилжааны хэлцэл” хэсгийн зохицуулалт нь 2002 оны Иргэний хуулиар зохицуулагдаж ирсэн, уг мөн чанартаа Арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааныхаа явцад түгээмэл хэрэглэх гэрээний зохицуулалтыг Арилжааны хууль руу шилжүүлэн тусгах зорилготой. Иймд төслийн II хэсэг Арилжааны хэлцэлээс арван нэгдүгээр бүлэгт заасан Санхүүгийн түрээс, арван хоёрдугаар бүлэгт заасан франчайз, арван тавдугаар бүлэгт заасан Илгээмж, арван есдүгээр бүлгийн хоёрдугаар дэд бүлэгт заасан Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох зэрэг зохицуулалтыг үнэлгээний объект болгон сонгосон.

6.3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 49 дугаар зүйлийн 49.2, 50 дугаар зүйлийн 50.1, 53 дугаар зүйлийн 53.1, 55 дугаар зүйлийн 55.1.3, 77 дугаар зүйл, 129 дүгээр зүйл	Зохицуулалтын практикт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж чадах эсэхэд дүн шинжилгээ хийх, сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох.

2	Практикт хэрэгжих боломж		Зохицуулалтын практикт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж чадсан эсэхээс хамааран практикт хэрэгжүүлэх хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох.
---	--------------------------	--	--

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу төслийн үр нөлөөг доорх хэсэгт гэрээний зохицуулалт тус бүр дээр хийв.

1. Санхүүгийн түрээсийн гэрээ

Иргэний хууль (2002) болон Санхүүгийн түрээсийн тухай хууль (2006)-д санхүүгийн түрээсийн гэрээний онцлог, санхүүгийн түрээсийн төрлийг ялгамжтай байдлаар зохицуулаагүйгээс өмчлөх эрх шилжих нөхцөлтэй санхүүгийн түрээсийн гэрээг зээлээр худалдах худалдан авах гэрээнээс ялгаж, гэрээний төрлийг зөв тодорхойлох тогтсон нэг ойлголт практик байхгүй байна.⁴¹ Өөрөөр хэлбэл, санхүүгийн түрээсийн гэрээний онцлогийг зөвхөн хэлбэрийн талаас нь тайлбарлаж өөр төрлийн гэрээтэй холих хандлага практикт түгээмэл.⁴²

Санхүүгийн түрээсийн гэрээний хэлбэр	
Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хууль (2006)-ийн зохицуулалт	Арилжааны хуулийн төслийн зохицуулалт
5.1.Санхүүгийн түрээс дор дурдсан шаардлагын аль нэгийг хангасан байна: 5.1.1.гэрээний хугацаа дуусгавар болоход түрээсийн зүйлийг түрээслэгчийн өмчлөлд шилжүүлэхээр гэрээнд тусгасан байх; 5.1.2.гэрээний хугацааг тухайн түрээсийн зүйл болох эд хөрөнгийн ашиглалтын хугацааны дөрөвний гурваас багагүй байхаар тогтоосон байх; 5.1.3.гэрээний нийт үнийг тухайн түрээсийн зүйл болох эд хөрөнгийн үнийн дүнгийн 90 болон түүнээс дээш хувьтай тэнцүү байхаар тогтоосон байх.	49 дүгээр зүйл.Санхүүгийн түрээсийн гэрээний хэлбэр, нөхцөл 49.2.Санхүүгийн түрээс доор дурдсан шаардлагын аль нэгийг хангасан байна: 49.2.1.гэрээний хугацаа дуусгавар болоход түрээсийн зүйлийг түрээслэгчийн өмчлөлд шилжүүлэхээр гэрээнд тусгасан байх; 49.2.2.гэрээний хугацааг тухайн түрээсийн зүйл болох эд хөрөнгийн ашиглалтын хугацааны дөрөвний гурваас багагүй байхаар тогтоосон байх; 49.2.3.гэрээний нийт үнийг тухайн түрээсийн зүйл болох эд хөрөнгийн үнийн дүнгийн 90 болон түүнээс дээш хувьтай тэнцүү байхаар тогтоосон байх.

Олон улсын хэмжээнд лизингийн гэрээг үйл ажиллагааны буюу англиар “operating” (борлуулалтыг дэмжих зорилготой) болон санхүүжилтийн буюу “financial” (зөвхөн санхүүжүүлэх зорилготой) гэсэн хоёр төрөлд ангилдаг.⁴³ НББОУС 17-д зааснаар эдгээр 2

⁴¹ Р.Мандухай, Санхүүгийн түрээсийн гэрээг зээлээр худалдах-худалдан авах гэрээнээс ялгахад тулгарч буй асуудал болон Санхүүгийн түрээсийн тухай хуулийг шинэчлэх шаардлага, <https://legaldatal.mn/buteel/pdf?id=1204>, 1 дэх тал

⁴² Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүй II – Гэрээний үүрэг, УБ., 2022, 261 дэх тал

⁴³ Р.Мандухай, Санхүүгийн түрээсийн гэрээг зээлээр худалдах-худалдан авах гэрээнээс ялгахад тулгарч буй асуудал болон Санхүүгийн түрээсийн тухай хуулийг шинэчлэх шаардлага, <https://legaldatal.mn/buteel/pdf?id=1204>, 3 дахь тал

төрлийг ялгахдаа дараах шалгуурыг аль нэгийг хангаж байгаа тохиолдолд санхүүжилтийн лизинг гэж үзэх бөгөөд алийг нь ч хангаагүй тохиолдолд борлуулалтын лизинг гэж үздэг. Үүнд:⁴⁴

- i. Түрээсийн хугацааны эцэст түрээслэгчид өмчлөх эрх шилжих
- ii. Түрээсийн зүйлийг харилцан тохиролцон худалдах сонголттой байх
- iii. Түрээсийн ашиглалтын хугацаа нь эд хөрөнгийн ашиглалтын 75 хувийг хангадаг байх
- iv. Түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ нь эд хөрөнгийн бодит зах зээлийн үнийн 90 хувиар хэтрээгүй байх
- v. Түрээслэгч нь түрээсийг цуцалбал үүнтэй холбогдон түрээслүүлэгчид учирсан хохирлыг хариуцдаг байх

Гэтэл Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт дээрх шаардлагуудын аль нэгийг санхүүгийн түрээс нь заавал хангасан байх шаардлагыг тавьсан байгаагаас Санхүүгийн түрээсийн тухай хуулиар зөвхөн санхүүжилтийн лизингийн гэрээний төрлийг авч үзсэн бөгөөд борлуулалтын лизингийг уг хуулиар зохицуулаагүй болох нь харагдаж байна.⁴⁵ Энэхүү зохицуулалтыг Арилжааны хуулийн төслийн 49.2 дахь хэсэгт энэ хэвээр тусгасан байгаа нь практикт үүсээд байгаа хуулийн зохицуулалт нь тухайн харилцааг бүрэн хамарч чадахгүй байгаа дутагдлыг залруулаагүй байна.

Шүүхийн шийдвэр: “М” ХХК нь нэг ширхэг зам индүүдэгч болон нэг ширхэг асфальтны индүү зэрэг нийт 352,479,000 төгрөгийн үнэ бүхий 2 техникийг нийлүүлэгч болох БНХАУ-ын компаниас худалдан авч “О” ХХК-д хүлээлгэн өгсөн. “О” ХХК нь уг нийт дүнгийн тал хувийг буюу 176,239,800 төгрөгийг урьдчилгаанд төлж, үлдсэн тал хувийг 3 сарын хугацаанд төлж, түрээсийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлэхээр тохиролцсон. Хариуцагч “О” ХХК нь санхүүгийн түрээсийн гэрээний төлбөрийн хуваарийг зөрчсөн тул түрээсийн техникийг ашигласан хугацааны төлбөрийг “М” ХХК нь “О” ХХК-иас нэхэмжилсэн. “О” ХХК нь түрээсийн зүйлээс зам индүүдэгчийн төлбөрийг төлсөн тул өмчлөгчөөр тогтоолгож, өөрийн өмчлөлд шилжүүлэхийг шаардсан сөрөг нэхэмжлэл гаргасан.

Анхан шатны шүүх:⁴⁶ Анхнаасаа түрээсийн зүйлийн төлбөр төлөгдөж дуусмагц түрээсийн зүйлийг түрээслэгчийн өмчлөлд шилжүүлэх агуулгаар харилцан тохиролцсон байгаа нь санхүүгийн түрээсийн гэрээний шинжийг бус зээлээр худалдах худалдан авах гэрээний шинжийг агуулсан. Учир нь Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан аль ч шаардлагыг уг гэрээ хангаагүй гэж үзсэн ба ялангуяа үүнд 5.1.1 дэх заалтад “гэрээний хугацаа дуусгавар болоход өмчлөх эрх шилжүүлнэ” гэж заасан харийн төлбөрийг төлөгдөж дуусмагц шилжүүлж байгаа нь зээлээр худалдах худалдан авах гэрээ болно гэж үзэж Иргэний хуулийн 262 дугаар зүйлийн 262.1, 205 дугаар зүйлийн 205.1 болон 219 дүгээр зүйлийн 219.1 дэх хэсгийг баримтлан нэхэмжлэлийн шаардлагын заримыг хангаж, бусад хэсгийг хэрэгсэхгүй болгон хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийг хангаж шийдсэн.

⁴⁴ Мөн тэнд, 3 дахь тал

⁴⁵ Мөн тэнд, 3-4 дэх тал

⁴⁶ Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 181/ШШ2018/00986 дугаар шийдвэр,

https://shuukh.mn/single_case/76128?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1

Судлаачийн дүгнэлт:⁴⁷ Шүүхээс гэрээ нь Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан нөхцөлүүдийн аль нэгийг нь хангахгүй байгаа тул санхүүгийн түрээсийн гэрээ биш гэж дүгнэжээ. Гэтэл НББОУС 17-д зааснаар тэдгээр шинжүүдийн аль нэгийг хангаагүй тохиолдолд үйл ажиллагааны /борлуулалтын түрээс болно гэж заасан. Өөрөөр хэлбэл, Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн шинжүүд нь санхүүгийн түрээсийн 2 төрлийг ялгадаг шинжүүд юм.

Шүүхийн практикт өмчлөх эрх шилжих нөхцөлтэйгөөр байгуулсан санхүүгийн түрээсийн гэрээ болон зээлээр худалдах, худалдан авах гэрээг ялгахдаа ялгаатай байдлаар тогтсон нэг үзэл баримтлалгүйгээр тайлбарлаж байгааг харж болох ба дараах дүн шинжилгээг нэгтгэн хийж болохоор байна.⁴⁸

Нэгдүгээрт гэрээнд гэрээний зүйлийн өмчлөх эрхийг гэрээний хугацаа дуусгавар болоход шилжүүлэхээр харилцан тохиролцсон бол энэ нь Иргэний хуулийн 312 дугаар зүйлийн 312.3 дахь хэсэг болон Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад зааснаар өмчлөх эрх шилжүүлэх нөхцөлтэй санхүүгийн түрээсийн гэрээ болох уу эсхүл гэрээний зүйлийг ашиглуулах бус өмчлөх эрхийг шилжүүлэх зорилготой гэдгээр зээлээр худалдах худалдан авах гэрээ гэж үзэх эсэх нь маргаантай байна. Шүүхийн практикт “Санхүүгийн түрээс”-ийн үйл ажиллагааны буюу борлуулалтын түрээснээс ялгадаг шинжийг зээлээр худалдах худалдан авах гэрээнээс ялгах шинж болгон авч үзэж байна. Нөгөө талаас өмчлөх эрхийг гэрээний хугацаа дуусахад шилжүүлж байвал санхүүгийн түрээсийн нэг шинжийг агуулж байна гээд харин төлбөр төлж дуусахад шилжүүлж байвал зээлээр худалдах худалдан авах гэрээ гэж үзэж байгаа нь Иргэний хуулийн 312 дугаар зүйлийн 312.4 дэх хэсэгт заасан (түрээслэгч өмчлөх эрхийг шилжүүлж авах эрхтэй байх зохицуулалт)-тай зөрчилдөж байна.

Хоёрдугаарт талуудын эд зүйлийг эзэмшил ашиглалтад нь шилжүүлж байгаа хүсэл зориг нь анхнаасаа ашиглуулах зорилготой байсан уу эсхүл худалдах зорилго байсан уу гэдгээр эдгээр гэрээг ялгаж байгаа бөгөөд зөвхөн энэ зорилгыг харгалзан үзэх нь өмчлөлд нь шилжүүлэх тохиролцоо санхүүгийн түрээсийн гэрээнд тусгагдсан л байвал худалдах худалдан авах гэрээ эсхүл зээлээр худалдах худалдан авах гэрээ болно гэж дүгнэхэд хүргэж байна. Санхүүгийн түрээс нь түрээслэгчийг хөрөнгө худалдан авахад нь санхүүжилт олгох эсхүл борлуулагчийн борлуулалтыг дэмжих зорилготойгоор хөрөнгийг түрээслэгчийн өмчлөлд шилжүүлэх гэсэн үндсэн зорилготой ба гэрээндээ өмчлөх эрхийг шилжүүлэхээр тусгасан ч түрээслүүлэгч нь анхнаасаа худалдах зорилгогүй зөвхөн түрээслэгчийн хүсэлтээр түүний эзэмшил ашиглалтад шилжүүлсэн байдаг. Иймээс талуудын тухайн хөрөнгийг өмчлөлдөө шилжүүлэх болсон анхны нөхцөл зорилгыг тогтоох шаардлагатай.

Санал: Санхүүгийн түрээсийн гэрээний санхүүжилтийн болон борлуулалтын гэсэн хоёр ялгаатай төрлийн онцлогийг харгалзаж, Арилжааны хуулийн төслийн 49.2-т заасан тодорхой шаардлагын аль нэгийг зайлшгүй хангуулсан байх шаардлагыг борлуулалтын түрээс/operating lease/-ийн гэрээнд хамаарахгүй байдлаар зохицуулах.

Эд хөрөнгө хөлслөх гэрээний зохицуулалтыг санхүүгийн түрээсийн гэрээнд нэгэн адил хэрэглэхээр хуульчилсан

⁴⁷ Мөн тэнд, 8 дахь тал

⁴⁸ Мөн тэнд, 9 дэх тал

Иргэний хууль (2002)-ийн зохицуулалт	Арилжааны хуулийн төслийн зохицуулалт
314 дүгээр зүйл. Түрээслүүлэгчийн хүлээх хариуцлага 314.1.Түрээслүүлэгч нь гэрээний зүйл болох эд хөрөнгийг түрээслэгчид шилжүүлээгүй, хугацаа хоцорч шилжүүлсэн, эсхүл шаардлага хангаагүй эд юмсыг шилжүүлсний хариуцлагыг эд хөрөнгө хөлслөх гэрээний нэг адил хүлээнэ. 317 дугаар зүйл. Санхүүгийн түрээсийн гэрээнд хамаарах бусад зүйл 317.1.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол санхүүгийн түрээсийн гэрээнд эд хөрөнгө хөлслөх гэрээний талаарх энэ хуульд заасан журам нэгэн адил үйлчилнэ.	50 дугаар зүйл.Түрээслүүлэгчийн хүлээх хариуцлага 50.1.Түрээслүүлэгч нь гэрээний зүйл болох эд хөрөнгийг түрээслэгчид шилжүүлээгүй, хугацаа хоцорч шилжүүлсэн, эсхүл шаардлага хангаагүй эд юмсыг шилжүүлсний хариуцлагыг эд хөрөнгө хөлслөх гэрээний нэг адил хүлээнэ. 53 дугаар зүйл.Санхүүгийн түрээсийн гэрээнд хамаарах бусад зүйл 53.1.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол санхүүгийн түрээсийн гэрээнд эд хөрөнгө хөлслөх гэрээний талаарх Иргэний хуульд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

Иргэний хуулийн дээрх хүснэгтэд харуулсан зохицуулалтаар эд хөрөнгө хөлслөх гэрээний зохицуулалтыг санхүүгийн түрээсийн гэрээнд нэгэн адил хэрэглэхээр хуульчилсан. Гэвч санхүүгийн түрээсийн төрлөөс санхүүжилтийн лизингийн гэрээ нь эд хөрөнгө хөлслөх гэрээнээс өөр болохыг доорх тайлбаруудаас харж болно.⁴⁹

Тодруулбал, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбарт санхүүжилтийн лизингт санхүүжилт хийх ашиг сонирхол тэргүүн ээлжид тавигдаж байгаа бөгөөд санхүүжүүлсэн худалдах, худалдан авах гэрээ эсхүл эд хөрөнгө хөлслөх гэрээний аль нь ч биш тул эд хөрөнгө хөлслөх гэрээний үндсэн зарчмаас өөр байдаг. Харин борлуулалтын гэрээний хувьд борлуулагчийн лизингт эд хөрөнгийг тодорхой хугацаанд ашиглалтад шилжүүлэх явдал буюу эд хөрөнгө хөлслөх түрээслэх гэрээний шинжтэй байдаг гэж тайлбарлажээ.

Харин Б.Буянхишиг “Борлуулалтын лизингт эд хөрөнгө хөлслөх гэрээний зохицуулалт хэрэглэгдэх боломжтой. Энэ төрлийн лизинг авч буй этгээд нь хэсэг хугацаа өнгөрсний дараа түрээсийн зүйлийг худалдаж авах эрхтэй байхаар тохирсон байдаг ба энэ эрхээ хэрэгжүүлбэл худалдах, худалдан авах гэрээгээр солигдоно”⁵⁰ гэжээ.

Дээрхээс үзэхэд борлуулалтын лизингийн хувьд эд хөрөнгө хөлслөх гэрээний нэгэн адил зохицуулалт үйлчлэх бол санхүүжилтийн лизингийн хувьд эд хөрөнгө хөлслөх гэрээний үндсэн зарчмаас өөр тул шууд хэрэглэх боломжгүй байна.⁵¹

Санал: Санхүүгийн түрээсийн гэрээний борлуулалтын лизинг болон санхүүжилтийн лизинг гэсэн хоёр төрлийн ялгаа заагийг тодруулж, эд хөрөнгө хөлслөх гэрээний зохицуулалт нэгэн адил үйлчлэх зарчмыг зөвхөн борлуулалтын лизингийн хувьд хамааралтай байхаар тусгах. Харин санхүүжилтийн лизингийн хувьд эд хөрөнгө хөлслөх гэрээний шууд хэрэглэгдэх боломж хязгаарлагдмал тул эд хөрөнгө хөлслөх гэрээний зохицуулалтыг эшлэхгүй байхаар тусгах.

2. Франчайзын гэрээ

⁴⁹ Мөн тэнд 4 дэх тал

⁵⁰ Мөн тэнд, 4 дэх тал

⁵¹ Мөн тэнд, 3-4 дэх тал

Иргэний хууль (2002)-ийн зохицуулалт	Арилжааны хуулийн төслийн зохицуулалт
334 дүгээр зүйл. Гэрээний талуудын үүрэг 334.1.Эрх шилжүүлэгч дараахь үүрэгтэй: 334.1.3.эрх хүлээн авагчийг шаардлагатай мэдээллээр хангах;	55 дугаар зүйл.Гэрээний талуудын үүрэг 55.1.Эрх шилжүүлэгч дараах үүрэгтэй: 55.1.3.эрх хүлээн авагчийг шаардлагатай мэдээллээр хангах;

Иргэний хуулийн 334 дүгээр зүйлийн 334.1.3 дахь зохицуулалт нь нэгэнт гэрээ байгуулсан талуудын хувьд эрх шилжүүлэгч “эрх хүлээн авагчийг мэдээллээр хангах” үүрэгтэй болохыг тусгасан байна. Гэвч гэрээ байгуулахын өмнөх шатанд эрх хүлээн авах хүсэл зоригтой байгаа этгээдийг мэдээллээр хангах үүрэг тус зохицуулалтын хүрээнд тусгагдаагүй байна.

Хувийн эрх зүйг ижилтгэх олон улсын хүрээлэн УНИДРУА-аас гаргасан Франчайзын мэдээлэх загвар хууль (UNIDROIT- International Institute for the Unification of Private Law, Model Franchise Disclosure Law, 2002)⁵² -ийн 3 дугаар зүйлд эрх шилжүүлэгч нь эрх хүлээн авагчид франчайзын гэрээ байгуулах эсхүл франчайзтай холбоотой аливаа төлбөр шилжүүлэхээс 14 хоногийн өмнө холбогдох мэдээллийг өгөх үүрэгтэй байхаар зохицуулсан. Цаашлаад хуулийн 5, 6 дугаар зүйлүүдэд мэдээлэх үүрэгт үл хамаарах 7 тохиолдол, болон мэдээлэгдсэн байх ёстой 16 бүлэг мэдээллийн төрөл, нэмж мэдээлж болох 11 мэдээллийн төрлийг нэрлэн тусгасан байна. Дээр дурдсан 14 хоногийн дотор мэдээлэх болон түүнд орсон өөрчлөлтийг мэдэгдээгүй нь франчайзын гэрээг цуцлах, учирсан хохирлоо арилгуулах үр дагавартай байхаар зохицуулсан.

Тус хуулийн дагалдах тайлбар (Explanatory Report)-т тус загвар хууль нь франчайзын хэлцлийн талуудад найдвартай эрх зүйн орчныг бүрдүүлэх, франчайзын эрх шилжүүлэн авах хүсэлтэй байгаа этгээд (prospective franchisee)-ийн хувьд франчайзын хэлэлцээрийн явцад, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахын өмнө мэдээллээр хангагдсан байх боломжийг бүрдүүлэх⁵³ зорилготой гэжээ.

Түүнчлэн, АНУ-ын хувьд франчайзын гэрээний урьдчилсан нөхцөл болох эрх шилжүүлэгчээс 23 нэр төрлийн мэдээллийг франчайзын гэрээ байгуулахаас 14 хоногийн өмнө эрх хүлээн авагчид гарган өгөхөөр зохицуулсан бол БНХАУ-ын хувьд франчайзын гэрээ байгуулахаас 30-аас доошгүй өдрийн өмнө 12 төрлийн мэдээллийг эрх хүлээн авагчид гарган өгч франчайзын мэдээллийг дутуу авах эрсдэлээс сэргийлэх зорилгоор зохицуулжээ.⁵⁴ Ийнхүү франчайзын гэрээ байгуулахаас өмнө урьдчилан мэдэгдэх, талуудад тавигдах шаардлага зэрэг тодорхой үе шатуудтай байдаг нь ирээдүйд үүсэх эрсдэлийг бууруулах, талуудын эрх ашгийг хамгаалах зорилготой.⁵⁵

Харин Монгол Улсын Иргэний хуулиар гэрээ байгуулахын өмнө мэдээлэх зохицуулалт (pre-contractual disclosure of information)-ыг эрх шилжүүлэгчид тавигдах

⁵² International Institute for the Unification of Private Law, Model Franchise Disclosure Law (2002), <https://www.unidroit.org/instruments/franchising/model-law/>

⁵³ International Institute for the Unification of Private Law, Guide to International Master Franchise Agreements – Second Edition (2007), <https://www.unidroit.org/wp-content/uploads/2021/06/franchising2007-guide-2nd-e.pdf>, Page 24

⁵⁴ Б.Оджаргал, Франчайзын олон улсын гэрээний эрх зүйн зохицуулалт (Магистрын ажил), <https://legaldatal.mn/b/1422>, 2020, 41 дэх тал

⁵⁵ Мөн тэнд, 48 дахь тал

шаардлага болгон зохицуулаагүй нь эрх хүлээн авагч франчайзын талаарх мэдээллээр бүрэн хангагдахгүй байх, төөрөгдөлд орох эрсдэл⁵⁶-ийг үүсгэхээр байна. Иргэний хуульд франчайзын гэрээ байгуулахын өмнө мэдээллээр хангах үүрэг болон хугацааны хязгаарлалтыг тогтоож өгөөгүй.⁵⁷

Шүүхийн шийдвэр: МУ-д франчайзын систем нь хөгжлийн эхэн үедээ явж байгаа бөгөөд одоогоор шүүхээр шийдвэрлэгдсэн маргаан харьцангуй цөөн байна.⁵⁸ 2011-2021 оны хооронд зөвхөн нэг франчайзын маргааныг дотоодын шүүхээр шийдвэрлэжээ.⁵⁹

Санал: Арилжааны хуулийн төслийн франчайзын зохицуулалттай холбогдох хэсэгт талуудын эрх шилжүүлэгчээс эрх хүлээн авагчид гэрээ байгуулахын өмнө тодорхой мэдээллээр хангах үүргийг нэмж зохицуулах.

3. Илгээмжийн гэрээ

Иргэний хууль (2002)-ийн зохицуулалт	Арилжааны хуулийн төслийн зохицуулалт
407 дугаар зүйл. Илгээмжийн гэрээ	77 дугаар зүйл.Илгээмжийн гэрээ
408 дугаар зүйл. Илгээгчийн эрх, үүрэг	78 дугаар зүйл.Илгээгчийн үүрэг
409 дүгээр зүйл. Захиалагчийн эрх, үүрэг	79 дүгээр зүйл.Илгээгч өөрөө тээвэрлэлтийг гүйцэтгэх
	80 дугаар зүйл.Илгээгчийн хүлээх хариуцлага
	81 дүгээр зүйл.Захиалагчийн үүрэг
	82 дугаар зүйл.Хөлс төлөх
	83 дугаар зүйл.Захиалагчийн шаардах эрх
	84 дүгээр зүйл.Илгээгчийн саатуулан барих эрх

Тээвэр зуучийн хувиар хариуцлага хүлээлгэх асуудлыг Иргэний хуульд хэрхэн зохицуулсан, аль гэрээний зохицуулалт хэрэглэх тал дээр шүүхийн практик тодорхойгүй байна.⁶⁰ Тээвэр зуучийн үйлчилгээ үзүүлж буй этгээдийн үүрэг нь тээвэрлэлтийг зохион байгуулах буюу 1/.тээврийн хэрэгсэл ба тээврийн замыг тодорхойлох, 2/. Гүйцэтгэгчийг сонгох, илгээхэд шаардлагатай тээвэрлэлтийн, хадгалалтын болон тээвэрлэлтийн гэрээг өөрийн нэрээр (үйлчлүүлэгчийн зардлаар) байгуулж ажилладаг. Мөн гүйцэтгэгчид мэдээлэл, зааварчилгаа өгөх, илгээгчийн хохирол шаардах эрхийг баталгаажуулах үүрэгтэй.⁶¹

⁵⁶ Мөн тэнд, 40-41 дэх тал

⁵⁷ B.Namsrai (Ph.D student at University of Pecs, Hungary), Mongolian Laws regarding Franchising questions: Critical Thinking on Domestic Statutes, <https://legalddata.mn/buteel/pdf?id=1609>, page 38

⁵⁸ Б.Оджаргал, Франчайзын олон улсын гэрээний эрх зүйн зохицуулалт (Магистрын ажил), <https://legalddata.mn/b/1422>, 2020, 40 дэх тал

⁵⁹ B.Namsrai (Ph.D student at University of Pecs, Hungary), Mongolian Laws regarding Franchising questions: Critical Thinking on Domestic Statutes, <https://legalddata.mn/buteel/pdf?id=1609>, page 36, Bayanzurkh District Court. Decision №20. (2020)

⁶⁰ Ханнс Зайделийн Сан, “Эрх зүйн боловсрол” академи Б.Буянхишиг “Тээвэр зуучийн гэрээг зохицуулах хууль хэрэглээний асуудал” (2021), <https://legalddata.mn/b/1802>, 46 дахь тал

⁶¹ Мөн тэнд, 52 дахь тал

Тээвэр зуучийн гэрээ байгуулагдсан нь илт байгаа ч шүүхийн шийдвэрүүдэд худалдааны төлөөллийн харилцаа үүссэн эсвэл зуучлалын болон тээвэрлэлтийн гэрээний хослол гэх мэт олон янзаар дүгнэж байна. Тээвэр зуучийн харилцаанд зориулж хууль тогтоогч ИХ-ийн 407-409-ийн “илгээмжийн гэрээний” зохицуулалтыг бүтээсэн болох нь харьцуулсан судалгаагаар нотлогддог ч энэ зүйл заалтыг огт хэрэглэж хэвшээгүй. ИХ-ийн 407 дугаар зүйлийн 407.1-д “Илгээмжийн гэрээ” гэсэн оновчгүй нэр томьёо оруулсан. Илгээмжийн үйл ажиллагаа нь тээвэр зуучийн үйл ажиллагаа нь мөн бөгөөд ачааг тодорхой цэгт хүртэл тээвэрлүүлэх захиалга өгөх буюу холбогдох гэрээ хэлцлийг мэргэжлийн өндөр түвшинд байгуулахыг хэлэх бөгөөд олон улсад энэ үйл ажиллагааг логистик хэмээн нэрлэж, зарим тохиолдолд *spedition* хэмээн орчуулах ба үүнийг МУ-ын практикт тээвэр зуучийн гэрээ хэмээн нэрлэж заншжээ. Харин МУ-ын ИХ-ийн хувьд энэ гэрээг “илгээмжийн гэрээ” хэмээн нэрлэсэн нь тээвэр зуучийн үйл ажиллагаа биш мэт ташаа ойлголт төрүүлж, хууль хэрэглээг тээвэрлэлт ба зуучлалын гэрээний зохицуулалт руу шилжүүлэх сөрөг үр нөлөөтэй байна.⁶² ИХ-ийн 407-409 зохицуулалт нь практикт тээвэр зуучийн гэрээний зохицуулалттай дүйж байгаа тул энд заасан “илгээгч” гэснийг “тээвэр зууч” гэж уншиж, хуулийг зөв тайлбарлан тээвэр зуучийн харилцааг хөгжүүлэх шаардлагатай.

Арилжааны хуулиар “илгээмжийн гэрээ” гэсэн нэр томьёог өөрчлөх хэрэгцээ, шаардлага

Хуулийн төслийн 77-84 дүгээр зүйлүүдэд “илгээмжийн гэрээ”-ний харилцааг зохицуулахдаа одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуулийн 407-409 дүгээр зүйлүүдэд зохицуулсан “илгээмжийн гэрээ”-ний зохицуулалттай харьцуулахад нэршлийг ижил хэвээр үлдээж, зохицуулалтын хувьд хэд хэдэн заалтыг шинээр нэмж тусгасан байна. Тодруулбал,

- ИХ-ийн 408.1-д Илгээгч нь илгээмжийн гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангахуйц байдлаар **“ачаа илгээмжийн тээвэрлэх”** гэснийг АХ-ийн төслийн 78.1.1-т **“тээврийн хэрэгсэл болон тээвэрлэх замыг шийдвэрлэх”**
- ИХ-ийн 408.1-д **“тээвэрлэлтэд оролцох этгээдийг сонгох”** гэсэн дээр нэмэх нь АХ-ийн төслийн 78.1.2-т **“түүнд мэдээлэл болон зааварчилгаа өгөх”**
- АХ-ийн төслийн 78.1.3-т **“илгээхэд шаардлагатай тээвэрлэлтийн, хадгалалтын илгээмжийн гэрээг байгуулах”**, 78.1.4-т **“захиалагчид хохирол шаардах эрхийг шилжүүлэх”**, 83.1-т **“Захиалагч нь илгээгч өөрийн нэрээр захиалагчийн зардлаар байгуулсан гэрээнээс үүссэн шаардах эрхийг өөртөө шилжүүлж авсны дараа хэрэгжүүлж болно”**, 84.1-т **“Илгээгч нь хөлс, холбогдох бусад зардал, захиалагчийн өмнөөс төлсөн аливаа төлбөрийн шаардлагаа хангуулах зорилгоор захиалагчийн илгээмжийг саатуулан барих эрхтэй”** зэрэг зохицуулалтыг нэмж тусгасан байна.

Санал: Арилжааны хуулийн төсөлд оруулсан “илгээмжийн гэрээ”-ний зохицуулалт нь Б.Буянхишиг судлаачийн дүн шинжилгээнд дурдсан агуулгаар тээвэр зуучийн гэрээний зохицуулалтыг боловсронгуй болгож, хариуцлагыг нарийвчилсан зохицуулсан ач холбогдолтой байна. Гэвч ингэхдээ нэр томьёоны хувьд агуулгадаа нийцүүлэн, дээрх судалгаанд санал болгосон агуулгаар **“Тээвэр, зуучийн гэрээ”** болгон өөрчлөөгүй байгаа нь учир дутагдалтай гэж үзэж байна. Учир нь тухайн бүлгийн нарийвчилсан зохицуулалт нь агуулгаараа тээвэр, зуучийн гэрээтэй нийцэж байх боловч үндсэн гэрээний нэршил

⁶² Мөн тэнд, 58 дахь тал

өөрчлөгдөөгүй байгаа нь өмнө нь шүүхээс уг гэрээний мөн чанарыг буруу дүгнэх, өөр гэрээнээс ялгахгүй байх нөхцөлийг залруулах боломжийг хязгаарласан байна.

4. Зээл тооцооны үүрэг: Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээ

Иргэний хууль (2002)-ийн зохицуулалт	Арилжааны хуулийн төслийн зохицуулалт
451 дүгээр зүйл. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээ 451.1.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид "зээлдүүлэгч" гэх/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ. 451.3.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна. 452 дугаар зүйл. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлийн хүү 452.1.Зээлдүүлэгчээс олгох зээл нь хүүтэй буюу хүүгүй байж болно. 452.2.Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу зээлдүүлэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр гэрээнд зааж болно. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлд анзыг хэрэглэхгүй.	129 дүгээр зүйл.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээ 129.1.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид "зээлдүүлэгч" гэх/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ. 129.3.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна. 130 дугаар зүйл.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлийн хүү 130.1.Зээлдүүлэгчээс олгох зээл нь хүүтэй, эсхүл хүүгүй байж болно. 130.2.Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу зээлдүүлэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр гэрээнд зааж болно. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлд анзыг хэрэглэхгүй.

Банк болон зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс зээл олгох талаарх зохицуулалтыг Иргэний хууль (“ИХ”)-ийн 222.5-д “Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй”, мөн хуулийн 453.1-д “Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй”, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай (БЭБХЭМШЗҮАтХ)-ийн 20.3-т “Зээлийн гэрээний хугацаа дууссан нь гэрээний үүргээ хугацаанд биелүүлээгүй зээлдэгчийн зээл, түүний хүү, нэмэгдсэн хүүг төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй”, мөн хуулийн 21.2-т “Зээлдэгч зээлийг зээлийн гэрээнд

заасны дагуу төлөөгүй, эсхүл хууль, зээлийн гэрээнд заасан үндэслэлээр зээлдүүлэгчийн нэг талын санаачилгаар зээлийн гэрээг хугацаанаас өмнө цуцалсан бол зээлийг бүрэн эргүүлэн төлөх хүртэлх хугацаанд зээлийн үндсэн хүү, зээлийн гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлнө.” гэж тус тус заасан.

Эдгээр заалтыг баримтлан зээлийн гэрээний хугацаа дууссан эсхүл гэрээг цуцалсан ч зээлдэгч нь хүү, нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэг дуусгавар болохгүй гэж маргаж, төлөгдөөгүй байгаа зээлийн үндсэн төлбөрийг холбогдох хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хамт төлөхийг зээлдэгчээс нэхэмжлэн шүүхэд хандаж байна.⁶³ Гэрээний хугацаа дуусах болон гэрээг цуцлах нь гэрээг дуусгавар болгох өөр өөр үндэслэл бөгөөд ИХ-ийн 453.1 дэх заалтад гэрээг цуцалсан, хугацаанаас нь өмнө дуусгавар болгосон тохиолдолд үргэлжлүүлэн хүү, нэмэгдүүлсэн хүү тооцож болох талаар дурдаагүй. Иймээс гэрээг цуцалсан тохиолдолд эдгээр заалтыг үндэслэн гэрээг цуцалснаас хойших хугацаанд хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцон нэхэмжлэх, нэхэмжлэхийг хангах боломжтой эсэх нь эргэлзээ төрүүлж байна.⁶⁴

Шүүхийн шийдвэр: Зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд зээлийн гэрээг цуцалснаас хойших хугацааны зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг гаргуулахаар шаардсан маргааныг шүүхээр шийдвэрлэж буй нөхцөл байдлын хоёр үндсэн төрлийг (20 орчим шүүхийн шийдвэрт үндэслэн) дурдвал:⁶⁵

- а) зээлийн гэрээ цуцалсан өдрөөс хойших хугацааны зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг хариуцагч буюу зээлдэгчээс гаргуулахаар шийдвэрлэж байна (9 хэрэг).⁶⁶
- б) дээрх шийдвэрүүдийн эсрэгээр зээлийн гэрээг цуцалсан өдрөөс хойших хугацааны зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг нэхэмжлэгч шаардах эрхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдлууд байна (11 хэрэг).⁶⁷

Шүүх нь зээлийн гэрээг цуцалснаас хойш хүү, нэмэгдүүлсэн хүү тооцож нэхэмжилсэн нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэхдээ хуулийг нэг мөр хэрэглэлгүй, ялгаатай шийдвэр гаргасан байх бөгөөд энэ асуудлаар шүүхийн тодорхой практик тогтоогүй байна.⁶⁸ Энэхүү нөхцөл байдал нь цаашлаад банк, санхүүгийн байгууллага (зээлдүүлэгч), бизнес эрхлэгч, иргэдэд (зээлдэгч) тодорхойгүй нөхцөл байдал үүсгэж байгаа бөгөөд тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь хуулиар тухайн асуудлыг хэрхэн зохицуулснаас бус, харин цэвэр шүүгчийн үзэмжээс шалтгаалах буюу шүүгч хуулийг хэрхэн ойлгож хэрэглэхээс хамаарахаар байна.⁶⁹ Үүний шалтгаан нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгож байгаа зээлийн харилцааг зохицуулсан тусгайлсан зохицуулалтууд болох ИХ-ийн 453 дугаар зүйлийн 453.1 болон 2021.05.21-ны өдөр хүчингүй болсон Банк, эрх

⁶³ Мөн тэнд, 26-27 дахь тал

⁶⁴ Мөн тэнд, 28 дахь тал

⁶⁵ Мөн тэнд, 29 дэх тал

⁶⁶ Ийнхүү шийдвэрлэхдээ ИХ-ийн 453 дугаар зүйлийн 453.1 дэх хэсэг дэх “Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй” гэсэн зохицуулалт мөн БЭБХЭМХТТЗҮАтХ (тус хууль нь 2021.05.21-ны өдөр хүчингүй болсон)-ийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх “Зээлийн гэрээний хугацаа дууссан нь гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй зээлдэгчийг зээл, түүний хүү, нэмэгдсэн хүүг төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй”, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Зээлийг заасан хугацаанд төлөөгүй бол зээлийн гэрээ үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэлх хугацаанд зээлийн үндсэн хүү, гэрээнд заасан бол түүний 20 хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлнө” гэсэн зохицуулалтыг тус тус үндэслэжээ.

⁶⁷ Үндэслэл нь ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.1, 453 дугаар зүйлийн 453.1 дэх хэсгийг үндэслэн байгуулсан зээлийн гэрээ ИХ-ийн 225 дугаар зүйлийн 225.1 дэх хэсэгт заасны дагуу цуцлагдсан тул тухайн гэрээг үндэслэн түүнээс хойших хугацааны хүү шаардах эрхгүй гэжээ.

⁶⁸ Нээлттэй нийгэм форум, Б.Ананд Л.Анхбаяр М.Балжинсүрэн “Зээлийн гэрээг цуцалснаас хойш хүү шаардсан маргааны шүүхийн шийдвэрийн шинжилгээ” (2021), <https://legaldata.mn/b/1099>, 48 дахь тал

⁶⁹ Мөн тэнд, 48 дахь тал

бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн зохицуулалтын дагуу зээлийн гэрээ цуцлагдсанаас хойших хугацаан зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг зээлдүүлэгч шаардах эрхтэй эсэх талаар тодорхой хуульчлагдаагүй, одоогийн хэм хэмжээ тухайн харилцааг тодорхойлоход төдий л ойлгомжтой бус байгаагаас шалтгаалан шүүх хуулийн нэг хэм хэмжээг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж, хуулийг нэр мөр хэрэглэхэд төвөгтэй байдал үүсгэж байж болох юм.⁷⁰

Арилжааны хуулиар хүүгийн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага

Арилжааны хуулийн төсөлд дээр дурдсан зээлийн гэрээг цуцалснаас хойш хүү, нэмэгдүүлсэн хүү төлөхийг шаардах эрхтэй эсэх асуудлыг тодорхой бус хэвээр үлдээсэн байна. Хэдийгээр 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр шинэчлэн найруулсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 21.2 дахь хэсэгт уг харилцааг зохицуулсан⁷¹ боловч үүнийг Арилжааны хуулийн төсөлд давхар тусгах шаардлагатай гэж үзэж байна. Учир нь Арилжааны хуулийг батлан гаргаж буйн нэг үндсэн зорилго нь тухайн харилцаанд оролцогч талуудад эрх зүйн тодорхой байдал (legal clarity/certainty) бүрдүүлэх юм. Түүнчлэн дээр судалгаанд гарч буйгаар уг харилцааг шүүхэд харилцан адилгүй байдлаар шийдвэрлэж, нэг мөр жишиг тогтооход хүндрэл учирч байна. Иймд арилжааны хуулиар тус асуудлыг нэр мөр шийдвэрлэж, цаашид тухай харилцаанд оролцогчид болон холбогдох зохицуулалтыг хэрэглэн маргаан шийдвэрлэж буй шүүх, хууль зүйн үйлчилгээ үзүүлж буй талуудын хувьд тодорхой байдал бүрдүүлэх нь чухал байна.

Санал: Арилжааны хуульд зээлийн гэрээг цуцалсан тохиолдолд үргэлжлүүлэн үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүү төлөх эсэх талаарх зохицуулалтыг тодорхой болгох. Ингэхдээ “гэрээ цуцалсанаас хойш гагцхүү ИХ-ийн 225.5-д хүүг тооцно” гэсэн агуулгыг тусгах.

6.4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

Арилжааны хууль нь хэрэгжихдээ өмнө нь Иргэний хуулиар зохицуулагдаж байсан арилжааны зарим зохицуулалтын практикт учирдаг асуудлыг шийдвэрлэх, түүнийг боловсронгуй болгох, тухайн асуудлыг зохих түвшинд даван туулахад чиглэх учиртай. Ингэснээр Арилжааны эрх зүйн харилцааг бие даасан хуулиар зохицуулж байгаа зорилгын нэг хэсэг биелэнэ.

Төслийн хүрээнд тодорхой гэрээнүүдэд Иргэний хуулийн зохицуулалтыг нарийвчилж, ингэхдээ арилжааны эрх зүйн ашгийн төлөөх зорилгыг хангах, шударгаар итгэсэн итгэлийг хангах, мэргэшсэн хариуцлагатай байх, түргэн шуурхай байх зэрэг зарчмын дагуух өөрчлөлтийг оруулжээ. Харин энэхүү бүлэгт Иргэний хуулийн хүрээнд явцад хэрэгжих яюцдаа шүүх, арилжааны практикт зарим асуудал дагуулж буй зохицуулалтыг сонгон авч, Арилжааны хуулийн төслийн хүрээнд тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн болохыг авч үзсэн. Эдгээр зохицуулалтын тухайд одоогийн Иргэний хуульд тусгагдан хэрэгжиж буй арилжаа эрхлэгчид хамаарах зарим төрлийн гэрээний зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөл рүү шилжүүлэн тусгахдаа Иргэний хуулийн үйлчлэлийн хүрээнд тулгарч байсан асуудал, дутагдлыг шийдвэрлэж, зохицуулалтыг

⁷⁰ Мөн тэнд, 48 дахь тал

⁷¹ Хуулийн 21.2-т “Зээлдэгч зээлийг зээлийн гэрээнд заасны дагуу төлөөгүй, эсхүл хууль, зээлийн гэрээнд заасан үндэслэлээр зээлдүүлэгчийн нэг талын санаачилгаар зээлийн гэрээг хугацаанаас өмнө цуцалсан бол зээлийг бүрэн эргүүлэн төлөх хүртэлх хугацаанд зээлийн үндсэн хүү, зээлийн гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлнө.”

боловсронгуй болгоогүй байгаа бөгөөд үүний улмаас эдгээрийн практикт хэрэгжих боломжид асуудал үүсэхээр байна. Иймд дээрх судалгааны хүрээнд дараах нэгтгэсэн санал зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Санхүүгийн түрээсийн гэрээний зохицуулалтын хүрээнд санхүүгийн санхүүжилтийн болон борлуулалтын лизингийн онцлогийг харгалзан, тэдгээрийн онцлогт нийцүүлэн гэрээний зохицуулалтыг боловсронгуй болгох.
- Франчайзын гэрээний зохицуулалтын хүрээнд гэрээний байгуулахын өмнөх шатанд мэдээллээр хангах үүргийг нэмэлтээр зохицуулах.
- Илгээмжийн гэрээний бүлэг зохицуулалтыг нэр томъёоны хувьд тээвэр зуучийн гэрээ болгон өөрчилж, оновчтой болгох.
- Зээлийн гэрээ цуцалсан тохиолдолд хүү, нэмэгдүүлсэн хүүг үргэлжлүүлэн төлөх эсэх зохицуулалтыг тодорхой болгох.

VII. АРИЛЖААНЫ ХУУЛЬД ТУСГАВАЛ ЗОХИХ ШИНЭ ГЭРЭЭНИЙ ТӨРЛҮҮД

Энэхүү үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баримтлан Арилжааны ерөнхий хуулийн анхдагч хуулийн төсөлд орхигдуулсан арилжааны хэлцэл бий эсэхэд судалгаа хийж, тодорхойлоход оршино.

Төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

7.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох

1. Харилцан уялдаа

Хуулийн төслийн тусгай анги буюу “арилжааны хэлцэл” хэсэгт үр нөлөөний үнэлгээг тооцохдоо “Харилцан уялдаа” бүхий шалгуур үзүүлэлтийг дараах шалтгаанаар сонгов. Тус төсөлд арилжааны хэлцэл гэж арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаанд хамаарах бүхий л хэлцлийг ойлгохоор заасан тул анхдагч хуулийн төсөлд нэмэлтээр тусгавал зохих, практик ач холбогдолтой арилжааны гэрээний шинэ төрлийг гадаадын зарим улс орнуудын ижил төсөөтэй зорилго зорилт бүхий хуулиудтай харьцуулан судалж үзэх нь зүйтэй.

7.2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох

Засгийн газрын дээрх тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тус хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл тул хоёрдугаар хэсэг болох арилжааны хэлцэл хэсгийг бүхэлд нь хамруулж шалгах болно.

7.3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” хэрэгслийн хүрээнд хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалт буюу арилжааны хуулийн төсөлд шинээр тусгавал зохих,

Монгол улсын бизнес эрх зүйн орчинд практик ач холбогдолтой байж болох арилжааны гэрээний төрлүүдийг авч үзэх болно. Тодруулбал, Эх газрын эрх зүйн бүлд хамаарах бие даасан Арилжааны хуультай ХБНГУ, Япон, Вьетнам, Макао улсуудын зохицуулалтыг харьцуулан судалж, үүний үндсэн дээр шинэ арилжааны гэрээний төрлүүд, тэдгээрийн тусгай зохицуулалтыг санал болгохыг зорьж байна.

Арилжааны хуулийн эрх зүйн зохицуулалт, хэрэглээ талаас олон жилийн туршлагатай 1897 оны ХБНГУ болон 1899 оны Япон улсын төрөлжсөн Арилжааны хуулийг харьцуулан судалснаар манай улсын хууль эрх зүйн орчин дахь зарим гэрээний төрлийн хэрэгцээ, шаардлагыг илрүүлж, эдийн засгийн бодитой үр дүн үзүүлж байгаа хэм хэмжээнээс туршлага судалж, авч хэрэглэх давуу талтай.

Түүнчлэн арилжааны эрх зүйн тусгайлсан хууль тогтоомжийн сүүлийн үеийн төлөөлөл болж байгаа 1999 оны Макаогийн Арилжааны хууль, 2005 оны Вьетнамын Арилжааны хууль нь манай улсын адил эдийн засгийн өсөлт, гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын худалдааг дэмжих хууль эрх зүйн тогтолцоог хөгжүүлэхэд чиглэж байгаа тул нь эдгээр улсуудын төсөөтэй байдлыг харгалзах нь зүйтэй.

Дээрх улсуудын Арилжааны хуульд хуульчлан тогтоосон гэрээний төрлүүдээс одоогийн хуулийн төсөлд байхгүй гэрээний төрлүүдийг дурдвал:

- ХБНГУ болон Японд аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд далд хамтран ажиллах (undisclosed partnership) гэрээний хэлбэрийг хуульчилсан байна.⁷²
- Вьетнамын Арилжааны хууль нь арилжааны үйл ажиллагааны олон төрөл хэлбэрээр хөгжиж байгаагийн тод илрэл бөгөөд Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх (sales promotion) гэрээ, Зар сурталчилгааны гэрээ, Худалдааны үзэсгэлэн гаргах гэрээ, Дуудлага худалдааны гэрээ, Франчайзын гэрээний зохицуулалтыг хуульчилж өгснөөрөө ХБНГУ, Японы Арилжааны хуулиас шинэлэг байна.⁷³
- Макаогийн Арилжааны хууль нь банк санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах банкны үйл ажиллагааны гэрээний төрөл болон түүний зохицуулалтыг тусгаж өгснөөрөө шинэлэг ба үүнд, банканд баталгаат хайрцаг түрээслэх гэрээ, кредит үйлчилгээний гэрээ, факторингийн гэрээ, лизингийн гэрээний зохицуулалтыг хуульчилж өгсөн байна.⁷⁴

Эдгээр гэрээний төрлүүдийг банк, санхүүгийн болон бусад холбогдох салбарын эрх зүйн актуудаар ихэвчлэн зохицуулсан байдаг. Харин хамтран ажиллах гэрээний тусгай хэлбэр байдлаар ХБНГУ, Япон улсын Арилжааны хуульд тусгагдсан Далд хамтран ажиллах гэрээ, Вьетнам улсын Арилжааны хууль дахь Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх гэрээ, Макао улсын Итгэлцлийн хууль дахь Хөрөнгө итгэмжлэх гэрээний төрлүүд нь Монгол Улсын арилжааны харилцаанд чухал ач холбогдолтой байж болно. Иймд одоогийн хуулийн төслөөр зохицуулж өгснөөр арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд эерэг нөлөөлөл үзүүлэх, хууль эрх зүйн тодорхой, оновчтой байдлыг бий болгох боломжтой эсэхийг жишээ тохиолдлууд дээр суурилан ач холбогдол, үр нөлөөг тодорхойлох болно.

⁷² Н.Норовсамбуу, Г.Давааням, Ж.Содномдаржаа. Иргэний хуулийн III хэсэг /Гэрээний эрх зүй/-т заасан арилжааны гэрээний төрлүүдийн судалгаа. 2019, 114 дэх тал.

⁷³ Мөн тэнд. 14 дэх тал.

⁷⁴ Мөн тэнд. 83 дахь тал.

Далд хамтран ажиллах гэрээ

Хамтран ажиллах гэрээг түүний шинжээр нь 1) ерөнхий зохицуулалт бүхий хамтран ажиллах гэрээ, 2) тусгай зохицуулалт бүхий хамтран ажиллах гэрээ хэмээн ангилж болно. Арилжааны хуулийн төсөл дэх хамтран ажиллах гэрээ нь ерөнхий зохицуулалт бүхий гэрээний шинжийг агуулж байна.⁷⁵ Гэвч зарим орны Арилжааны хуульд хамтран ажиллах гэрээний тусгай хэлбэрийг тусгажээ. Тухайлбал, ХБНГУ болон Японд аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд далд хамтран ажиллах гэрээний хэлбэрийг хуульчилсан байдаг. Энэхүү далд хамтран ажиллах гэрээний хэлбэр нь хамтран ажиллах гэрээний Арилжааны хууль дахь тусгай зохицуулалт хэмээн ойлгож болох бөгөөд Монгол улсын хувьд Арилжааны хуулийн хүрээнд дээрх тусгай зохицуулалтыг хуульчлан тогтоох боломжтой.⁷⁶

Далд хамтран ажиллах харилцааг Герман улсын Арилжааны хуулийн §230-237 дээр зохицуулсан байдаг ба далд хамтран ажиллах гэрээ (stille Gesellschaft) нь бусад этгээдийн бизнесийн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах, тухайн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааны улмаас бий болох ашгаас далд хамтран ажиллах гишүүндээ жил бүр ашиг хуваарилахаар тохиролцсон байдаг (Арилжааны хуулийн 232(1) хэсэг). Арилжааны үйл ажиллагааг удирдах эрх нь зөвхөн арилжаа эрхлэгчид хадгалагдах ба тус хуулийн 233 зүйлд зааснаар далд хамтран ажиллах гишүүн нь зөвхөн мэдээлэл авах хязгаарлагдмал эрхтэй. Хэрэв өөрөөр тохиролцоогүй бол далд хамтран ажиллах гишүүн нь үйл ажиллагааны ашиг, түүний алдагдалд оролцох ёстой.⁷⁷

Япон улсын Арилжааны хуулийн §535-542 дээр дээрх харилцаа нь зохицуулагдсан байдаг. Орчин үеийн Японы бизнест далд хамтран ажиллах харилцаа нь уян хатан зохицуулалттай, татварын хөнгөлөлттэй тул чухал үүрэг бүхий хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тооцогддог ба гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах ашиг тустай юм. Япон дахь далд хамтын ажиллагаанд далд хамтран ажиллах гишүүн (tokumei kumiai-in) болон өмчлөгч (eigū-sha) оролцдог. Далд хамтран ажиллах гишүүн нь өмчлөгчийн бизнест хөрөнгө оруулж, ашгаас нь хувь хүртдэг боловч ерөнхийдөө гуравдагч этгээдийн нэхэмжлэлд хариуцлага хүлээхгүй.⁷⁸ Далд хамтран ажиллах гэрээний зохицуулалтыг тодорхойлж хуульчилснаар ихээхэн ач холбогдолтой болохыг тодорхой тохиолдлыг жишээ болгон орууллаа.

Япон улсын Арилжааны хууль болон далд хамтран ажиллах гэрээтэй холбогдолтой нэгэн томоохон тохиолдол байдаг. 2007 онд Токиогийн дээд шүүхээс дараах хэргийг хэлэлцэж, тус корпорацын талд шийдвэр гаргасан.⁷⁹

Энэ маргаан нь Японы Үндэсний Татварын Агентлаг болон АНУ-ын үндэстэн дамнасан корпорац хоорондын маргаантай холбоотой. Тус корпорац нь Японы охин компани болон Голландын охин компанитайгаа далд хамтран ажиллах гэрээ байгуулсан боловч үүнийг тус татварын агентлаг ердийн хамтран ажиллах харилцаа байна гэж үзэж, тус корпорацад илүү их татварын дарамт учруулсан. Гэвч шүүх далд хамтран ажиллах гэрээг хууль ёсны гэж хүлээн зөвшөөрч, татварын агентлагийн актыг хүчингүй болгосон.

⁷⁵ Мөн тэнд. 18 дахь тал.

⁷⁶ Мөн тэнд. 114 дэх тал.

⁷⁷ Wooldridge, Frank. "The German Limited and Silent Partnerships." *Amicus Curiae*, no. 80 (Winter 2009) p. 31.

⁷⁸ Arnold, Martin. "Silent Partnership in Japan and Germany." *ZJapanR / J.Japan.L.*, (2002) p. 210, 211.

⁷⁹ <https://www.internationaltaxreview.com/article/2a69vjm1mfqgnnty8vs3k/tokyo-high-court-judgment-on-tokumei-kumiai>

Далд хамтран ажиллах гэрээтэй холбоотой татварын хөнгөлөлтийг баталгаажуулсан тул энэ хэрэг чухал ач холбогдолтой гэж үздэг.

Энэхүү тохиолдол нь арилжааны эрх зүйн зарчим, далд хамтран ажиллах гэрээний зохицуулалт нь маргаан бүхий тохиолдлыг хэрхэн шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг харуулж байгаа юм.

Монгол улсын шүүхийн практикт хэдийгээр маргаан бүхий харилцаа нь далд хамтран ажиллах гэрээний онцлог шинжийг агуулж байвч Иргэний хуулийн §476 зүйлд зохицуулсан ерөнхий зохицуулалт бүхий хамтран ажиллах гэрээний зохицуулалтыг хэрэглэж байгаа учир практикт тус тохиолдлыг шийдвэрлэхэд тал бүрээс нь үнэлж, дүгнэж чадахгүй байна. Жишээлбэл, Монгол улсын уул уурхайн салбарт компанийн үйл ажиллагаанд нь оролцож, шийдвэр гаргах эрх эдлэхгүйгээр зөвхөн тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг бизнест нь оруулж, үйл ажиллагааны ашгаас нь хувь хүртэх тохиролцоо ихээхэн ажиглагддаг ба Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг нэр бүхий алтны уурхайн компанид 1,500,000 ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсэн харилцан тохиролцоо бүхий маргааныг анхан болон давж заалдах шүүхийн шатанд хэлцэл хүчин төгөлдөр эсэх, шилжүүлсэн гүйлгээг компанийн үйл ажиллагаанд зориулсан эсэхийг тогтоож үүнд үндэслэн шийдвэрлэсэн байна.⁸⁰ Хэрэв далд хамтран ажиллах харилцааг тодорхойлж, түүний зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд тусгах тохиолдолд өмнө дурдсанчлан далд хамтран ажиллах гишүүн нь үйл ажиллагааны ашиг, түүний алдагдлыг хариуцах тул үүнтэй төсөөтэй харилцаа мөн түүнээс үүдэлтэй маргаанд хөрөнгө оруулсан компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд үндэслэн ашиг, алдагдлын байдлыг харгалзан үзэж, нэхэмжлэлийн үнийн дүн өөрчлөгдөх зэрэг бизнесийн суурь зарчимд нийцсэн эрх зүйн ач холбогдолтой байна.

Үүнээс дүгнэхэд, далд хамтран ажиллах гэрээ нь арилжаа эрхлэгч өөрийн менежментийн эрхээ хадгалан хөрөнгө босгох, хөрөнгө оруулагчдын хувьд үйл ажиллагаанд оролцох шаардлагагүйгээр ашиг хүртэх боломжуудыг нээн тухайн улсын эдийн засагт ихээхэн эерэг нөлөө үзүүлэх боломжтой байна. Арилжааны хуулийн төсөлд далд хамтран ажиллах гэрээний зохицуулалтыг тусгаснаар дээр дурдсан боломжийг ашиглах хууль эрх зүйн орчныг гэрээний талуудад бий болгоно.

Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх гэрээ

Вьетнам улсын Арилжааны хуулийн⁸¹ §88-101 заалтуудад бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх гэрээ нь зохицуулагдсан байна. Ингэснээр хууран мэхлэх болон шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх замаар хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, итгэлийг нэмэгдүүлэх, нөгөөтээгүүр шударга өрсөлдөөнийг дэмжих зах зээлийн тогтвортой орчныг хангадаг.⁸² Зар сурталчилгааны гэрээнээс ялгаатай тал нь хөнгөлөлт, бэлэг, дээж, шалгаруулалт уралдаан гэх мэт урамшууллын төрлүүдийг санал болгож, борлуулалтыг богино буюу тодорхой хугацаанд дэмжих зорилготой.

⁸⁰ Шүүхийн шийдвэрийн цахим сан дахь Анхан болон Давж заалдах шатны шүүхийн шийдвэр, https://shuukh.mn/single_case/134927?daterange=2024-01-01%20-%202024-06-10&id=1&court_cat=1&bb=1, https://shuukh.mn/single_case/30067?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1

⁸¹ Вьетнамын Худалдааны хуулийн англи хэл дээрх орчуулга, <https://vietnamlawenglish.blogspot.com/2005/06/vietnam-commercial-law-2005-law.html>

⁸² Nguyen, Vinh Quoc, and Kien Trung Trinh. PLC Doing Business in Vietnam. Practical Law Company, 2018.

Монгол улсын бизнесийн салбарт цахим орчин, нийгмийн сүлжээ ашиглан борлуулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа улам бүр нэмэгдэж байгаа нь Арилжааны хуулийн төслийн хүрээнд зохицуулалт хийх шаардлагыг тодорхойлж байна. Тодруулбал, Монгол Улсад 2023 оны нэгдүгээр сарын байдлаар 2,5 сая сошиал медиа хэрэглэгчид бүртгэгдсэн байдаг⁸³ тул зах зээлийн хэрэгцээ шаардлага тэлж буйг харуулж байна. Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх гэрээний хуулийн зохицуулалтыг Вьетнам улсын Арилжааны хуулиас жишиг болгон авч үзвэл хөнгөлөлт, бэлэг, дээж, шалгаруулалт уралдаан гэх мэт борлуулалт нэмэгдүүлэх зөвшөөрөгдөх урамшууллын төрлүүдийг тодорхойлох; бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих үйл ажиллагааг хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалан, үнэн зөв, бодит мэдээллийг өгөх, онцгой нөхцөл, болзлыг хэрэглэгчдэд хангалттай тодорхой хүргэх; шударга бус өрсөлдөөний үйлдлээс урьдчилан сэргийлж, бүх арилжаа эрхлэгчдэд тэгш өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх талаар энэхүү гэрээний талуудын эрх, үүрэг, хязгаарлалтыг нарийвчлан тусгаж өгөх юм.

Бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг Арилжааны хуульд тусгаж үнэн зөв, ил тод байдлыг баталгаажуулан гэрээний талуудын эрх, үүргийг тодорхойлох хэрэгцээ шаардлага тулгарч байгаа тул шинэ хуулийн төсөлд Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх гэрээний зохицуулалтыг тусгах саналтай байна.

Хөрөнгө итгэмжлэх арилжааны гэрээ

Монгол улсын Иргэний хуулийн §406 зүйлд тусгасан хөрөнгө итгэмжлэх гэрээний зохицуулалт нь иргэн хооронд эд хөрөнгө итгэмжлэн шилжүүлэхэд үүсэх харилцааг зохицуулахад илүү тохиромжтой. Тухайлбал, хөрөнгө итгэмжлэх гэрээнд тохиролцоогүй тохиолдолд итгэмжлэгдсэн өмчлөгч нь хөлс, төлбөр шаардах эрхгүй⁸⁴ байхаар тусгажээ. Харин арилжаа эрхлэгчдийн хооронд хөрөнгө итгэмжлэх үйлдэл нь бизнесийн олон талын ач холбогдолтой ба гаднын улсуудын жишгээс итгэлцэл дээр үндэслэн идэвхгүй байгаа хөрөнгийг эргэлтэд оруулах, мэргэшсэн байгууллага хөрөнгийг итгэмжлэн удирдаж, үнэгүйдэл, эрсдэлийг бууруулах, өмчийн эзэн ашиг хүртэх нөхцөлүүд нь хөрөнгө оруулалтын чухал хэрэгсэл болдог. Англи, АНУ зэрэг нийтийн эрх зүйн бүлийн нэлээдгүй улс орнууд хөрөнгө итгэмжлэх харилцааг Итгэлцлийн хуулиар тусгайлан зохицуулж өндөр ач холбогдол өгдөг. Түүнчлэн эх газрын эрх зүйн бүлийн зарим улс орнууд мөн Итгэлцлийн тусдаа хууль баталсан байдаг ба энэхүү хуулиар хөрөнгө итгэмжлэн удирдах харилцааг зохицуулдаг байна. Үүнээс олон улсын стандартын дагуу итгэмжлэгдсэн өмчлөгчийн итгэлцлийн үүрэг, итгэмжлэгчийн хамгаалалтыг чухалчилдаг Япон, Макао улсын Итгэлцлийн хуулийн зохицуулалтаас туршлага судлахаар сонгож авлаа.

Макаогийн Итгэлцлийн хуулийн дагуу итгэмжлэгч болон итгэмжлэгдсэн өмчлөгч хоорондын харилцаа, эрх хэмжээний тэнцвэртэй байдал, итгэмжилсэн хөрөнгийг итгэмжлэгдсэн өмчлөгчийн өөрийн хөрөнгөөс нь тусгаарлахад анхаардаг. Итгэмжилсэн хөрөнгийг тусгаарлах нь ялангуяа итгэмжлэгдсэн өмчлөгч нь дампууралтай тулгарах үед итгэмжлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах ач холбогдолтой.⁸⁵

⁸³ <https://datareportal.com/reports/digital-2023-mongolia>

⁸⁴ Монгол улсын Иргэний хуулийн 406.5 дахь заалт.

⁸⁵ Jing, Hui. 2022. "Trust Law in Macao: An Organisational Law Account." European Business Organization Law Review. Accessed June 14, 2024. <https://ssrn.com/abstract=4391225>.

Харин Япон улсын Итгэлцлийн хуулийн онцлог шинж нь жижиг хэмжээний хөрөнгө оруулагчдад хүртээмжтэй байдал юм.⁸⁶ Хөрөнгө итгэмжлэх гэрээний дагуу хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд нь харьцангуй жижиг хөрөнгө оруулагчдад мэргэжлийн удирдлагын дор төрөлжсөн хөрөнгө оруулалтын багцыг санал болгодог тул өнөөгийн Монгол улсын хөрөнгийн зах зээлийн зорилго, чиглэлтэй төсөөтэй.

Монгол улсын хууль, эрх зүйн орчинд Хөрөнгө оруулалтын менежментийн компани, Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам, Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам зэрэг эрх зүйн баримт бичгүүдээр нарийвчлан зохицуулж байна. Гэвч хөрөнгө итгэмжлэн удирдах харилцааг одоогийн Арилжааны хуулийн төсөлд түүний зорилго, зарчимд нийцүүлэн тусгаж өгөх шаардлагатай гэж үзэж байна. Учир нь дээр авч үзсэнчлэн Иргэний хууль дахь хөрөнгө итгэмжлэх гэрээ нь хувь хүмүүс хоорондын туслалцаа үзүүлэхтэй холбоотой харилцаанд тохирсон тул хөрөнгө оруулалтын харилцааны оролцогч талуудын хэлцэл, гэрээний агуулгыг төрөлжсөн хуульд нэгдсэн байдлаар тодорхойлж, Арилжааны хуулийн зохицуулах хүрээнд хамруулах нь зүйтэй.

7.4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

Дүгнэлт

ХБНГУ, Япон, Вьетнам, Макао улсуудын бие даасан Арилжааны хууль, Итгэлцлийн хуулийн зохицуулалтыг харьцуулан судалж, үүний үндсэн дээр Далд хамтран ажиллах гэрээ, Бараа бүтээгдэхүүн борлуулалт нэмэгдүүлэх гэрээ, Хөрөнгө итгэмжлэх арилжааны гэрээ, тэдгээрийн зохицуулалтын ач холбогдол, үр нөлөөг тодорхойллоо. Иймд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмж

1. Хуулийн төсөлд доорх байдлаар нэмэлт оруулах саналтай: Далд хамтран ажиллах гэрээ

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ДАЛД ХАМТРАН АЖИЛЛАХ

137 дугаар зүйл. Далд хамтран ажиллах гэрээ⁸⁷

137.1. Далд хамтран ажиллах гэрээ нь гэрээний нэг тал нөгөө талын аж ахуйн үйл ажиллагаанд хөрөнгө оруулж, тухайн аж ахуйн үйл ажиллагааны улмаас бий болох ашгийг хуваах талаар тохиролцсоноор байгуулагдсанд тооцогдоно.

⁸⁶ Tamaruya, Masayuki. "The Transformation of Japanese Trust Law and Practice: Historical Contexts and Future Challenges." University of Tokyo Business Law Working Paper Series No. 2021-E-02, May 2021.

⁸⁷ **Гэрээний нэршлийн хувьд**

Герман: stille Gesellschaft

Франц: société en participation

Англи: undisclosed partnership or silent partnership

Япон: 匿名組合

138 дугаар зүйл. Далд хамтран ажиллах гишүүний оруулах хөрөнгө

138.1.Далд хамтран ажиллах гишүүний оруулсан хөрөнгө нь аж ахуй эрхлэгчийн хөрөнгөд хамаарна.

138.2.Далд хамтран ажиллах гишүүний оруулах хөрөнгө нь мөнгө болон бусад төрлийн хөрөнгө байж болно.

139 дугаар зүйл. Далд хамтран ажиллах гишүүний эрх, үүрэг

139.1.Далд хамтран ажиллах гишүүн нь аж ахуйн үйл ажиллагааг удирдах, аж ахуй эрхлэгчийг төлөөлөх эрхгүй байна.

139.2.Далд хамтран ажиллах гишүүн нь аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гуравдагч этгээдийн өмнө эрх эдэлж, үүрэг хүлээхгүй.

140 дугаар зүйл. Өөрийн нэрийг ашиглахыг зөвшөөрсөн далд хамтран ажиллах гишүүний хариуцлага

140.1.Далд хамтран ажиллах гишүүн нь өөрийн нэрийг аж ахуй эрхлэгчийн арилжааны нэрийн хэсэг болгон оруулах эсхүл өөрийн арилжааны нэрийг аж ахуй эрхлэгчийн арилжааны нэр болгож ашиглахыг зөвшөөрсөн тохиолдолд тухайн нэрийг ашиглаж эхэлснээс хойших үүрэгт аж ахуй эрхлэгчтэй хамтран хариуцлага хүлээнэ.

141 дугаар зүйл. Ашиг хуваарилахад тавих хязгаарлалт

141.1.Оруулсан хөрөнгө нь алдагдлын улмаас багассан бол тухайн алдагдлыг нөхөж олоогүй тохиолдолд далд хамтран ажиллах гишүүн нь ашиг хуваарилахыг шаардах эрхгүй.

142 дугаар зүйл. Танилцаж, хуулбарыг авах эрх

142.1.Далд хамтран ажиллах гишүүн нь санхүүгийн жил дууссаны дараа дараах баримт бичиг, тайлантай танилцаж, хуулбарлан авч болно:

142.1.1.Хувиараа аж ахуй эрхлэгч бол бичгэн болон цахим хэлбэрээр хөтөлсөн журнал;

142.1.2.Хуулийн этгээд бол Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь хэсэгт заасан санхүүгийн тайлан.

143 дугаар зүйл. Шалгах эрх

143.1.Далд хамтран ажиллах гишүүн нь шаардлагатай тохиолдолд шүүхийн зөвшөөрлийн үндсэн дээр аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаа, хөрөнгийн байдлыг шалгаж болно.

143.2.Энэ хуулийн 143.1-т заасан зөвшөөрлийг олгох эсэхийг аж ахуй эрхлэгч оршин байгаа газрын анхан шатны шүүх харьяалан шийдвэрлэнэ.

144 дугаар зүйл. Далд хамтран ажиллах гэрээг цуцлах

144.1.Далд хамтран ажиллах гэрээнд гэрээний хугацааг тогтоогоогүй эсхүл бүх насаараа хамтран ажиллахаар гэрээ байгуулсан бол талууд санхүүгийн жил дуусах үед

гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй. Гэвч 6 сарын өмнө урьдчилан мэдэгдэх үүргийг хүлээнэ.

144.2.Далд хамтран ажиллах гэрээний хугацааг тогтоосон эсэхээс үл хамааран зайлшгүй нөхцөл байдлын улмаас гэрээний талууд хэдийд ч гэрээг цуцалж болно.

145 дугаар зүйл. Далд хамтран ажиллах гэрээг дуусгавар болгох нөхцөл

145.1.Далд хамтран ажиллах гэрээ нь дараах нөхцөлийн улмаас дуусгавар болно:

145.1.1.далд хамтран ажиллах гэрээний хүрээнд зорьсон үйл ажиллагаа амжилттай болсон эсхүл амжилтгүй болсон

145.1.2.аж ахуй эрхлэгч нас барсан эсхүл харгалзан дэмжигч тогтоогдсон

145.1.3.аж ахуй эрхлэгч эсхүл далд хамтран ажиллах гишүүнд дамбуурлын хэрэг үүссэн

146 дугаар зүйл. Оруулсан хөрөнгөө буцаан авах

146.1.Далд хамтран ажиллах гэрээ дуусгавар болсон тохиолдолд аж ахуй эрхлэгч нь далд хамтран ажиллах гишүүнд оруулсан хөрөнгийг буцаан олгох үүрэг хүлээнэ. Гэвч оруулсан хөрөнгө нь алдагдлын улсаас багассан бол үлдэгдэл хөрөнгийг буцаан олгоно.

2. Хуулийн төсөлд доорх байдлаар нэмэлт оруулах саналтай: Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх гэрээ

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ НЭМЭГДҮҮЛЭХ

67 дугаар зүйл. Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх гэрээ

67.1.Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх гэрээгээр арилжаа эрхлэгч нь хэрэглэгчид давуу тал олгох замаар бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нэмэгдүүлэх зорилгоор борлуулалт дэмжигчтэй хамтран ажиллана.

67.2.Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх гэрээг бичгээр эсхүл хуульд заасны дагуу цахим хэлбэрээр хийнэ.

67.3. Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх арилжаа эрхлэгч нь дараах эрх, үүрэгтэй:

67.3.1.Борлуулалт нэмэгдүүлэх үйл ажиллагааны хэлбэр, хугацаа, газар, зохион байгуулах журам, борлуулалтыг нэмэгдүүлэхэд ашиглах бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, хямдралын хувь хэмжээг тодорхойлох;

67.3.2.Борлуулалт нэмэгдүүлэх үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллийг борлуулалт дэмжигчид өгөх;

67.3.3.Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх үйл ажиллагааг нийтэд зарласан арилжаа эрхлэгч нь зарласан ёсоор хэрэглэгчдийн өмнө үүрэг хүлээх буюу борлуулалт дэмжигчийн үйл ажиллагаанд хяналт тавих;

67.3.4.ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг арилжаа эрхлэгч эсхүл өрсөлдөгч этгээдийн талаар эерэг болон сөрөг мэдээллийг өгөхөөс зайлсхийх;

67.4. Борлуулалт дэмжигч нь дараах эрх, үүрэгтэй:

67.4.1.Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдсэн эсэхээс үл хамааран гэрээгээр тохиролцсон хөлсийг шаардах;

67.4.2.Арилжаа эрхлэгчээс борлуулалт нэмэгдүүлэх бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар өгсөн мэдээлэлд үндэслэн үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллийг олон нийт буюу хэрэглэгчид мэдээлэх;

67.4.3.Борлуулалт дэмжигч нь борлуулалт нэмэгдүүлэх үйл ажиллагааг хөлс, төлбөр авсан эсэхээс үл хамааран арилжаа эрхлэгчийн захиалгаар явуулж байгааг ил тод мэдээлэх, байршуулах;

67.4.4.Борлуулалт дэмжигч нь бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх үйл ажиллагааг шударгаар гүйцэтгэх;

67.4.5.Арилжаа эрхлэгчээс бусад гуравдагч этгээдийн талаар эерэг болон сөрөг мэдээллийг дурдахаас зайлсхийх;

67.4.6.Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх гэрээгээр харилцан тохиролцож тогтоосон үйл ажиллагаа зохион байгуулах журмыг дагаж мөрдөх.

67.5.Талууд гэрээ байгуулахдаа шаардлагатай бүхий л мэдээллийг шударгаар харилцан солилцох, гэрээ байгуулагдахгүй тохиолдолд мэдээллийн нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

68 дугаар зүйл. Бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдүүлэх үйл ажиллагааны хэлбэр

68.1.Борлуулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа нь дараах хэлбэртэй байна:

68.1.1.бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний дээжийг үнэ төлбөргүй санал болгох;

68.1.2.бэлэг санал болгох эсвэл үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх;

68.1.3.урамшууллын хугацаанд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хямдралтай борлуулах;

68.1.4.эрхийн бичиг буюу купон санал болгох;

68.1.5.шагнал буюу урамшуулалтай уралдаан зохион байгуулах;

68.1.6.азын тоглоом зохион байгуулах;

68.1.7.борлуулалтыг дэмжих зорилгоор хэрэглэгчид зориулсан бусад арга хэмжээ зохион байгуулах;

68.1.8.хуулиар тогтоосон бусад хэлбэр.

69 дүгээр зүйл. Борлуулалт нэмэгдүүлэх бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ

69.1.Борлуулалт нэмэгдүүлэхэд ашиглагдаж буй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хуулиар хориглоогүй, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээ, олон улсын худалдааны практикт хүлээн зөвшөөрөгдсөн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ байна.

69.2.Арилжаа эрхлэгч нь борлуулалт нэмэгдүүлэх үйл ажиллагааны хэлбэр, хугацаа, газар, зохион байгуулах журам, бараа бүтээгдэхүүн, хямдралын хувь хэмжээг харилцан тохиролцож тогтооно.

3. Хуулийн төсөлд доорх байдлаар нэмэлт оруулах саналтай: Хөрөнгө итгэмжлэх арилжааны гэрээ

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

АРИЛЖААНЫ ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭХ

70 дугаар зүйл. Хөрөнгө итгэмжлэх арилжааны гэрээ

70.1. Арилжааны хөрөнгө итгэмжлэх гэрээгээр итгэмжлэгч нь хөдлөх эд хөрөнгө буюу эрхийг итгэмжлэгдсэн өмчлөгчид шилжүүлэх, итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг хүлээн авч итгэмжлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн, үнэнч шударгаар захиран зарцуулах үүрэг тус тус хүлээнэ.

70.2. Хөрөнгө итгэмжлэх гэрээг бичгээр эсхүл хуульд заасны дагуу цахим хэлбэрээр хийнэ.

70.3. Итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг өөрийн нэрийн өмнөөс, итгэмжлэгчийн зардал, эрсдэлээр захиран зарцуулах үүрэгтэй.

70.4. Итгэмжлэгдсэн өмчлөгч нь өөрийн хөрөнгө болон итгэмжилсэн хөрөнгийг тусгаарлах үүрэгтэй.

70.5. Итгэмжлэгдсэн өмчлөгч гуравдагч этгээдтэй харилцаанд орохдоо өмчлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж, үр дагаврыг нь хариуцах бөгөөд итгэмжлэгчийн ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулсны улмаас түүнд учирсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлөх үүрэгтэй.

70.6. Итгэмжлэгдсэн өмчлөгч итгэмжилсэн хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагаа явуулсны төлөө итгэмжлэгчээс хөлс авах эрхтэй.

70.7. Итгэмжлэгч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд итгэмжилсэн хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааны хөлсний хэмжээ, хөрөнгө итгэмжлэх хугацааг гэрээнд зааснаас өөрчлөх эрхтэй.

70.8. Итгэмжилсэн хөрөнгөөс олсон орлого, үр шимийг гэрээгээр тохирсон нөхцөлөөр итгэмжлэгч өмчилнө.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж

1. Иргэний хууль (2002)
2. Хууль тогтоомжийн тухай хууль (2015)
3. ХБНГУ-ын Арилжааны хууль
4. Япон Улсын Арилжааны хууль
5. 2001 оны Худалдааны нэгдсэн хууль (UCC)
6. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт
7. Монгол Улсын Дээд шүүхийн 2016 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 3 дугаар зөвлөмж “Гэрээний зарим эрх зүйн маргааныг хууль хэрэглээ болон гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахад анхаарах асуудлууд”, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12295>
8. Uniform Law Commission. "Uniform Commercial Code (UCC)
9. United Nations Convention on Contracts for the International Sale of Goods (CISG)
10. Common European Sales Law
11. Вьетнамын Худалдааны хуулийн англи хэл дээрх орчуулга, <https://vietnamlawenglish.blogspot.com/2005/06/vietnam-commercial-law-2005-law.html>
12. International Institute for the Unification of Private Law, Model Franchise Disclosure Law (2002), <https://www.unidroit.org/instruments/franchising/model-law/>
13. People's Republic of China, Administrative Measures for Commercial Franchise Information Disclosure (2012 Revision), <http://www.lawinfochina.com/display.aspx?lib=law&id=10932&EncodingName=big5#>

Шүүхийн шийдвэр

14. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 181/ШШ2018/00986 дугаар шийдвэр, https://shuukh.mn/single_case/76128?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1
15. Шүүхийн шийдвэрийн цахим сан дахь Анхан болон Давж заалдах шатны шүүхийн шийдвэр, https://shuukh.mn/single_case/134927?daterange=2024-01-01%20-%202024-06-10&id=1&court_cat=1&bb=1, https://shuukh.mn/single_case/30067?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1
16. Higher Cantonal Court du Valais (Fiberglass composite materials case), Switzerland 28 January 2009, available at <http://cisgw3.law.pace.edu/cases/090128s1.html>
17. Marc Rich & Co v Iritechna SpA Appellate Court Geneva, Italy 24 March 1995, available at <http://cisgw3.law.pace.edu/cases/950324i3.html>
18. St Paul Guardian Insurance Co v Neuromed Medical Systems & Support 2002 WL 465312 (SDNY 2002) US Federal District Court, New York 26 March 2002, CLOUT case no 447, available at <http://cisgw3.law.pace.edu/cases/020326u1.html>
19. China North Chemical Industries Corporation v Beston Chemical Corporation WL 295396 (SD Tex 2006) US Federal District Court, Texas 7 February 2006, available at <http://cisgw3.law.pace.edu/cases/060207u1.html>

20. BP Oil International v Empresa Estatal Petroleos de Ecuador 332 F3d 333 (5th Cir 2003) 338, 200 ALR Fed 771 Federal Appellate Court (5th Circuit) United States 11 June 2003, available at <http://cisgw3.law.pace.edu/cases/030611u1.html>

Монгол эх сурвалж

21. Б.Амарсанаа, С.Батбаяр, Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар “Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан” 2019 он.
22. МУИС-ийн ХЗС-ийн харьяа Эдийн засаг, бизнесийн эрх зүйн судалгааны төв “Арилжааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайлан” 2024 он.
23. ХЗДХЯ-ны захиалгаар Н.Норовсамбуу, Г.Давааням, Ж.Содномдаржаа “Гадаад орнуудын арилжааны /худалдаа/-ны тухай хуулиудын харьцуулсан судалгаа” 2019 он.
24. “Ханнс-Зайделийн” сангийн “Эрх зүйн боловсрол академи”-ийн захиалгаар “Өмгөөлөл судлалын академи” ТББ гүйцэтгэсэн “Арилжааны хууль тогтоомжийн зохицуулалтын талаарх бизнес эрхлэгчдийн байр суурь судалгааны тайлан” 2020 он.
25. Р.Мандухай “Санхүүгийн түрээсийн гэрээг зээлээр худалдах-худалдан авах гэрээнээс ялгахад тулгарч буй асуудал болон Санхүүгийн түрээсийн тухай хуулийг шинэчлэх шаардлага” 2022 он, <https://legalddata.mn/buteel/pdf?id=1204>
26. Ж.Оюунтунгалаг “Иргэний эрх зүй II – Гэрээний үүрэг” 2022 он.
27. Б.Оджаргал, “Франчайзын олон улсын гэрээний эрх зүйн зохицуулалт (Магистрын ажил)” 2020 он, <https://legalddata.mn/b/1422>
28. B.Namsrai (Ph.D student at University of Pecs, Hungary) “Mongolian Laws regarding Franchising questions: Critical Thinking on Domestic Statutes” 2023 он, <https://legalddata.mn/buteel/pdf?id=1609>
29. Ханнс Зайделийн Сан “Эрх зүйн боловсрол” академи Б.Буянхишиг “Тээвэр зуучийн гэрээг зохицуулах хууль хэрэглээний асуудал” 2021 он, <https://legalddata.mn/b/1802>
30. Нээлттэй нийгэм форум, Б.Ананд, Л.Анхбаяр, М.Балжинсүрэн “Зээлийн гэрээг цуцалснаас хойш хүү йшаардсан маргааны шүүхийн шийдвэрийн шинжилгээ” 2021 он, <https://legalddata.mn/b/1099>
31. Н.Норовсамбуу, Г.Давааням, Ж.Содномдаржаа “Иргэний хуулийн III хэсэг /Гэрээний эрх зүй/-т заасан арилжааны гэрээний төрлүүдийн судалгаа” 2019 он
32. Э.Байгал “Олон улсын эрх хувийн эрх зүй (баримт бичгийн эмхэтгэл)” 2023 он

Гадаад эх сурвалж

33. Cutler “Private Power and Global Authority: Transnational Merchant Law in the Global Political Economy” 2003 (Cambridge University Press)
34. Gillette “Harmony and stasis in trade usage for international sales” 1999 (39 Virginia Journal of International Law)
35. Bernstein “Merchant law in a modern economy” 2013 (Coase-Sandor Institute for Law and Economics Working Paper No 639, University of Chicago)

36. Schmitthoff, Clive M "The New Sources of the Law of International Trade" 1988 (Chia-Jui Cheng)
37. Michaels, Ralf, "The True Lex Mercatoria: Private Law Beyond the State" 2007 (Indiana Journal of Global Legal Studies, 14)
38. HJ Berman and C Kaufman, "The Law of International Commercial Transactions (Lex Mercatoria)" 1978 (19 Harvard International Law Journal 221)
39. Klaus Peter Berger "The Creeping Codification of the New Lex Mercatoria (2nd revised ed)" 2010 (Kluwer Law 2010)
40. Juana Coetzee "The role and function of trade usage in modern international sales law" 2015 (Unif. L. Rev., Vol. 20)
41. Halsbury's Laws of England, vol 32 (5th edn, Lexis Nexis 2012)
42. Roy Goode "Goode on Commercial Law, edited by Ewan McKendrick (4th revised edn)" 2010 (Penguin Books)
43. Jurgen Basedow "The State's Private Law and the Economy: Commercial Law as an Amalgam of Public and Private Rule-Making" 2008 (American Journal of Comparative Law, 706 for the position in French and German laws)
44. Juana Coetzee "Trade usage: Still law made by merchants for merchants?" 2016
45. Mak, Vanessa "According to Custom...? The Role of 'Trade Usage' in the Proposed Common European Sales Law (CESL)" 2013 (*Tilburg Law School Legal Studies Research Paper* No. 02/2014, TISCO Working Paper Series on Civil Law and Conflict Resolution Systems No. 001/2013, Available at SSRN: <https://ssrn.com/abstract=2364427> or <http://dx.doi.org/10.2139/ssrn.2364427>)
46. Graffi, L "Remarks on Trade Usages And Business Practices In International Sales Law" 2011 (*Journal of Law and Commerce*, vol. 29, no. 2, doi:10.5195/jlc.2011.18)
47. Miklos, Kiraly "The Unification of Contract Law and Commercial Usages" 2022 (*TCLR*, Issue 2, 2022) <https://www.qmul.ac.uk/unidroit-itcl/media/ccls/docs/research/tclr-2-the-unification-of-contract-law-and-commercial-usages.pdf>
48. Ian Ayres & Robert Gertner "*Filling Gaps in Incomplete Contracts: An Economic Theory of Default Rules*" 1989 (99 Yale L. J. 87, 87-94)
49. R. H. Coase "The Problem of Social Cost" 1960 (3 J. L. & Econ 1)
50. Louis Kaplow "Rules Versus Standards: An Economic Analysis" 1992 (42 Duke L. J. 557)
51. Vincy Fon & Francesco Parisi "On the Optimal Specificity of Legal Rules" 2007 (4 George Mason Uni L. & Econ. 10)
52. Jing, Hui "Trust Law in Macao: An Organisational Law Account." 2022 (European Business Organization Law Review) <https://ssrn.com/abstract=4391225>
53. Tamaruya, Masayuki "The Transformation of Japanese Trust Law and Practice: Historical Contexts and Future Challenges" 2021 (University of Tokyo Business Law Working Paper Series No. 2021-E-02)
54. Nguyen, Vinh Quoc, and Kien Trung Trinh "PLC Doing Business in Vietnam. Practical Law Company" 2018
55. International Institute for the Unification of Private Law "Guide to International Master Franchise Agreements – Second Edition" 2007, <https://www.unidroit.org/wp-content/uploads/2021/06/franchising2007-guide-2nd-e.pdf>
56. Wooldridge, Frank "The German Limited and Silent Partnerships" *Amicus Curiae* 2009 (no. 80)

57. Arnold, Martin "Silent Partnership in Japan and Germany." 2002, ZJapanR / J.Japan.L

Цахим эх сурвалж

58. <https://www.uniformlaws.org/acts/ucc>.

59. <https://www.unidroit.org/instruments/franchising/model-law/>

60. <https://www.internationaltaxreview.com/article/2a69vjm1mfgqnnty8vs3k/tokyo-high-court-judgment-on-tokumei-kumiai>

61. <https://datareportal.com/reports/digital-2023-mongolia>

62. Zivilgericht Basel [Civil Court] Switzerland, 3 Dec. 1997, <http://www.cisg.law.pace.edu/cases/971203s2.html>

63. Amtsgericht Duisburg [Petty Court] Germany, 13 Apr. 2000, <http://cisgw3.law.pace.edu/cases/000413g1.html>

64. Oberster Gerichtshof [Supreme Court] Austria, 21 Mar. 2000, <http://www.cisg.law.pace.edu/cases/000321a3.html>

65. Landgericht Saarbrücken [District Court] Germany, 13 Jan. 1992, <http://www.cisg.law.pace.edu/cases/920323g1.html>